

# БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН СТАНДАРТ

ХУВИЛБАР 5.0 | 2025



Conservation  
Measures  
Partnership

# БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН СТАНДАРТЫН ТУХАЙ

Байгаль хамгааллын стандарт 5.0 хувилбар нь Conservation Measures Partnership (CMP), Байгаль хамгааллын сургагч багш нарын сүлжээ (CCNet), болон хамтран ажилладаг талуудын мэдлэг, туршлагад суурилан боловсруулсан байгаль хамгааллын төлөвлөлтийн аргачлал юм. Байгаль хамгааллын стандартын редакторын бүрэн эрхийг CMP хариуцна.

## Conservation Measures Partnership (CMP) гэж юу вэ?

[Conservation Measures Partnership](#) (CMP) нь олон улсын төрийн бус байгууллагууд, төрийн байгууллага, санхүүжүүлэгчид болон хувийн хэвшлийн байгууллагаас бүрдсэн хамтын түншлэл бөгөөд байгаль хамгааллын үйл ажиллагааг төлөвлөх, удирдах, үр дүнг хэмжих чиглэлээр хамтардаг. Байгаль хамгааллын стандартын дагуу CMP-ийн гишүүд мэдлэгээ хуваалцах, сайн туршлагыг нэвтрүүлэх, үр дүнгүй арга барилаас зайлсхийх, үр ашиг, шинэлэг санаачлагыг нэмэгдүүлэх замаар хамтран ажилладаг.

## Гишүүн байгууллагууд (2025):

African Wildlife Foundation; Alcedo Conservation; Bush Heritage Australia; Chester Zoo; Conservation X Labs; Conservation Management; Disney's Animals, Science, and Environment; Durrell Wildlife Conservation Trust; Endangered Wildlife Trust; Environmental Incentives; Foundations of Success; The Gordon and Betty Moore Foundation; International Crane Foundation; Jane Goodall Institute; Keith Campbell Foundation for the Environment;

Kent Wildlife Trust; Lemu; Margaret A. Cargill Foundation; National Fish and Wildlife Foundation; The Nature Conservancy; Nature Conservancy of Canada; NOAA's Coral Reef Conservation Program; The Pew Charitable Trusts; Puget Sound Partnership; Rare; San Diego Zoo Wildlife Alliance; The Summit Foundation; TRAFFIC; US Agency for International Development; US Fish and Wildlife Service; Walton Family Foundation; Wildlife Conservation Network; Wildlife Conservation Society; and World Wide Fund for Nature.

## Шинэчлэл, сайжруулалт:

CMP нь Байгаль хамгааллын стандартын редакторын бүрэн эрхийг эзэмшдэг. Энэ бол CMP-ийн гишүүд тогтмол шинэчилж, сайжруулж байдаг амьд баримт бичиг юм. Шинэчилсэн хувилбарууд, гарын авлага болон нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл CMP-ийн цахим хуудас ([www.conservationmeasures.org](http://www.conservationmeasures.org)) болон Байгаль хамгааллын стандартын вэбсайт ([www.conservationstandards.org](http://www.conservationstandards.org))-д зочлоорой. Энэ аргачлалыг ашиглаж буй хүн бүр санал хүсэлтээ бидэнтэй [CMPIinfo@conservationmeasures.org](mailto:CMPIinfo@conservationmeasures.org) цахим хаягаар хуваалцахад таатай хүлээн авах болно.

## Байгаль хамгааллын стандарт 5.0 –ийн шинэчлэлийн хороо:

5.0 хувилбар нь хамтын ажиллагааны үр дүнд бий болсон бүтээл юм. Байгаль хамгааллын стандартын агуулгыг сайжруулахад 88 гишүүн (хамгийн багадаа 33 байгууллагыг төлөөлсөн) идэвхтэй оролцсон. Үнэтэй цагаа зориулсан, саналаа өгсөн дараахи хүн бүхэнд CMP-ийн зүгээс талархаж байна.Үүнд:

Adrienne Marvin, Amelia Grigson, Anita Diederichsen, Anne Ntongho, Annette Stewart, Ash Baker, Becky Raboy, Becky Stewart, Beth Allgood, Bridget Mattingley, Carol Bogezi, Caroline Stem, Catherine Payne, Charles Latrémouille, Clair Dougherty, Claire Relton, Cristina Eghenter, Danica Schaffer-Smith, Daphne Yin, David Wilkie, Diane Detoef, Eduardo Cuevas, Elizabeth Nelson, Erica Cochrane, Felix Cybulla, Frank Weisenberger, Gayle Burgess, Giselle Block, Heather Barna, Helma Brandmeier, Iain Dickson, Jaclyn Lucas, Joaquin Riesgo, John Morrison, John Waugh, Jon Fisher, Josh Goldstein, Judy Boshoven, Karyne Bellehumeur, Katie Williamson, Kelly Swiech, Kelsey Schueler, Lauriane Besse Streit, Leander Lacy, Li Ying, Llara Kritzner, Lucy Rose, Maggie Lee, Marcia Brown, Mariano de la Maza, Marko Pecarevic, Matrída Simfukwe, Michael Looker, Moritz Spielberg, Nan Zeng, Narangerel Naranpurev, Nathan Karres, Nick Hutcheson, Nick Salafsky, Nick Tealer, Nico Boenisch, Nicole Gross-Camp, Olivia Millard, Paloma Bravo Córdova, Paola Mejía, Pavitray Pillay, Philippa Dyson, Preston Whitt, Quinn Shurtliff, Rachel Martin, Sarah Cotter, Sarah Pearson, Sheila O'Connor, Sophie Hall-Aspland, Stephan Funk, Sujata Ram, Tara Stephens, Terri Schultz, Theany Mout, Tessa Stienen, Tina Jansen van Vuuren, Vanessa Correa, Varsha Suresh, Vinaya Swaminathan, Wessyl Kelly, Will Beale, Xavi Escuté, Yaw Opoku Agyeman, Zeljka Rajovic

Байгаль хамгааллын стандартын хувилбарыг сайжруулахад санал өгсөн CMP-ийн гишүүдэд талархал илэрхийлье.

Байгаль хамгааллын стандарт 5.0 хувилбарыг Б. Мөнхчулуун (WWF-Mongolia), Э. Төгөлдөр (TNC Mongolia), Н. Нарангэрэл (CCNet Mongolia) нар Монгол хэл рүү хөрвүүлэв.

English: The Conservation Standards Version 5.0 was translated into Mongolian by Munkhchuluun.B (WWF-Mongolia), Tuguldur.E (TNC Mongolia), and Narangerel.N (CCNet Mongolia).



Байгаль хамгааллын стандартыг ашиглах: Энэхүү бүтээлийг [Creative Commons Attribution-ShareAlike 4.0 International License](#) дагуу ашиглах лицензтэй. Уг лицензийн дагуу Байгаль хамгааллын стандартыг өөрийн хэрэгцээнд тохируулан өөрчилж болно, хэрэв та а) Байгаль хамгааллын стандартыг иш татсан байх, б) Сайжруулсан бүтээлийг ижил төстэй Creative Commons лиценз эсвэл түүнтэй дүйцэх эрхийн нөхцөлийн дагуу нийтлэнэ. Та мөн CMP-д өөрийн оруулсан өөрчлөлтийг санал болгосноор байгаль хамгааллын стандартын албан ёсны хувилбарт оруулах талаар анхаарах болно. Энэ үйл явц нь Стандартыг мэргэжилтнүүдийн оролцоотойгоор хөгжүүлж, байгууллага бүрийн хэрэгцээнд нийцүүлэх боломжийг олгохын зэрэгцээ, байгаль хамгааллын ажлыг хэрэгжүүлэхэд зориулагдсан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалыг бий болгож өгөх.

# АГУУЛГА

<b>Танилцуулга</b>	<b>01</b>	<b>4. Үр дүнг үнэлэх &amp; уялдуулах</b>	<b>66</b>
Оршил	02	<b>5. Хуваалцах</b>	<b>74</b>
Байгаль хамгааллын стандартын зорилго	03	5A. Баримтжуулах	75
Байгаль хамгааллын стандартын хувьсал	04	5B. Мэдлэгээ хуваалцах	76
Байгаль хамгааллын стандартыг хэрэглэх	05	5C. Суралцах орчинг бүрдүүлэх	77
Байгаль хамгааллын стандарт ба бусад аргачлалуудын уялдаа	06	<b>Төлөвлөлтийн мөчлөгийг зангидах нь</b>	<b>79</b>
Байгаль хамгааллын стандартыг хэрэгжилтийг дэмжих нь	09	<b>Хавсралт</b>	<b>80</b>
Ерөнхий зарчим, анхаарах асуудал	12	Хавсралт 1. Нэр томъёоны тайлбар	81
<b>1. Тодорхойлох</b>	<b>14</b>	Хавсралт 2. Үндсэн нэр томъёоны тодорхойлолт, шалгуур	89
1A. Зорилгоо тодорхойлж, төслийн багаа бүрдүүлэх	15	Хавсралт 3. Ерөнхий зарчим, анхаарах асуудлууд	90
1B. Алсын хараа, хамрах хүрээ, хамгаалах үнэт зүйлийг тодорхойлох	17	Хавсралт 4. Байгаль хамгааллын стандартын алхам, тэдгээрийн хүрээнд гарах үр дүнгийн тойм	93
1C. Аюул, дарамтыг тодорхойлох	23		
1D. Нөхцөл байдлыг тодорхойлох	26		
<b>2. Төлөвлөх</b>	<b>31</b>		
2A. Стратегийн төлөвлөгөө боловсруулах: Зорилго, Арга хэмжээ, Таамаглал, Зорилт	33		
2B. Үнэлгээ, мониторингийн төлөвлөгөө боловсруулах	47		
2C. Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах	53		
<b>3. Хэрэгжүүлэх</b>	<b>55</b>		
3A. Багийн бүтэц, ажлын үйл явцыг эргэн нягтлах	56		
3B. Нарийвчилсан, богино хугацааны ажлын төлөвлөгөө боловсруулах	57		
3C. Төслийн төсвийг боловсруулж, сайжруулах	59		
3D. Төлөвлөгөө хэрэгжүүлэх	62		

# ТАНИЛЦУУЛГА

# ОРШИЛ

Байгаль хамгааллын мэргэжилтнүүд өндөр эрсдэлтэй, томоохон, төвөгтэй, нэн тэргүүний байгаль орчны асуудлуудыг шийдвэрлэхээр ажиллаж байна. Бид урт хугацааны үр нөлөө үзүүлэх асар их боломжтой бөгөөд урам зориг өгөхүйц ахиц дэвшлүүдийг гаргаж чадсан. Гэвч биологийн олон янз байдлын хомсдол, уур амьсгалын өөрчлөлт болон тэгш бус байдал нь хямралыг өдөөдөг бүтэц, тогтолцоог хөндөн биднээс системийн түвшинд хариу арга хэмжээ

2004 онд Байгаль хамгааллын Нээлттэй стандартын<sup>1</sup> (цаашид Байгаль хамгааллын стандарт буюу CS гэж нэрлэнэ) 1.0 хувилбар гарснаас хойш байгаль хамгааллын мэргэжилтнүүд илүү үр нөлөө, үр дүнг тодорхойлох, түүнийгээ хэмжих чиглэлээр ахиц гаргасан. Гэсэн хэдий ч олон байгууллага, агентлагууд ямар арга үр дүнтэй байгаа, юуг сайжруулах шаардлагатай, юуг өөрчлөх ёстой вэ гэдгийг нотолгоонд тулгуурлан тайлбарлахад хүндрэлтэй хэвээр байна.

Хэрэв бид үйл ажиллагааныхаа үр нөлөөг өргөн хүрээнд системтэйгээр хэмжиж, өөрсдийн хүчин чармайлтыг бүртгэж баримтжуулахгүй бол бид зорилгодоо хүрч буй эсэхээ хэрхэн мэдэх вэ? Бид үйл ажиллагаагаа хэрхэн илүү дүнтэй болгох вэ? Бид бие биенээсээ хэрхэн суралцах вэ? Мөн бид амжилтаа хэрхэн нотолж, тулгарч буй сорилтуудаа даван туулахын тулд олон нийтийн болон улс төрийн дэмжлэгийг хэрхэн татан авах вэ?

Байгаль хамгааллын стандарт нь эдгээр сорилтод хариу өгөх зорилгоор нийтлэг ойлголт, арга барил, нэр томъёог нэгтгэсэн зарчим, бодит туршлагыг санал болгож, хариуцлага, ил тод байдал, тэгш оролцоотой хамгааллыг дэмждэг. Энэ бүхэн нь оролцогч талууд илүү үр дүнтэйгээр хамтран стратегиэ боловсруулах, үр нөлөөг нь үнэлэх, сайжруулах боломжийг бий болгодог.

## СМР-ИЙН АЛСЫН ХАРАА

СМР-ийн алсын хараа нь нотолгоонд тулгуурлан ажиллаж, үр нөлөөг хэмжиж, олж авсан сургамжаа бусадтай ил тод, нээлттэй хуваалцан, үүнээсээ урам зориг авдаг. Энэ алсын хараа биелэлээ олохын тулд гишүүн байгууллагууд дараах зүйлд зорилтыг хэрэгжүүлэхийг эрмэлздэг тэмүүлдэг:

- Байгаль хамгааллын нөхцөл байдалд үнэлгээ хийж, тулгамдаж буй асуудал, тэдгээрийн шийдлийг боломжит нотолгоо, мэдлэг, туршлагадаа тулгуурлан тодорхойлох.
- Хүсэж буй үр дүнгээ арга хэмжээ бус, хамгааллын үр нөлөөний хэлбэрээр илэрхийлэх
- Хүссэн үр дүнд хүрэх явцаа хянах
- Сургамж, мэдлэг, туршлагадаа үндэслэн үндэслэн стратегиэ өөрчлөн сайжруулах
- Гарсан үр дүнгээ үнэн зөв, ил тод байдлаар хуваалцаж, суралцах үйл явцыг дэмжих замаар нотолгоогоо баяжуулах

Гишүүдийн үүрэг хариуцлагын талаархи бүрэн тайлбарыг дараах эх сурвалжаас үзнэ үү Гишүүдийн үүрэг хариуцлагын талаархи бүрэн тайлбарыг дараах эх сурвалжаас үзнэ үү [CMP's Charter](#).

<sup>1</sup> "Нээлттэй стандарт" гэх нэр томъёо нь Open Source / Creative Commons хөдөлгөөнд суурилсан бөгөөд эдгээр стандартууд нь олон нийтийн хамтын оролцоогоор боловсруулагддаг, хүн бүрт үнэ төлбөргүй нээлттэй байдаг, ямар нэгэн хувь хүн эсвэл байгууллагын өмч биш гэсэн утгатай. [Creative Commons ShareAlike](#) лицензийн нөхцөлийг энэ баримт бичгийн [Байгаль Хамгааллын Стандартын Тухай](#) хэсгээс үзнэ үү.

# БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН СТАНДАРТЫН ЗОРИЛГО

Байгаль хамгааллын чиглэлийн хүмүүс алсын харааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд Байгаль хамгааллын стандарт нь байгаль хамгааллын төлөвлөлтийг<sup>2</sup> амжилттай хэрэгжүүлэх шилдэг туршлагуудыг санал болгодог бөгөөд энэ нь таван үе шаттай алхмуудад тулгуурладаг.



## ӨӨРТ ХАМГИЙН ТОХИРОМЖТОЙ АЛХМААС ЭХЛЭХ

Төлөвлөгөө боловсруулах баг нь Байгаль хамгааллын стандартын [Алхам 1](#)-ээс эхлэх албагүй. Төлөвлөлтийн баг өмнө нь хийсэн ажлууд, төлөвлөлтийн алхмын аль шатанд байгаагаа харгалзан, Байгаль хамгааллын стандартын хамаарах алхам руу оруулах хэрэгтэй. Заримдаа нөхцөл байдлын талаар мэдээлэл олж авахын хэрээр дараагийн алхмаас эхэлж, өмнөх алхам руу буцаж ажиллах нь илүү оновчтой байж болно.

Байгаль хамгааллын стандарт нь ягштал дагаж мөрдөх гарын авлага биш юм. Харин мэдээлэл, бусад шийдвэр гаргах хэрэгслүүдтэй хамт менежментийн гол шийдвэрүүдийг чиглүүлэх, хамтын ажиллагааг дэмжих, ил тод байдлыг хангаж, хамтын шийдвэр гаргах болон суралцах үндэс суурийг бий болгох зорилготой. Байгаль хамгааллын стандарт нь гэрээ байгуулах, хүний нөөцийн менежмент зэрэг захиргааны холбогдох үйл явц, чиг үүргийг орлох бус, харин тэдгээрийг нөхөж, уялдуулан дэмжих зорилготойгоор боловсруулагдсан.

Энэ гарын авлага нь байгаль хамгааллын сайн зарчим, арга барилд төвлөрсөн бөгөөд “хэрхэн хийх” зааварчилгааг багтаагаагүй. Ийм зааварчилгааг CMP болон Байгаль хамгааллын стандартын зарчмаар боловсруулагдсан бусад эх сурвалжуудаас авах боломжтой ([Support for Implementing the Conservation Standards](#)).

Эдгээр стандартыг ашиглаж буй хүн бүрээс санал хүсэлт хүлээн авахад баяртай байх болно (цахим шуудан: [CMPinfo@conservationmeasures.org](mailto:CMPinfo@conservationmeasures.org)).

2 Ямар ч түвшний хамгааллын бүх үйл ажиллагааг тодорхой бүлэг мэргэжилтнүүд (менежерүүд, судлаачид, орон нутгийн иргэд болон бусад оролцогчид) тодорхой зорилго, зорилгод хүрэхийн тулд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны багц гэж ил тод буюу далд байдлаар төсөл гэж нэрлэж болно. Харин цар хүрээг авч үзэхдээ, хоорондоо холбоотой төслүүдийг томоохон хөтөлбөр болгон нэгтгэх нь ашигтай байж болно. Эдгээр хөтөлбөрүүд нь ихэвчлэн захиргааны болон санхүүжилтийн нэгж байдлаар үйлчилдэг боловч өөрийн гэсэн өндөр түвшний зорилго, зорилт, үйл ажиллагаатай байж болох бөгөөд үндсэндээ илүү том төсөл мэт ажилладаг. Энэ баримт бичигт бид “төсөл” гэх нэр томъёог бүх түвшний төсөл болон хөтөлбөрийг хамруулан ашигласан.

# БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН СТАНДАРТЫН ХУВЬСАЛ

Хувилбар 1.0 (2004) нь 2002 онд Байгаль хамгааллын нөлөөллийг хэмжих санаачилгын хүрээнд хийсэн судалгаанд үндэслэсэн бөгөөд уг судалгаагаар байгаль хамгааллыг оролцуулан долоон салбарын туршлагыг харьцуулж, төслийг хэрхэн сайн төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах нийтлэг арга барилыг тодорхойлсон байдаг.

Уг судалгааны үр дүнд төлөвлөлтийн алхмуудыг уян хатан байлгах зарчмуудыг тодорхой болгожээ. Үүнтэй зэрэгцэн СМР нь гишүүн байгууллагуудын ашиглаж буй төлөвлөлтийн аргуудыг харьцуулж, арга барил болон нэр томъёоны ижил төстэй, ялгаатай талыг тодорхойлох зорилгоор “Rosetta Stone” гэх аргыг ашигласан. Эдгээр бүтээгдэхүүн дээр тулгуурлан СМР-ийн гишүүн байгууллагууд өөрийн байгууллагын онцлог төлөвлөлт, хэрэгжилтийн арга барилыг хуваалцаж, Байгаль хамгааллын стандартын 1.0 хувилбарыг боловсруулж, сайжруулсан.

Байгаль хамгааллын стандартыг хэрэгжүүлэх нь тасралтгүй, уян хатан үйл явц бөгөөд тухайн байгууллагын онцлогт тохирсон стандартыг боловсруулах, алхам бүрийн нарийвчилсан удирдамж боловсруулан түүнийгээ бусад улс оронд түгээн дэлгэрүүлэх сургалт явуулах зэрэг ажлуудыг хийж эхэлсэн. СМР-ийн гишүүд болон хамтрагч талууд Байгаль хамгааллын стандартыг байгаль хамгааллын салбарт нийтлэг, хүлээн зөвшөөрөгдсөн хэрэглээ болгоход голлох үүрэг гүйцэтгэсэн юм. Мөн Байгаль хамгааллын сургагч багш нарын сүлжээ (CCNet) нь стандартыг сурталчлах, хэрэгжүүлэх, дэлхий даяар чадавхыг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэж байна. Байгаль хамгааллын мэргэжилтнүүд хамтдаа өөрсдийн сайн туршлага, мэдлэгээ хуваалцсанаар СМР нь Байгаль хамгааллын стандартыг тасралтгүй сайжруулах боломжтой болсон бөгөөд шинэчилсэн хувилбаруудыг ойролцоогоор 5 жил тутамд гаргадаг.

5.0 хувилбар нь олон хүний мэдлэг, туршлага, оролцооны үр дүнд бий болж байгаа бөгөөд 33 байгууллагын 88 хүн агуулгыг боловсруулахад идэвхтэй оролцсон. 5.0 хувилбарын гол шинэчлэлүүдийг “Хайрцаг 1”-д онцлон харууллаа.

## ХАЙРЦАГ 1

### 5.0 ХУВИЛБАРЫН ШИНЭЧЛЭЛ

5.0 хувилбар нь СМР-ийн гишүүд, Байгаль хамгааллын стандартыг хэрэглэдэг олон хүний оролцоо, хамтын ажиллагааны үр дүн. Эдгээр хүмүүс бодит жишээ, туршлагадаа тулгуурлан шинэчилсэн агуулгыг хамтран боловсруулсан. Гол онцлох зүйлс нь:

- Нэр томъёог өөрчлөх, тодруулах замаар гол ойлголтуудыг илүү ойлгомжтой болгох
- 3–5-р алхмуудын дэлгэрэнгүй тайлбар нэмэх
- Бүх алхамд нотолгоо ашиглах, түүний ач холбогдлыг онцлох
- Байгаль хамгааллын стандарт, шийдвэр гаргалт явцын хоорондын уялдааг тодруулах
- Илүү их үр нөлөө үзүүлэхийн тулд цар хүрээний ач холбогдолд анхаарах
- Зан үйлийн өөрчлөлт болон зан үйлийн судалгааны үр дүнг хамгааллын үйл ажиллагаанд хэрхэн тусгахыг онцлох
- Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлуудыг шинэчлэх
- Хүний сайн сайхны төлөөх зорилтыг харгалзан үзэх, жишээ тайлбарыг нарийвчлах
- Байгаль хамгааллын шударга зарчмын талаар нэмэлт тодруулга оруулах
- Орон зайн дүн шинжилгээг алхам бүрт оруулах, хүлээн зөвшөөрөх
- Зах зээлийн системийн хөгжлийн салбарт ашиглагддаг арга хэрэгсэл, аргачлалыг техниктэй анх удаа ашигласан

# БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН СТАНДАРТЫГ ХЭРЭГЛЭХ

Байгаль хамгааллын стандарт нь уг аргачлалыг ашиглаж буй хүмүүст зориулагдсан. СМР нь эдгээр хүмүүс стандартыг өөрсдөд нь хамааралтайгаар ойлгох нь чухал гэж үздэг. Иймээс стандартад олон жишээ оруулж, уншихад хялбар, шууд хандсан үг хэллэгийг ашигласан.

Байгаль хамгааллын стандартыг ашиглах нь нэг талаараа шинжлэх ухаан, нөгөө талаараа уран сэтгэмж, туршлага шаардсан ажил юм. Төлөвлөлтийн баг<sup>3</sup> нь ажлаа илүү үр дүнтэй байлгах, хэрэгжүүлэхийн тулд нөхцөл байдалдаа тааруулан уян хатан хандаж болно. Жишээлбэл, аргачлалын дагуу ажиллахад дэс дараатай хийх ёстой мэт харагддаг ч төлөвлөлт хийж буй баг ихэвчлэн эхнээс нь төгсгөл хүртэл шулуун замаар явдаггүй, харин алхам хооронд нааш, цааш болох нь бий. Мөн аргачлал, гарах үр дүн нь бүх нөхцөлд тохиромжтой биш тул өөрсдийн нөхцөлд тохируулан бусад арга хэрэгслүүдтэй хослуулах шаардлагатай (жишээг [Recipes for Conservation: A Conservation Standards Toolkit](#) -ээс харна уу).

Байгаль хамгааллын стандартын алхмуудыг [Зураг1](#)-т харуулсан бөгөөд [Хавсралт 4](#) -т алхам бүрийн товч тайлбар, хүлээгдэж буй үр дүнг оруулсан. Байгаль хамгааллын стандартыг хэрэгжүүлэх үйл явц эхэндээ төвөгтэй, нарийн санагдаж болох ч төлөвлөгөө ямар шатанд явж байгаагаас хамааран олон алхмыг та аль хэдийн хийчихсэн байх магадлалтай. Алхам бүрт төгс үр дүн гаргахыг зорих шаардлагагүй. Харин энэ үйл явцыг давтагдах, хурдан урагшлах, гарах үр дүнгийн эхний хувилбарыг боловсруулах, хэрэгжүүлэх явцад өөрчлөлт оруулан сайжруулах боломж гэж үзэх нь зүйтэй. Мөн мэдээлэл хангалтгүй байгаа тохиолдолд саатахгүйгээр таамаглалуудаа дэвшүүлэн, одоо байгаа хамгийн сайн мэдээлэл дээр үндэслэн үргэлжлүүлж, гол шийдвэрүүдээ баримтжуулан, хэрэгцээт мэдээллээ тодорхой болгоорой.



3 Байгаль хамгааллын стандартад бид зориуд "та" болон "таны" гэсэн танил үгсийг ашигладаг. Ингэснээр стандарт нь илүү ойр дотно, ойлгомжтой санагдаж, төлөвлөлтийн үйл явцад оролцож буй бүх хүнд, байгууллагын ажилтан, орон нутгийн иргэд, уугуул ард иргэд гээд хязгаарлагдахгүйгээр зориулагдсан болохыг харуулдаг.

# БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН СТАНДАРТ БА БУСАД АРГАЧЛАЛУУДЫН УЯЛДАА

Байгаль хамгааллын стандарт нь шийдвэр гаргалт болон дасан зохицох менежментийг<sup>4</sup> дэмжихэд ашиглагддаг хэд хэдэн арга, хэрэгслүүдийн нэг юм. Байгаль хамгааллын стандартыг хэрхэн өөрийн нөхцөлд тохируулан ашигласан болон бусад арга хэрэгслүүдтэй ямар уялдаа холбоотой болохыг ойлгохын тулд ангиллуудыг ялгаж үзэх нь чухал. Төслөө төлөвлөх, хэрэгжүүлэх, түүнээсээ суралцах явцдаа шийдвэр гаргалт болон өөрт хамгийн тохиромжтой аргачлалыг сонгон ашиглана уу.

## Байгууллага болон зорилтот бүлэгт нийцүүлсэн

### Байгаль хамгааллын стандартын өөрчлөлтүүд:

Зарим байгууллага Байгаль хамгааллын стандартыг өөрийн бодлого, дотоод журам болон ажлын арга барилдаа нийцүүлэн өөрчлөн ашигладаг (жишээ нь: ДБХС-ийн Төсөл, Хөтөлбөрийн Менежмент Удирдлагын Стандарт). Зарим нь тодорхой зорилтот бүлэгт зориулан өөрчилдөг, ялангуяа уугуул (нутгийн) иргэдтэй ажиллаж байгаа үед (жишээ нь: Healthy Country Planning). Эдгээр хувилбарууд нь нэр томъёоны өөрчлөлт, нарийвчилсан зааварчилгаа, эсвэл тодорхой аргачлалыг зөвлөж болно.

### Бусад дасан зохицох менежментийн аргачлалууд:

Бусад аргачлалууд (жишээ нь: Collective Impact Framework, Conservation Planning Specialist Group-ийн Зарчим ба Алхмууд, Systematic Conservation Planning) нь Байгаль хамгааллын стандарттай ижил зорилготой боловч анхаарал төвлөрүүлж буй чиглэл болон хэрэглэж буй аргаараа ялгаатай. Хэдий тийм ч эдгээр аргачлалууд болон Байгаль хамгааллын стандарт нь харилцан уялдаж, бие биенээ нөхөж, ингэснээр илүү үр дүнд хүрч болно. Жишээлбэл, олон хамтрагчтай төсөлд BirdLife-ийн Project Toolkit нь Байгаль хамгааллын стандартыг ашиглаж, уялдуулан Collective Impact Framework-ийг боловсруулсан байдаг.

**Нэмэлт шийдвэр гаргах хэрэгслүүд:** Байгаль хамгааллын стандартын тодорхой алхмуудыг сайжруулахын тулд бусад арга, хэрэгслүүдийг (жишээ нь: үр дагаврын хүснэгт эсвэл системийн зураглал) ашиглаж болно. Асуудлын нарийн төвөгтэй байдал болон төлөвлөлтийн багийн сонголтоос хамааран эдгээр аргачлал, хэрэгслүүдийг сонгож, хослуулан ашиглах боломжтой. Үнэндээ Байгаль хамгааллын стандарт нь бусад аргачлалуудаас зарчим, хэрэгслүүдийг нэгтгэх боломжтойгоор боловсруулагдсан бөгөөд энэ нь уян хатан байдлыг хангаж, илүү мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах боломжийг олгодог.

### Байгаль хамгааллын бусад аргачлалууд:

Түгээмэл хэрэглэгддэг бусад аргачлалууд (жишээ нь: IUCN-ийн Green List of Protected Area эсвэл Conservation Assured Tiger Standards) нь байгаль хамгааллын менежментийн сайн туршлагыг харуулахад төвлөрдөг боловч дасан зохицох менежментийн аргачлал биш юм. Дээрхи аргачлалууд нь тодорхой шалгуурыг хэр сайн хангаж байгааг үнэлэх зорилготой бөгөөд хүлээн зөвшөөрөгдөх боломжийг олгодог. Эдгээр аргачлалуудыг ашиглах нь Байгаль хамгааллын стандартад дэмжлэг үзүүлэх зорилгоор [Conservation Audit Tool](#)-ийг ашиглахтай адил юм.

Илүү дэлгэрэнгүй үзэхийг хүсвэл “Бодит” [хүснэгтээс](#) үзнэ үү.



PHOTO: JOHN MORRISON

## ХАЙРЦАГ 2

ГОЛ СЭДВҮҮДИЙН ТАЛААРХ  
НЭМЭЛТ ТАЙЛБАР, МЭДЭЭЛЭЛ

Байгаль хамгааллын стандарт 5.0-н баг ач холбогдол бүхий хэд хэдэн сэдвийг илүү гүнзгий авч үзсэн бөгөөд тэдгээрийг энд нэгтгэн харууллаа. Байгаль хамгааллын стандартын алхам бүрт холбогдох хэсэгт эдгээр гол сэдвүүдтэй холбоотой ойлголтуудыг нэгтгэсэн. Байгаль хамгааллын стандартын үндсэн зарчим ба практик туршлагауудыг оруулсан бөгөөд зарим хэсгүүдэд тухайн сэдвийн талаар илүү дэлгэрэнгүй байдлаар ([supplemental briefs](#)) тайлбарласан зөвлөмж, нэмэлт эх сурвалжуудыг оруулсан.

**Зан үйлийн өөрчлөлт:** Байгаль хамгааллын бүх ажил хүний зан үйлтэй хамааралтай байдаг. Иймээс зан үйлийн болон нийгмийн шинжлэх ухааны зарчмуудыг ашиглах нь бидний ажлыг илүү үр дүнтэй, цэгцтэй болгоход тусална.

**Уур амьсгалын өөрчлөлт:** Уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэх нь дэлхийн хэмжээнд тэргүүлэх чиглэл учир хамгааллын төлөвлөлт, менежментэд зайлшгүй тооцох шаардлагатай. Болзошгүй уур амьсгалын нөлөөлөл нь төвөгтэй, зарим талаар бүрэн ойлгогдоогүй байдаг тул ажиглалт, тандалт нь таамаглалыг шалгах, шаардлагатай өөрчлөлтийг тодорхойлох гол арга болно. Өмнөх хувилбаруудын нэгэн адил, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх нэмэлт тайлбарууд энэ гарын авлагад ногоон хүрээтэй хэсгүүдэд багтсан.

**Нотолгоо:** Байгаль хамгааллын мэргэжилтнүүд шийдвэр гаргах, арга хэмжээ авах, дэвшүүлсэн таамаглалаа шалгахдаа төрөл бүрийн **нотолгоонд** тулгуурладаг (жишээ нь: уламжлалт мэдлэг, судалгааны анхан шатны өгөгдөл, туршлагаас олж авсан мэдлэг, мэдээллийн сан, нотолгоонд суурилсан онолууд). Байгаль хамгааллын стандартын алхам бүрд нотолгоог ашиглахыг онцгойлон зөвлөж, үүнд ач холбогдол өгдөг.

**Тэгш хүртээмжтэй хамгаалал:** Манай гаригийн ирээдүйг аюулгүй, баталгаатай байлгахын тулд хүн бүр дуу хоолойгоо хүргэх, оролцох, үйлдэл хийх боломжтой байх ёстой. СМР нь байгаль хамгааллын ажлыг хэрэгжүүлдэг хүмүүсийг илүү үр дүнтэйгээр дэмжих үүднээс **тэгш, хүртээмжтэй хамгааллыг** хөхүүлэн дэмждэг.

**Хүний сайн сайхны төлөөх зорилт:** Байгаль хамгааллын ажил нь хүн төвтэй бөгөөд хүмүүс хэрхэн байгаль хамгаалалд хувь нэмрээ оруулж, хамгааллын үр дүн нь тэдэнд хэрхэн нөлөөлж байдгийг тусгах нь чухал. Энэ хувилбарт СМР-ийн дэлгэрэнгүй заавар болон эдгээр ойлголтыг хэрэгжүүлэх явцад бий болсон сургамжуудыг оруулсан.

**Цар хүрээ:** Байгаль орчинд тулгамдаж буй асуудлуудын цар хүрээ нь тодорхой нэг газрууд дээр ажиллаад шийдэх боломжгүйг харуулсаар байна. Харин эдгээр даяаршсан асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай орон зайн, засаглалын, цаг хугацааны хэмжээнд системтэйгээр арга хэмжээ авах шаардлагатай. Энэ нь “том хүрээнд ажилла”, “хамрах хүрээгээ нэмэгдүүл” гэсэн зарчмыг шаарддаг.

## ЗУРАГ 1

Байгаль хамгааллын стандартын мөчлөг

**1. ТОДОРХОЙЛОХ**

- Төлөвлөлтийн зорилго & баг
- Хамрах хүрээ, алсын хараа, хамгаалах үнэт зүйл
- Аюул, дарамт
- Нөхцөл байдал

**2. ТӨЛӨВЛӨХ**

- Зорилго, арга хэмжээ, таамаглал, зорилт
- Мониторинг төлөвлөгөө
- Үйл ажиллагааны төлөвлөгөө

**3. ХЭРЭГЖҮҮЛЭХ**

- Багийн бүтэц, үйл явц
- Гүйцэтгэлийн төлөвлөгөө, хугацаа
- Төсөв
- Төлөвлөгөө хэрэгжүүлэх

**4. ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ & УЯЛДУУЛАХ**

- Өгөгдөл бэлтгэх
- Дүн шинжилгээ
- Төлөвлөгөө, төсвийг тодотгох

**5. ХУВААЛЦАХ**

- Баримтжуулах
- Мэдлэгээ хуваалцах
- Суралцах орчинг бүрдүүлэх

# БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН СТАНДАРТЫГ ХЭРЭГЖИЛТИЙГ ДЭМЖИХ НЬ

Төлөвлөгөө боловсруулахад Байгаль хамгаалалтын стандартад тусгагдсан зарчим, арга барилыг хэрэгжүүлэхийн тулд дэмжлэг болох, зааварчилгаа чиглүүлэг авах олон арга зам бий.

## Сургагч багш нар

Үр дүн, нотолгоонд түшиглэсэн төлөвлөлт ба хэрэгжилтийн арга барилыг ашиглах нь байгууллага болон хүмүүсийн ажиллах, сэтгэлгээнд томоохон өөрчлөлт авчрах тохиолдол олон байдаг. Иймээс Байгаль хамгааллын стандартыг шинээр ашиглаж буй хүмүүст эхлээд чиглүүлэг өгөх сургагч багштай ажиллах нь үр дүнтэй. Зарим байгууллага дотооддоо Байгаль хамгааллын стандартаар мэргэшсэн сургагч багштай байдаг. Мөн түүнчлэн Байгаль хамгааллын стандартын чиглэлээр зөвлөгөө, төлөвлөлтийг удирдан чиглүүлдэг мэргэшсэн үйлчилгээ үзүүлдэг сургагчид байдаг. Эдгээр мэргэжилтнүүдийн олонх нь [Conservation Coaches Network](#) (CCNet)-ийн гишүүн байдаг. CCNet нь дэлхийн даяар энэ чиглэлээр ажиллаж буй багуудыг дэмжих, сургагч багш нарын идэвхтэй сүлжээг бий болгох зорилготой CMP-ийн ойрын хамтрагч юм. Мөн CCNet нь сургагч багш болох сонирхолтой байгаль хамгааллын чиглэлээр ажиллаж буй хүмүүст зориулсан сургалт, чиглүүлэг олгохоос гадна туршлагатай сургагч багш нарыг гэрчилгээжүүлэх ажлыг хийдэг.

## Зааварчилгаа, хэрэглэгдэхүүн


CMP-ийн гишүүн байгууллагууд болон хамтрагч талууд нь үндсэн зарчмуудын талаар шат дараалсан заавар, эсвэл илүү дэлгэрэнгүй мэдээлэл бүхий гарын авлага, хэрэгслүүдийг боловсруулсан байдаг. [Зураг 2](#)-р зурагт харуулсанчлан, эдгээр нь Байгаль хамгааллын стандартын үндсэн зарчим, арга барилыг хэрэгжүүлэхэд мэргэжилтнүүдэд туслах зорилготой. Үүнд байгууллагад зориулсан гарын авлага, байгууллагуудын хамтран боловсруулсан ангиллын системүүд (жишээлбэл, аюул, дарамт болон үйл ажиллагааны ангилал), цахим болон танхимын сургалт, судалгаа, видео материалууд, сургалтын хөтөлбөрүүд багтдаг. Эдгээр материалуудыг [Conservation Standards website](#) -аас авах боломжтой (Training, Case Studies, Resource Library хэсгүүдийг үзнэ үү). Мөн гарын авлагууд нь CMP болон CCNet-ийг төлөөлсөн, байгууллагууд хоорондын хамтарсан зөвлөлөөр хянагдаж, үнэлэгдсэн байдаг. Байгаль хамгааллын стандартын уламжлалт хэрэгслээс гадна, мэргэжлийн хүмүүс ашиглаж болох шийдвэр гаргахад туслах олон төрлийн эх сурвалжууд бас бий.



PHOTO: JASON HOUSTON FOR USAID

## ЗУРАГ 2

## Байгаль хамгааллын стандарт ба холбогдох эх сурвалжууд

ЕРӨНХИЙ ӨНДӨР ТҮВШНИЙ  
ЗАРЧИМ, ПРАКТИКУУДБАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН СТАНДАРТУУДЫН ЗАРЧМУУДЫН  
ХЭРЭГЖИЛТИЙГ ДЭМЖИХ ТУСГАЙЛСАН УДИРДАМЖ, ХЭРЭГСЛҮҮД

## Дэмжих технологи

Дэмжих технологи гэдэг нь Байгаль хамгааллын стандартыг хэрэгжүүлэхэд мэргэжилтнүүдийн чадварыг нэмэгдүүлэх хэрэгсэл, аргачлалуудыг хэлнэ. Жишээлбэл, шийдвэр гаргахад туслах аргууд, стратегийн төлөвлөлтийн програм хангамж, төслийн менежментийн аргачлал, санхүүгийн менежментийн програм, зэрлэг амьтан болон нийгмийн судалгааны мониторинг, өгөгдөл хадгалах системүүд орно. Байгаль хамгааллын стандартыг хэрэглэж буй мэргэжилтнүүд бүтээлч хэлэлцүүлэг хийх, судалгаа, нотолгоо, тооцоолол, хамтран ажиллах, мэдээлэл хуваалцах, хийх үндсэн хэрэгслүүдийн багцтай байдаг. Шинэ технологи хайхдаа багийнхаа хэрэгцээ болон нөөцийг сайтар харгалзан үзэж, хамгийн тохиромжтой сонголтыг хийх хэрэгтэй. Үүнд энгийн хэрэгслүүд болох хүснэгт (spreadsheet) болон цаас, үзэг ч багтаж болно.

**Miradi програм:** Miradi програм нь Байгаль хамгааллын стандартын гол алхмуудыг шат дараатайгаар хэрэгжүүлэхэд зориулагдан бүтээгдсэн сайн технологийн тод жишээ юм. Энэ програм нь хамгаалалтын нөхцөл байдал, тэргүүлэх арга хэмжээ, хүлээгдэж буй үр дүн, холбогдох зорилго болон зорилтуудыг харуулах, баримтжуулах боломжтой. Мөн үр дүнгийн хэрэгжилтийн явцыг хянах, мэдээллийг нэгтгэн харуулах харилцан уялдаатай өгөгдлийн сангийн

үүргийг гүйцэтгэнэ.”Стандартчилсан өнгө болон дүрсийг ашигласнаар Miradi нь Байгаль хамгааллын стандартын хэрэглэгчдийн хоорондын харилцан ойлголцлыг хялбарчилж, нийтлэг дүрсний хэлийг бий болгосон. Үүнээс гадна Miradi нь хэлэлцүүлэг, нотолгоо, шийдвэрүүдийг баримтжуулах тусгай хэсгүүдтэй бөгөөд энэ нь дасан зохицох менежмент, **нотолгоонд суурилсан хамгаалал**, түүнчлэн суралцах үйл явцыг дэмжихэд чухал боломж болдог. Miradi нь мөн [Conservation Actions and Measures Library \(CAML\)](#) –ийг дэмждэг. CAML нь хамгааллын арга хэмжээнүүдтэй холбоотой өөрчлөлтийн онолын загвар, хүлээгдэж буй үр дүнгийн баталгаажсан загвар, жишээнүүдээс бүрдсэн сан юм. [Miradi](#)-гийн вэбсайт болон [YouTube channel](#) суваг нь төрөл бүрийн сургалтын эх сурвалжуудыг агуулсан байдаг. Зарим хүмүүс Miradi-г Байгаль хамгааллын стандарттай андуурдаг. Гэхдээ үр ашигтай хамгааллын төлөвлөлт, хэрэгжилтийг тодорхойлогч гол хүчин зүйл нь Miradi бус, харин CS-ийн зарчим болон практик гэдгийг онцлон тэмдэглэх нь чухал. Мэргэжилтнүүд өөрсдөд нь үр нөлөөтэй гэж үзсэн аливаа хэрэгслийг ашиглаж болно. Miradi нь Байгаль хамгааллын стандартыг хэрэгжүүлэх бараг бүх алхмыг дэмждэг цогц хэрэгсэл боловч бүх нөхцөл байдалд заавал тохирох албагүй. Зарим баг өөрсдөд нь илүү танил, илүү тохиромжтой бусад хэрэгслийг сонгон ашиглаж болох бөгөөд зарим тохиолдолд байгууллагын шаардлагаар тодорхой ажиллах болон тайлагнах платформуудыг ашиглах үүрэгтэй байж болно.

**Орон зайн технологи:** Орон зайн (spatial) технологи нь Байгаль хамгааллын стандартыг хэрэгжүүлж буй мэргэжилтнүүдэд чухал үүрэгтэй. Орон зайн мэдээлэлтэй холбоотой аргууд нь мэдээллийг зурагжуулах, шинжлэх, тайлбарлах үйл ажиллагааг дэмждэг түгээмэл хэрэгсэл. Энэ технологи нь биологийн олон янз байдал, зүйлийн тархалт, газар ашиглалтын хэв шинж ба түүний өөрчлөлт, амьдрах орчны хүртээмж, холбоос нутаг, экосистемийн үйл явц, экосистемийн үйлчилгээний үр өгөөж, хүний сайн сайхан байдлын нөлөөлөл, уур амьсгалын өөрчлөлтийн хэв шинж зэрэг олон талт ойлголтуудыг илүү нарийн мэдэхэд тусалдаг. Хэдий орон зайн технологи нь хүчирхэг хэрэгсэл боловч заримдаа сорилттой тулдаг. Тухайлбал: Мэргэшсэн програм хангамж, тоног төхөөрөмж, чадварлаг хүний нөөцийн өндөр өртөг нь хүртээмжийг хязгаарлаж болно. Өгөгдлийн чанар, хүртээмж бүс нутаг бүрт адилгүй байдаг тул дутуу эсвэл тархмал мэдээлэл нь шинжилгээний нарийвчлалд нөлөөлөх магадлалтай. Мөн, орон зайн аргачлалууд (болон хиймэл оюун ухааны технологи) нь боловсруулалтын хүчин чадал, өгөгдөл хадгалах зай шаарддаг.

**Хиймэл оюун ухаан:** Хиймэл оюун ухаан (AI) нь хурдацтай хөгжиж, байгаль хамгааллын салбарын салбарын олон чиглэлд шинэ өөрчлөлт

авчирч байна. AI нь байгаль хамгааллын төслийг төлөвлөх, удирдах үйл явцад зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, үр дүнг сайжруулах томоохон боломжийг олгодог. Гэвч өнөөгийн ихэнх AI загварууд интернетээс олддог олон нийтэд нээлттэй мэдээлэлд тулгуурлан сургасан байдаг. Энэ мэдээлэл нь ихэвчлэн дутагдалтай, төлөөлөх чадвар муутай, чанар ба нарийвчлал нь ханалтгүй байдаг. Иймээс AI д тулгуурлан байгаль хамгааллын ажил хийхдээ хамгийн найдвартай эх сурвалжын найдвартай байдал, мэдээллийн үнэн зөвийг салбарын мэргэжилтнүүд болон Байгаль хамгааллын стандартын туршлагатай баг, хамт олны оролцоотойгоор шүүн, тунгаах үнэлэх шаардлагатай.

Одоогийн AI загваруудын хязгаарлагдмал байдлыг харгалзан, CMP нь Байгаль хамгааллын стандартын ойлголт, нэр томъёог зөв ойлгодог, баталгаажсан, төлөөлөх чадвартай, баталгаат эх сурвалжын багцаас бүтээгдсэн AI загварыг хөгжүүлэх зорилготой. Ингэснээр AI гаар боловсруулсан мэдээллийг ашиглахад чанар, найдвартай байдал, хэрэглээний үр өгөөжийг мэдэгдэхүйц сайжруулна гэж харж байна. Энэ чиглэлийн хөгжлийн явцыг хянах, мөн боломжтой хэрэгслүүдийн талаар зөвлөмж, чиглүүлэг хуваалцах зорилгоор [AI section in the CMP Workspace](#) хэсгийг ашиглаж болно.

## ТУСЛАМЖ АВАХ

[Conservation Standards Resource Library](#) нь олон төрлийн эх сурвалжуудыг агуулдаг бөгөөд тэдгээрийн ихэнхийг Хамгааллын Стандартад оролцдог олон байгууллагын төлөөллөөс бүрдсэн (CMP–CCNet Guidance Review Committee) хөндлөнгийн үнэлгээний баг хянаж, үнэлсэн байдаг. Шинэ эх сурвалжууд тогтмол хянагдаж, нөөцийн санд ордаг.

Хамгааллын Стандартын гишүүдэд зориулсан [хөтлөлттэй болон Бие даан суралцах боломжтой сургалтын сонголт -ууд](#) байдаг. Эдгээр сургалтуудыг Guidance Review Committee нягталж, баталгаажуулсан.

Мөн олон сэдэв дамнасан чиглэлүүд тус бүрдээ [нэмэлт тайлбар товчоо supplemental briefs](#) -той байдаг бөгөөд эдгээр нь тухайн сэдэвт илүү нарийвчилсан мэдээлэл хайж буй хүмүүст зориулсан. Эдгээр материалууд нь Хамгааллын Стандартуудад тусгагдсан өндөр түвшний зарчмуудаас цаашилж, чиглүүлэг болгон хэрэглэх боломжтой тодорхой эх сурвалжуудыг санал болгодог.

[Байгаль хамгааллын хэрэгслүүд: “A Conservation Standards Toolkit”](#) нь хүмүүст бодит нөхцөл байдалд ашигласан илүү энгийн байдлаар Байгаль хамгааллын стандартыг ашиглахад зориулсан цуврал “жор”-уудыг санал болгодог. Эдгээр жорууд нь практик санаа, шууд ашиглаж болох загварууд, бусад хэрэгслүүдийн багтаасан Tipsheet-үүдтэй холбогддог бөгөөд энгийн болон нарийвчилсан байдлаар ашиглахад аль алинд нь тохиромжтой.

[CMP Workspace](#) нь CMP-ийн гишүүдийн дотоод хамтын ажиллагааны платформ бөгөөд шинэ санаачилга, уулзалт, сургалт болон CMP-ийн бусад үйл ажиллагаатай холбоотой гарын авлагууд, тэмдэглэл, файлуудыг агуулдаг. Workspace-д тодорхой бүтээгдэхүүнүүд байдаг ч олон нийтэд зориулсан эцсийн бүтээгдэхүүний ихэнх нь CS Resource Library-д байрладаг.


[Conservation Coaches Network \(CCNet\)](#) ийн цахим хуудас нь хэрэглэгчдийг сургагч багш нартай холбогдох боломжтой болгохын зэрэгцээ Байгаль хамгааллын стандартыг хэрэгжүүлэх үе шат бүрт чиглэл өгөх нарийвчилсан материалуудыг санал болгодог.

# ЕРӨНХИЙ ЗАРЧИМ, АНХААРАХ АСУУДАЛ

Байгаль хамгаалалтын стандартын бүх алхамд хамаарах хэд хэдэн үндсэн зарчим болон анхаарах зүйл бий. Эдгээрийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг 3-р хавсралтад, харин товч дүгнэлтийг 3-р хайрцагт танилцуулсан. 3-р хайрцгийн сүүлийн анхаарах зүйлд дурдсанаар ‘зорилго’, ‘зорилт’, ‘стратегий’, ‘үйл ажиллагаа’, ‘хамгаалах үнэт зүйл’, ‘дунд хугацааны үр дүн’ зэрэг техникийн нэр томъёоны утга, нэршлийн талаар хэлэлцүүлэг, маргаан өрнөдөг.

Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, нэг мөр ойлголт одоогоор байхгүй ч Байгаль хамгааллын стандарт нь төслийн багийн гишүүд болон хамтрагчид нэр томъёог тодорхой, нийтлэг ойлголттой байх нь маш чухал гэж үздэг. Үүнийг харгалзан энэхүү аргачлалд ашигласан техникийн нэр томъёог анхааралтай сонгож, анх удаа бүрэн тайлбарласан үед нь тод (bold) хэлбэрээр тэмдэглэн, дараагийн хэсгүүдэд тогтвортой ашиглаж, тайлбар тольд тодорхойлсон.

Байгаль хамгааллын стандарт хөгжихийн хэрээр зарим нэр томъёог харилцаа холбоо болон үндсэн зарчим, алхмуудыг илүү ойлгомжтой болгохын тулд шинэчлэх шаардлага гардаг. [1-р хүснэгтэд](#) 5.0 хувилбар дахь нэр томъёоны зарим шинэчлэл, тодруулгыг багтаасан.



## ХАЙРЦАГ 3

### ҮНДСЭН ЗАРЧИМ БА АНХААРАХ ЗҮЙЛСИЙН ТОВЧ ДҮГНЭЛТ

Байгаль хамгааллын стандартыг ашиглахдаа дараах зарчмуудыг анхаарах нь чухал (дэлгэрэнгүйг [3-р хавсралтаас](#) үзнэ үү):

#### ЗАРЧМУУД

- Талуудтай хамтран ажиллах
- Сонирхогч талуудыг аль болох эрт, бүрэн оролцуулах
- Байгаль хамгааллыг шударга, тэгш хэрэгжүүлэх
- Нотолгоонд тулгуурлан зөв ашиглах, түүнд хувь нэмэр оруулах
- Тодорхойгүй байдлыг удирдахад дасан зохицох менежментийг ашиглах
- Гаргасан шийдвэрээ баримтжуулах
- Суралцах орчныг бүрдүүлэх

#### АНХААРАХ ЗҮЙЛС

- Энэ стандарт цаг хугацааны явцад өөрчлөгдөнө
- Стандарт нь хамгийн оновчтой загварыг илэрхийлнэ
- Стандарт нь тодорхой тэргүүлэх чиглэлүүдийг аль хэдийн тогтоосон гэж үздэг
- Цөөн төслүүд төлөвлөлтийн эхний шатнаасаа Байгаль хамгааллын стандартыг хэрэгжүүлж эхэлдэг
- Төсөл бүр өөрийн онцлогтой тул стандартыг тохируулан ашиглах шаардлагатай
- Энэ стандарт нь аливаа төсөлд орон зайн, байгууллагын болон цаг хугацааны ямар ч түвшинд хамаарна
- Стандартын гол зорилго нь байгаль хамгаалал боловч хэрэгцээндээ нийцүүлэн өөрчилж болно
- Стандартыг байгалийн, нийгмийн болон зан үйлийн шинжлэх ухааны олон аргачлал, зааварчилгаагаар хэрэгжүүлж болно
- Стандартад нэр томъёог тодорхой, тогтвортой ашиглахыг зорьдог

ХҮСНЭГТ 1

Хувилбар 5.0-д орсон нэр томъёоны өөрчлөлт

Өмнөх нэр томъёо	Шинэ нэр томъёо	Шинэчлэлийн тайлбар
Хамгаалах үнэт зүйл Target (Хүсэж буй үр дүн/ үнэ цэнэ)	Хамгаалах үнэт зүйл Focal value	<p>Байгаль хамгааллын стандартын өмнөх хувилбаруудад ‘Хамгаалах үнэт зүйл’ (target) гэдэг нэр томъёог төлөвлөлтийн баг анхаарлаа төвлөрүүлсэн системийн хүчин зүйд ашиглаж ирсэн. Харин олон улсын түвшинд (дэлхийн конвенциудыг багтаан) ‘Target’ гэдэг нэр томъёог SMART зорилго эсвэл зорилтын хүрээнд хүрэх ёстой үзүүлэлтийн тоон болон чанарын хэмжүүрийг илэрхийлэхэд хэрэглэдэг. Байгаль хамгааллын стандартын хэрэглэгчид ‘Target’ гэсэн нэр томъёог ашиглаж, мөн зөрүүтэй ойлголтод санаа зовниж ирсэн. Иймээс бусад салбар болон олон улсын конвенцийн хэллэгтэй нийцүүлэх шаардлагатай гэж үзэж байна.</p> <p>Тайлбар: Хамгаалах үнэт зүйл (focal value) нь янз бүр байж болно (жишээ нь: биологийн олон янз байдал, уур амьсгал, хүний сайн сайхан байдал, соёлын үнэт зүйлс). Төлөвлөлтийн баг оролцогч талууддаа хамгийн ойлгомжтой, тохиромжтой нэр томъёог сонгон ашиглах хэрэгтэй.</p>
Стратеги Strategy	Арга хэмжээ Action	<p>Хувилбар 4.0 д “стратеги” гэдгийг нийтлэг чиглэлтэй үйл ажиллагааны багц арга зам гэж тодорхойлж, харин “арга хэмжээ” (action) гэдгийг стратеги, үйл ажиллагаа, даалгавар зэрэг хийх ажлыг илэрхийлсэн ерөнхий нэр томъёо болгон ашигладаг байсан. Гэвч энэ нь хөгжлийн салбар, бизнесийн салбар, батлан хамгаалах зэрэг олон улсын түвшний салбарууд эдгээр нэр томъёог ашигладаг стандарт хэрэглээтэй нийцдэггүй.</p> <p>Иймээс нэр томъёоны хэрэглээг дараах шатлалын дагуу шинэчлэн тохируулсан: стратеги (Strategy), Арга хэмжээ (Action), Үйл ажиллагаа (Activity), Даалгавар (Task).</p>
Оролцогч тал Stakeholder	Оролцогч тал Interested party	<p>“Stakeholder” буюу оролцогч тал гэдэг нэр томъёо нь колоничлолын өнгө аястай холбоотой гэж үзсэн тул илүү төвийг сахисан утгатай “оролцох сонирхолтой тал” (interested party) гэж хэрэглэхээр боллоо.</p>



# ТОДОРХОЙЛОХ



# ТОДОРХОЙЛОХ

Байгаль хамгааллын стандартын энэ алхамд төлөвлөгөөний үндсэн хамрах хүрээ, ерөнхий нөхцөл байдлыг үнэлнэ. Тухайлбал, төлөвлөгөөний зорилго, хэрэгжүүлэх баг, оролцогч талуудын оролцооны хэлбэр зэрэг асуудлуудыг тодорхой болгоно. Мөн төлөвлөгөөний хамрах хүрээ, алсын харааг томъёолох, хамгаалах үнэт зүйлүүдийг тодорхойлох ажлууд хийгдэнэ. Эцсийн дүндээ энэ алхам нь төлөвлөгөөний нөхцөл байдлыг илүү сайн ойлгоход чиглэх бөгөөд төлөвлөгөөнд тулгарч буй асуудал, боломжууд, төслийн үр дагаварт өртөх эсвэл оролцох гол талуудыг тодорхойлох юм.

## 1А. Зорилгоо тодорхойлж, төслийн багаа бүрдүүлэх

### Хамгааллын Стандартыг ашиглах зорилгыг тодорхойлох

Байгаль хамгааллын стандартын алхмуудын аль хэсгээс ч орж болох ба хаанаас нь ч эхэлсэн бай юун түүрүүндяагаад энэ стандартыг ашиглаж байгаагаа тодорхойлох хэрэгтэй бөгөөд энэ үйл явц таны төлөвлөлтөд хэрхэн дэмжлэг үзүүлэхийг ойлгох нь чухал юм (стратегийн төлөвлөгөө боловсруулах, өмнө хийсэн ажлын үр нөлөөг эргэн харах гэх мэт)<sup>5</sup>. Мөн ямар шийдвэрүүд гаргах гэж байгаа, хэн шийдвэр гаргах, ямар хүмүүс эерэг болон сөрөг байдлаар өртөхийг тодруулах хэрэгтэй. Үүний зэрэгцээ байгууллагын эрхэм зорилго, одоогийн тэргүүлэх чиглэлүүдийг эргэн харж, өмнө гаргасан шийдвэрүүдийг тодруулах, шийдвэр гаргагчдын хүлээлт болон санхүүжилт, бусад зүйлсийн талаарх таамаглалуудыг тодруулах нь зүйтэй. Хэрэв талуудтай хамтран ажиллаж байгаа бол эрхэм зорилго, тэргүүлэх чиглэлүүдээ харьцуулж, нийцэж буй болон зөрчилдөх асуудлуудыг тодорхойлох шаардлагатай. Түүнчлэн тодорхой донортой хамтран ажиллахаар төлөвлөж байгаа бол Байгаль хамгааллын стандартыг үндсэн үйл явц болгон ашиглахыг уриалах, эсвэл нэр томъёо болон алхмуудыг уялдуулан тайлбарлаж ойлголтыг нэмэгдүүлэх нь чухал.

Өмнө нь хийгдэж байсан ажлууд, түүний туршлага, сургамжийг ашиглах нь зүйтэй. Энэ үнэлгээ нь та энэ үйл явцад хэр хэмжээний хүчин чармайлт гаргах ёстойгоо болон бусадтай харьцуулахад

аль алхамууд илүү чухал болохыг тодорхойлоход тусална.

Жишээлбэл, хамгаалах үнэт зүйлс болон зорилгуудыг аль хэдийн тодорхойлсон бөгөөд аюул, дарамтын үнэлгээ хийгдсэн бол та тэдгээрийг дахин хянаад дараагийн шатанд нөхцөл байдлын дүн шинжилгээ болон стратеги боловсруулах ажилд оруулах боломжтой.

### Төлөвлөлтийн баг

**Төлөвлөлтийн баг** гэдэг нь тухайн ажлыг төлөвлөж, хэрэгжүүлдэг хүмүүсийн бүрэлдэхүүн юм. Багийн гишүүдэд ихэвчлэн байгууллагын мэргэжилтнүүд, **гол хамтран ажиллагсад** болон **оролцогч талууд** багтдаг. Оролцогч талууд гэдэг нь гол хамтрагчид болон төлөвлөлтийг сонирхож буй, нөлөөлөх боломжтой, эсвэл төлөвлөлтийн үйл ажиллагаанаас эерэг болон сөрөг байдлаар нөлөөнд өртөх магадлалтай хувь хүн, бүлэг, байгууллагыг хэлнэ. Төлөвлөгөөний хэрэгжилт болон хүлээн зөвшөөрөлт нь багт хэн оролцож байгаагаас ихээхэн хамаарах тул олон талын сонирхогчдыг хэрхэн оролцуулах талаар бодох нь чухал. Багууд ихэвчлэн багийн ахлагчаар удирдуулж, тэр нь багийн ажлыг бүхэлд нь зохицуулж, урагш ахиулах үүрэгтэй байдаг. Зарим байгууллагад баг нь дээд түвшний менежерт тайлагнадаг. Ерөнхийдөө төлөвлөлтийн багийн бүх гишүүдийн үүрэг, хариуцлагыг тодорхой болгох нь чухал. Багийн дүрэм болон хамтын ажиллагааны гэрээгээр багийн хэм хэмжээ, үйл ажиллагааг албан ёсоор тодорхойлох нь зүйтэй.

5 Сануулахад, [Recipes for Conservation: A Conservation Standards Toolkit](#) нь багуудад Байгаль хамгааллын стандартыг хэрэгжүүлэх үйл явцад оролцох, дасан зохицох олон арга замыг санал болгодог бөгөөд багуудын өөр өөр хэрэгцээг харгалзан үздэг.

Хамтын ажиллагааны тохиолдолд багууд албан ёсны гэрээ байгуулахаас өмнө боломжит асуудлуудыг илрүүлж, шийдвэрлэхийн тулд нарийн шалгалт хийх шаардлагатай.

Багаа бүрдүүлэхдээ шаардлагатай ур чадвар, туршлагыг ойлгож, хэн тэдгээрийг авчрах боломжтойг тодорхойлохын зэрэгцээ нөхөх шаардлагатай сул талуудыг таних нь чухал. Техникийн болон хөтөлбөрийн мэдлэгээс гадна олон багт захиргаа, санхүү, харилцаа холбооны ур чадвар шаардлагатай байдаг. Төслийн хэрэгцээ өөрчлөгдөхийн хэрээр багийн бүрэлдэхүүн CS мөчлөгийн явцад өөрчлөгдөж болно.

Багаа бүрдүүлэх явцад процедурын шударга байдлыг анхаарах нь чухал бөгөөд энэ нь эрх мэдлийн харилцааг эргэн харах, холбогдох оролцогчдыг төлөөлүүлэх, шийдвэр гаргах үйл явцыг баримтжуулах зэрэгтэй холбоотой. Өөр өөр бүлгүүд шийдвэр гаргах талаар өөр өөр хүлээлттэй байх магадлалтай тул энэ асуудлыг эртнээс хамтран тодорхойлох нь зүйтэй.

Мөн баг нь үнэн зөв зөвлөгөө өгөх чадвартай нэг эсвэл хэд хэдэн зөвлөхийг тодорхойлох боломжтой бөгөөд тэдгээр нь таны ажлыг эерэгээр нөлөөлөх нөлөө бүхий хүмүүс байх нь тохиромжтой. Оролцогч талуудын сүлжээг ойлгосны дараа

эдгээр хүмүүсийн зарим нь төслийн багийн нэг хэсэг байх ёстой эсэхийг дахин авч үзэж, хэрэв тийм бол оролцоход тулгарч болох саадыг хэрхэн даван туулахыг тодорхойлох нь чухал.

## ЭНЭ АЛХМЫН ХҮРЭЭНД ГАРАХ ҮР ДҮНГҮҮД:

- Төслийн зорилго, шийдвэр гаргагчид, шийдвэр гаргах үйл явц болон шаардлагатай шийдвэрүүдийг тодорхойлох.
- Оролцогч талуудыг тодорхойлж, оролцоход тулгарч болох саадыг даван туулахад дэмжлэг үзүүлэх.
- Төлөвлөлтийн багийг тодорхойлж, багийн ахлагч, үндсэн гишүүд болон зөвлөх гишүүдийг тодорхойлох.
- Төлөвлөлтийн багийн гишүүдийн чадавхи, шаардагдах ур чадваруудыг тодорхойлох.
- Багийн гишүүдийн үүрэг, хариуцлагыг тодорхой зааж өгөх.



PHOTO: FELIX YBULLA

## 1В. Алсын хараа, хамрах хүрээ, хамгаалах үнэт зүйлийг тодорхойлох

### Хамрах хүрээ

Та ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэхээ бодохоос өмнө ерөнхийдөө юу хийхийг хүсэж байгаа талаараа тодорхой ойлголттой байх хэрэгтэй. Энэ нь төслийн хамрах хүрээг тогтоож, бүх төлөвлөлтийн ажлын суурь болно. Төслийн **хамрах хүрээ** нь төлөвлөлтийн нөлөөлөхийг зорьж буй зүйлсийг тодорхойлдог боловч үйл ажиллагаа хаана явагдахыг заавал хязгаарлахгүй. Хамрах хүрээний гурван нийтлэг хувилбар байдаг.

- **Газар нутгийн хамрах хүрээ** (Place-based scope) нь тодорхой газарзүйн бүсэд төвлөрч, экобүс нутаг, экосистем, тэргүүлэх ач холбогдолтой бүс нутаг, эсвэл хамгаалалттай газар нутгийг хамгаалах, удирдах үйл ажиллагааг хамардаг. Жишээлбэл, үндэсний парк нь өөрийн хил доторх олон экосистем болон биологийн олон янз байдлыг хамарсан газарзүйн чиглэсэн хамрах хүрээний жишээ юм.
- **Хамгаалах үнэт зүйлд төвлөрсөн хамрах хүрээ** (Focal value-based scopes) нь тодорхой зүйл эсвэл экосистемд төвлөрдөг. Зүйлд төвлөрсөн хамрах хүрээ нь тухайн зүйлийн амьдралын түүхийн хэсэг эсвэл бүхэлд нь холбогдох газарзүйн хүрээнд хамарч болно. Жишээлбэл, олон газар нутгийг хамарсан барын тоо толгойг өсгөхөд чиглэсэн дэлхийн барын хөтөлбөр нь зүйлд төвлөрсөн хамрах хүрээний жишээ юм. Экосистемд төвлөрсөн хамрах хүрээний жишээнд Азийн мангров ой болон дэлхийн өвсөн тал нутгийг хамгаалах үйл ажиллагаа багтана.
- **Сэдэвчилсэн хамрах хүрээ** (Thematic-based scopes) нь тодорхой аюул, дарамт, боломж, эсвэл дэмжих нөхцөлүүдийг шийдвэрлэхэд чиглэдэг. Жишээлбэл, Европын Холбоонд мод импортлохыг бууруулах зорилготой хууль бус мод бэлтгэлийг багасгах төсөл, эсвэл тээвэр, орон сууц, хүнс, эрчим хүчний үйлдвэрлэлээс гарах үндэсний CO2 ялгаруулалтыг бууруулах уур амьсгалын хөтөлбөр нь сэдэвт төвлөрсөн хамрах хүрээний жишээ юм.

Газарзүйн үл мөртэй төслүүдийн хувьд (сэдэвт төвлөрсөн байсан ч) гол байгаль хамгааллыг хэрэгжүүлэх баг, газар нутаг, экологийн онцлог болон нийгэм-сөрөг хүчин зүйлсийг багтаасан орон зайн зураг боловсруулах нь ихэвчлэн ашигтай байдаг. Ийм зураг боловсруулах нь төслийн бүс нутагт нэмэлт

### ХАЙРЦАГ 4

## ЗАН ҮЙЛИЙН ӨӨРЧЛӨЛТ ГЭЖ ЮУ ВЭ, ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

Байгаль хамгааллын сорилтуудын ихэнх нь хүний зан үйлтэй холбоотой байдаг. Байгаль хамгааллын зорилгод хүрэхэд ямар зан үйл дэмжлэг болох эсвэл саад болох вэ гэдгийг системийн түвшинд авч үзэх хэрэгтэй. **Зан үйлийн өөрчлөлт** гэдэг нь хүмүүсийн хийдэг үйлдлийг өөрчлөх үйл явц юм. Үүнд одоогийн зан үйлийг нэмэгдүүлэх, хадгалах, бууруулах эсвэл шинэ зан үйл нэвтрүүлэх орно. Хүний зан үйлийг өөрчлөхийг зорихдоо тухайн зан үйл ямар нийгмийн, соёлын, улс төрийн, эдийн засгийн орчинд явагдаж байгааг ойлгох нь чухал. Үүнд таны зорилго гол оролцогч талуудын зорилготой нийцэж байгаа эсэхийг мэдэх, 'Зөв' зан үйл гэж үзэхдээ өөрийн хандлага ба эрх мэдлийн тэнцвэрийг эргэцүүлэх, сайн үйл хийхийн оронд хохирол учруулах эрсдэл байгааг анхаарах зэрэг багтана. Зан үйлийн өөрчлөлтийн үйл ажиллагаа нь ил тод, оролцоог хангахуйц байх ёстой бөгөөд судалгаа, оролцоо, харилцаа холбоо, үнэлгээний ёс зүйн зарчмыг дагаж мөрдөх шаардлагатай.


хамтрагчид, үнэт зүйлс болон аюулуудыг авч үзэх шаардлагыг тодорхойлоход тусална.

Таны тодорхойлсон хамрах хүрээ ямар ч бай, байгаль хамгааллын сорилтыг шийдвэрлэхийн тулд хүний зан үйлийг нэг буюу хэд хэдэн түвшинд (Хайрцаг 4) ойлгож, өөрчилж эсвэл дэмжих шаардлагатай байдаг. Хүссэн үр нөлөөгөө гаргахын тулд та тохирох хэмжээнд ажиллах хэрэгтэй бөгөөд жишээлбэл (жишээ нь та тусгай хамгаалалттай газрын сүлжээнд хувь нэмэр оруулахын тулд олон улсын тусгай хамгаалалттай газрын төсөл хооронд ажиллах шаардлагатай байж болно). Мөн ажлынхаа хугацааны хэмжээсийг бодолцох хэрэгтэй, учир нь энэ нь таны хүрч чадах үр дүнд нөлөөлнө. Ихэнх тохиолдолд нэг эсвэл таван жилийн төсөл нь экосистем эсвэл зүйлийн амьдрах чадварт томоохон өөрчлөлт авчрахгүй, харин хүний зан үйл болон бодлогын өөрчлөлтөд нөлөөлж, эцэстээ экосистем эсвэл зүйлийн амьдрах чадварт нөлөөлөх боломжтой.

Хүмүүсийн байгаль хамгааллын ажлын үр дүнд гүйцэтгэх үүрэг олон талтай байдаг бөгөөд төлөвлөлтийн баг төлөвлөгөөгөө боловсруулахдаа хүний сайн сайхныг хамтатган авч үзэх нь түгээмэл. Хүний сайн сайхны төлөөх зорилт нь байгаль хамгааллын асуудалтай зэрэг авч үзэх нь хамгийн тохиромжтой боловч энэ нь өөр өөр ур чадвар болон нэмэлт нөөц шаарддаг. Иймээс үүнийг хүлээн зөвшөөрч, төлөвлөлтөд хамаарах болон хамаарахгүй зүйлсийг тодорхой зааглах нь чухал.

## Алсын хараа

Хамрах хүрээг тодорхойлохоос гадна нийтлэг алсын харааг тогтоох шаардлагатай. **Алсын хараа** гэдэг нь таны хүрэхийг зорьж буй нөхцөлийн тодорхойлолт юм. Та алсын хараагаа *харьцангуй ерөнхий, урам зориг өгөхүйц, товч* байдлаар (Энэ шалгуурын тайлбарыг [Хавсралт 2](#)-т үзнэ үү) алсын харааг илэрхийлнэ. Төлөвлөгөөний алсын хараа нь танай байгууллагын эрхэм зорилго, оролоцогч талуудын хэрэгцээ, сонирхлыг харгалзсан байх ёстой.



## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ХАРГАЛЗАН ҮЗЭХ НЬ 1

### ХАМРАХ ХҮРЭЭ, АЛСЫН ХАРАА

Төлөвлөгөөний хамрах хүрээг тодорхойлохдоо биологийн олон янз байдлыг хамгаалахад төвлөрч байгаа эсэхээ, мөн уур амьсгалын өөрчлөлт таны хамгаалахаар сонгосон үнэт зүйлүүдэд хэрхэн нөлөөлөхийг харгалзан үзэх шаардлагатай. Үүний зэрэгцээ экосистемийг хамгаалж, нөхөн сэргээх замаар хүний амьдралд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулахад (өөрөөр хэлбэл, экосистемд суурилсан дасан зохицол) төвлөрч байгаа эсэхээ харгалзах хэрэгтэй. Мөн төлөвлөгөөнийхөө гол зорилгын нэг нь байгальд суурилсан шийдлүүдийг ашиглан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, зайлсхийх зэргийг тодорхойлох нь чухал.

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн гарах шийдвэр нь төлөвлөгөө боловсруулах газар нутгийн хамрах хүрээг өөрчлөх зэрэгт нөлөөлж болзошгүй. Та зөвхөн өнөөдрийн нөхцөл байдлыг бус, уур амьсгал өнгөрсөн хугацаанд хэрхэн өөрчлөгдсөн болон цаашид хэрхэн өөрчлөгдөх магадлалтайг бодолцох хэрэгтэй. Үүнд экосистем эсвэл зүйлийн тархалт өргөргийн дагуу эсвэл өндрийн дагуу шилжих эсэх, эсвэл экосистем доторх зүйлүүдийн тархалт өөрчлөгдөх магадлал гэх мэт ч багтана. Мөн ирээдүйд хүний хэрэгцээ болон уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх хариу үйлдлийг харгалзан үзэх нь чухал.

Алсын хараа нь ирээдүйд чиглэсэн байх ёстой бөгөөд төсөөлөгдөж буй уур амьсгалын нөхцөл байдлыг харгалзан үзсэн ирээдүйн экологийн нөхцөл байдлыг тодорхойлно. Эдгээр төсөөллийг үндэслэн та ирээдүйн экологийн төлөвийг зөвхөн тоо хэмжээний хувьд бус, харин экосистемийн бүтэц, үйл ажиллагаа, процессын хувьд тодорхойлох шаардлагатай байж магадгүй.

## Хамгаалах үнэт зүйл

**Хамгаалах үнэт зүйл** гэдэг нь төлөвлөлтийн эцсийн нөлөө үзүүлэхийг зорьж буй зүйл юм. Энэ нь ихэвчлэн системийг төлөөлөхүйц зүйлээр тодорхойлогдоно. Хамгаалах үнэт зүйлст биологийн олон янз байдал (жишээ нь: зүйл, амьдрах орчин, эсвэл экосистем), уур амьсгалын үнэт зүйлс, соёлын үнэт зүйлс, хүний сайн сайхны төлөөх зорилт зэрэг багтдаг. Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт 5.0 хувилбарт өмнө хэрэглэж байсан “хамгаалах үнэт зүйл” (target) гэсэн нэр томъёог “хамгаалах үнэт зүйл” (focal value) гэж орлуулан ашиглаж байна.

## Биологийн олон янз байдлын хамгаалах үнэт зүйл

Таны баг төслийн хамрах хүрээгээ тодорхой болгосны дараа хязгаарлагдмал тооны **хамгаалах үнэт зүйлсийг** (экологийн гол үнэт зүйлс гэж ч нэрлэдэг) сонгох шаардлагатай<sup>6</sup>. Эдгээр нь төслийн хүрээнд хамгаалахаар ажиллаж буй тодорхой, бодит объектууд бөгөөд төслийн эцсийн зорилгыг төлөөлж, хамардаг. Тэдгээр нь зорилго тодорхойлох, үйл ажиллагаа сонгох, нөлөөллийг хэмжих үндэс болдог.

- **Хамгаалал үнэт зүйлсийн нарийвчлал нь төслийн хамрах хүрээ болон төрөлд харилцан адилгүй байна:** Газарт суурилсан эсвэл үнэт зүйлд суурилсан төслүүдийн хувьд биологийн гол үнэт зүйлс нь экосистем, амьдрах орчин, эсвэл тодорхой зүйлүүд байж болно. Эдгээр нь тухайн хамрах хүрээнд бүхэлдээ биологийн олон янз байдлыг төлөөлөх бөгөөд сонгосон гол үнэт зүйлсийг хамгаалснаар онолын хувьд хамрах хүрээнд багтах бүх экосистем, зүйлсийг хамгаалах боломжтой. Ихэнх газарт суурилсан төслүүдийг наймаас хэтрэхгүй сайн сонгосон гол үнэт зүйлсээр тодорхойлох боломжтой. Томоохон хэмжээний төслүүдийн хувьд илүү олон эсвэл ерөнхийлсөн гол үнэт зүйлс (жишээ нь: тодорхой зүйлээс илүү зүйлсийн бүлэг) шаардлагатай байж болно. Зарим төсөл ганцхан гол үнэт зүйлд төвлөрч болох бөгөөд энэ нь нэр хүндтэй бэлгэдэл зүйл (жишээ нь: бар) эсвэл экосистем (жишээ нь: мангров ой) байж болно.

- **Сэдэвт суурилсан төслүүдийн хувьд гол анхаарал нь биологийн олон янз байдлын үнэт зүйлтэй холбоотой тодорхой хүчин зүйлд чиглэнэ.** Үүнд заналхийлэл, нөлөөлөгч хүчин зүйл, эсвэл экосистемийн үйлчилгээ багтаж болно. Нөхцөл байдлаас хамааран багууд эцсийн дүнд нөлөөлөхийг зорьж буй тодорхой экосистемийн шинж чанар эсвэл зүйлсийг тодорхойлох, эсвэл ерөнхийд нь “биологийн олон янз байдал” эсвэл “байгалийн нөөц” гэж нэрлэх боломжтой.

Биологийн олон янз байдлын гол үнэт зүйлсийг сонгохдоо олон төрлийн мэдлэгийн системийн мэргэжилтнүүдийн оролцоо шаардлагатай байдаг. Гол үнэт зүйлийн одоогийн газарзүйн тархалтыг, мөн түүхэн болон ирээдүйд өөр өөр хувилбарын дагуу хэрхэн өөрчлөгдөхийг зураглах нь ашигтай. Жишээ нь, Алхам 1С-ийн [Зураг 4](#) -д ийм зураглалын жишээ үзүүлсэн байдаг. Хэрэв таны сонгосон гол үнэт зүйл өргөн тархалттай бол (жишээ нь: нүүдлийн зүйл эсвэл бүхэл бүтэн экосистемийн төрөл), түүнийг тодорхой орон зайн дэд үнэт зүйлс болгон хуваах нь зүйтэй байж болно. Үүнд тодорхой популяци эсвэл амьдралын мөчлөгийн үе шат (жишээ нь: үржлийн газар, нүүдлийн зам, өвөлжих газар) багтаж болно. Энэ үйл явцыг хөнгөвчлөхөд орон зайн өгөгдлийн сангуудыг ашиглах боломжтой.

Ихэнх тохиолдолд та хамгаалалх үнэт зүйл бүрийн одоогийн төлөвийг тодорхойлох хэрэгтэй. Хамгийн энгийн түвшинд энэ нь хамгийн сайн боломжтой нотолгоог ашиглан (жишээ нь: нотолгооны санг ашиглах, уламжлалт экологийн мэдлэг эзэмшигчдээс зөвлөгөө авах) тухайн үнэт зүйлийн эрүүл мэнд буюу “амьдрах чадвар”-ын ерөнхий үнэлгээг гаргах явдал юм. Илүү нарийвчилсан үнэлгээ хийхдээ тухайн гол үнэт зүйлийн гол **экологийн шинж чанаруудыг** тодорхойлох, шинж чанар бүрт тохирох үзүүлэлтүүдийг тогтоох, үзүүлэлт бүрийн зөвшөөрөгдөх хэлбэлзлийн хүрээг тодорхойлох, мөн тухайн үзүүлэлтийн одоогийн төлөвийг энэ хүрээтэй харьцуулан үнэлэх шаардлагатай. Олон гол шинж чанарыг газарзүйн өгөгдлийн үзүүлэлтээр тоон хэлбэрт оруулж болно (жишээ нь: амьдрах орчны хэмжээ, зүйлсийн тархалт, холбогдол). Газарзүйн өгөгдлийн сангууд нь эдгээр мэдээллийг олоход тохиромжтой эх сурвалж болдог. Амьдрах чадварын үнэлгээ нь хамгаалах үнэт зүйлсийн зорилго тодорхойлох, тэдгээрийн төлөвийг хянах, мөн гол заналхийллийг ойлгох үндэс суурийг бүрдүүлдэг.

6 5.0 хувилбарт бид өмнө хэрэглэж байсан Target буюу хамгаалах үнэт зүйлийг focal value гэж нэрлэсэн (Монгол хэл дээр өөрчлөгдөөгүй). Энэ өөрчлөлт нь Биологийн олон янз байдлын тухай конвенц болон хамгаалалттай газар нутгийн "Value" гэж нэрлэдэг бусад олон аргачлалуудтай нийцүүлэх зорилготойг өөрчилсөн. Харин Target гэсэн утга нь нь УХААЛАГ зорилго эсвэл зорилтын ирээдүйн хэмжүүрийг илэрхийлэхэд хэрэглэгддэг (жишээлбэл, 30 x 30 зорилт).

## Хүний сайн сайхны төлөөх зорилт

Байгаль хамгааллын ажил нь нийгмийн асуудалтай хамааралтай байдаг учраас төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн үр дүн хүмүүст хэрхэн нөлөөлж болох, мөн таны хийж буй ажил хүмүүсийн амьдралд шууд хэрхэн нөлөөлж байгааг харуулах нь чухал<sup>7</sup> Хамгаалах үнэт зүйлсийг тодорхойлох, нөхцөл байдлын дүн шинжилгээ боловсруулах үйл явцын нэг хэсэг болгон хүний сайн сайхны гол үнэт зүйлсийг багтаахыг бодолцох хэрэгтэй, энэ үед таны **хүний сайн сайхны төлөөх зорилт** нь ихэвчлэн хамгаалах үнэт зүйлсийн төлөв болон холбогдох **экосистемийн үйлчилгээний** нөлөөнд өртдөг хүний сайн сайхны бүрэлдэхүүн хэсгүүдийг хамардаг (Хайрцаг 5), жишээлбэл бие махбодын, сэтгэцийн болон сүнслэг эрүүл мэнд, амьжиргаа ба материаллаг сайн сайхан байдал, нийгмийн харилцаа, соёлын үнэт зүйл, соёлын онцлог, аюулгүй байдал зэрэг бөгөөд **Зураг 3** нь эдгээр ерөнхий харилцааг харуулж, биологийн олон янз байдал болон хүний сайн сайхны төлөөхи зорилт нь харилцан хэрхэн нөлөөлж болохыг үзүүлдэг, хүний сайн сайхны гол үнэт зүйлсийг тодорхойлох нь орон зайн аргачлалыг ашиглахад тохиромжтой өөр нэг боломж болж, энэ нь таны багт экосистемийн үйлчилгээ болон хүний сайн сайханд нөлөөлж болох бусад хүчин зүйлсийг дүрслэн харуулах, илүү сайн ойлгоход тусалдаг.

### ХАЙРЦАГ 5

## ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД АВЧ ҮЗДЭГ ХҮНИЙ САЙН САЙХНЫ ТӨЛӨӨХ ЗОРИЛТЫГ ХОЛБОЖ ОЙЛГОХ НЬ


Хүний сайн сайхны төлөөх зорилт болон хамгаалах үнэт зүйлүүдийг сонгохдоо мэргэжилтнүүд төлөвлөгөөг олон улсад хэрэглэгдэж буй санаачилгуудтай хэрхэн уялдаж, ямар хувь нэмэр оруулж байгааг харгалзан үзэх хэрэгтэй. Эдгээр аргачлал, заавруудын тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх, илүү тогтвортой ирээдүйг хангахын тулд хүний сайн сайхныг дээшлүүлэх, байгаль орчны доройтлыг бууруулах, хоёуланг нь оновчтой болгох нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг дэмжих зорилготой. Тиймээс төлөвлөлтийн багийн ашиглаж болох гарын авлагад Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой Хөгжлийн Зорилтууд, Куньмин-Монреалын Дэлхийн Биологийн Олон Янз Байдлын Хамрах хүрээ, НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөрийн “Шинэ Хэтийн Төлөв”, Байгаль хамгаалах олон улсын холбоо (IUCN)-ын “Байгаль, соёлын соёлын ач холбогдол” зэрэг баримт бичгүүд багтдаг.



PHOTO: FELIX СУВИЦА

**ЗУРАГ 3**

**Нөхцөл байдлын ерөнхий загвар дахь Хамрах хүрээ, Алсын хараа, Хамгаалах үнэт зүйлийн харагдах байдал**



Стратеги боловсруулах явцдаа хамгааллын үйл ажиллагаанаас шууд ашиг хүртэх хүний сайн сайхны төлөөх зорилтыг багтаахыг хүсэж болох юм. Байгаль хамгааллын ажлын үр дүнд ихэвчлэн биологийн олон янз байдлыг хамгаалах, хүний сайн сайхныг нэмэгдүүлэх тэнцвэрийг хангахыг зорьдог. Ингэснээр байгальд суурилсан үйл ажиллагаа нь байгалийн нөөцөд тулгуурлан амьдарч буй олон нийтийн урт хугацааны сайн сайханд хувь нэмэр оруулдаг. Төлөвлөлтийн багийн үндсэн чиглэлээс хамааран хүний сайн сайхны төлөөх зорилт, хамгаалах үнэт зүйлсийг хамтад нь нэг түвшинд авч үзэх хэрэгтэй. Тиймээс эдгээрийг сонгохдоо оролцогч талуудтай хамтран сонгох ёстойг анхаараарай. Хүний сайн сайхны төлөөх зорилтыг сонгосон эсэхээс үл хамааран байгаль хамгааллын ажлууд нь хүмүүсийн амьдралд эерэг болон сөрөг аль алианаар нь хэрхэн нөлөөлөхийг бодолцож байх нь чухал юм.





PHOTO: FELIX CUBULLA

## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ХАРГАЛЗАН ҮЗЭХ НЬ 2

### ХАМГААЛАХ ҮНЭТ ЗҮЙЛ

Төлөвлөлтийн явцад уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг авч үзэхдээ та дараах зүйлсийг үнэлэх шаардлагатай. Үүнд:

- Тухайн төлөвлөлтийн газар зүйн хамрах хүрээн дэх экосистем, амьдрах орчин болон амьтан, ургамлын зүйлүүд ирээдүйд хэвээр үлдэх эсэх;
- Уур амьсгалын өөрчлөлт нь биологийн олон янз байдал, хүний сайн сайхны төлөөх зорилтод хэрхэн нөлөө үзүүлж болох,
- Таамагласан өөрчлөлтийн хүрээнд авахаар төлөвлөсөн арга хэмжээ нь хамгаалах үнэт зүйлсийг хадгалах, сайжруулахад үр дүнтэй байж чадах эсэх.

Эдгээрийг үнэлсний дараа хамрах хүрээ болон хамгаалах үнэт зүйлсээ дахин нэг эргэж хараарай

Хүлэмжийн хийн ялгаралтаас зайлсхийх, бууруулах эсвэл шингээхүндсэн зорилготой төслүүдийн хувьд төлөвлөлтийн баг хамгаалах, эсвэл нөхөн сэргээх экосистемүүдийг хамгаалах үнэт зүйлийн нэг болгон багтаах хэрэгтэй.

### ЭНЭ АЛХАМД ГАРАХ ҮР ДҮНГҮҮД:

- Төлөвлөлт хийх хамрах хүрээний товч тайлбар, шаардлагатай бол газрын зурагтай хамт боловсруулагдсан,
- Алсын харааны тодорхойлолт,
- Хамгаалах үнэт зүйлүүдийн сонголт, яагаад сонгосон тухай товч тайлбар, шаардлагатай бол тухайн хамгаалах үнэт зүйлийн байршлыг харуулсан тайлбар болон/эсвэл газрын зураг,
- Хүний сайн сайхны төлөөх зорилтын сонгогдсон, холбогдох экосистемийн үйлчилгээний тодорхойлолт боловсруулагдсан,
- Нэн тэргүүний хамгаалах үнэт зүйл, түүний амьдрах чадварын төлөв байдлын тайлбар



## 1С. Аюул, дарамтыг тодорхойлох

Хамгаалах үнэт зүйлүүдээ тодорхойлсны дараа нөлөө үзүүлж буй шууд аюул, дарамтыг<sup>8</sup> тэдгээрийг үүсгэж буй буй шалтгаануудыг тодорхойлохын тулд боломжит нотолгоог ашиглах хэрэгтэй. **Шууд аюул, дарамт** гэдэг нь нэг буюу хэд хэдэн хамгаалах үнэт зүйлийг шууд доройтуулах хүний үйлдэл (зан үйл) юм. Жишээлбэл: зохион байгуулалтгүй загасчлал, агнуур, газрын тос олборлолт, үйлдвэрийн бохир усны хаягдал, эсвэл харь зүйл зэрэг болно. Шууд аюул, дарамт нь хүний үйл ажиллагааны улмаас үүдэлтэй байгалийн үзэгдэл байж болно.

Жишээлбэл, уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан хүчтэй шуурган эсвэл гангийн давтамж нэмэгдэх зэрэг. [IUCN–CMP Шууд аюул, дарамтын ангиллын](#) жишээг харна уу. Боломжтой тохиолдолд заналхийллийн орон зайн ул мөрийг зураглах нь тустай. Ингэснээр гол заналхийлэл болон тэдгээрийн шалтгааныг илүү сайн ойлгоход тусална (жишээ нь: шимпанзе хамгааллын төсөлд ашигласан 4-р зурагт харуулсан жишээг үзнэ үү).

ЗУРАГ 4

Шимпанзег хамгаалах үнэт зүйлээр сонгосон газар нутаг дахь аюул, дарамтыг харуулсан зураглал



Шимпанзегийн амьдрах орчин

Газар тариалангаас үүдэлтэй амьдрах орчны хуваагдал, өөрчлөлтийн аюул, дарамт

Эх үүсвэр: Лилиан Пинтеагийн Байгаль хамгааллын стандарт хэрэглэсэн жишээнээс авав Jane Goodall Institute

Аюул, дарамтыг тодорхойлохдоо тухайн дарамтыг хэн үүсгэж буйг тодорхой болгох нь чаухал. Жишээлбэл, компаниуд, хууль бус загасчид, анчид гэх мэт. Зарим аюул, дарамтыг үүсгэж буй этгээдүүд нь ижил эсэхээс хамааран нэгтгэж эсвэл салгаж авч үзэж болно.

Жишээлбэл, “хууль бус агнуур”-ыг “зохион байгуулалттай бүлэглэлүүдийн хууль бус агнуур” болон “орон нутгийн иргэдийн хууль бус агнуур” гэж салгаж болно. тодорхой байлгах нь оролцогч талуудын үнэлгээ хийх болон стратеги боловсруулахад чухал хэрэгтэй.

8 Зарим тохиолдолд аюул, дарамт (threat) гэсэн нэр томъёо нь тухайн талууд (жишээ нь: малчид, мод бэлтгэгчид) өөрсдийн үйл ажиллагаа эсвэл мэргэжил нь аюул гэж тодорхойлогдох үед таатай хүлээж авахгүй байж болох тул ‘дарамт’ (pressure) гэсэн ижил утгатай нэр томъёог ашиглах нь тустай. Мөн аюул, дарамтын шинж чанарыг тодруулахын тулд ‘тогтвортой бус’ (unsustainable), ‘хууль бус’ (illegal) гэх мэт тодотгол үгсийг ашиглах нь үр дүнтэй (жишээ нь: тогтвортойгүй мал аж ахуй).



PHOTO: ASHBAKER

## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ХАРГАЛЗАН ҮЗЭХ НЬ 3

### УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН АЮУЛ, ДАРАМТ БА ТҮҮНИЙ НӨЛӨӨЛЛИЙГ ҮНЭЛЭХ НЬ

Уур амьсгалын өөрчлөлт нь хамгаалах үнэт зүйлд шинээр аюул, дарамт үүсгэхээс гадна уламжлалт (уур амьсгалтай холбоогүй) аюул, дарамтыг улам хурцатгах, эсвэл ижил биофизик хүчин зүйл дээр уламжлалт аюул, дарамттай харилцан үйлчилж эрчийг нэмэгдүүлж болно. Жишээлбэл, далайн усны түвшин нэмэгдэх, далайн эрэг орчим дах бүтээн байгуулалт нь хоёулаа эрэг орчмын ус намгархаг газрын ач холбогдлыг бууруулдаг. Биофизик хүчин зүйл гэдэг нь амьд (биотик) эсвэл амьгүй (абиотик) хүчин зүйл бөгөөд шууд аюул, дарамт нь хамгаалах үнэт зүйлд хэрхэн нөлөөлж байгааг тодруулахад тусалдаг. Энэ жишээнд холбоос нутаг (connectivity) нь **биофизикхүчин** зүйл юм.

Уур амьсгалын өөрчлөлт нь хамгаалах үнэт зүйлүүд, экосистем, хүмүүст хэрхэн нөлөө үзүүлж буйг таньж судлах нь чухал. Мөн уур амьсгалын өөрчлөлтөд хүмүүсийн авч буй буруу хариу үйлдэл түүнээс, үүсэх нөлөөллийг (жишээлбэл, далайн усны түвшин нэмэгдэхэд далан барих барих нь оновчгүй арга хэмжээ) харгалзах хэрэгтэй. Үүнийг хийхийн таамгалаж буй уур амьсгалын тодорхой өөрчлөлтүүдийг (уур амьсгалын аюул, дарамт, температурын өсөлт, хур тунадасны өөрчлөлт, онцгой цаг агаарын үзэгдэл, далайн хүчиллэгжилт, далайн усны түвшин нэмэгдэх гэх мэт) тодорхойлж, тэдгээр нь хамгаалах үнэт зүйлд хэрхэн нөлөөлөхийг үнэлэх шаардлагатай. Энэ нь шууд (жишээлбэл, температур нэмэгдэж, хур тунадас багассанаар ой хээрийн түймэрт өртөмтгий байдал нэмэгдэх) эсвэл шууд бус (жишээлбэл, гангийн давтамж нэмэгдэж байгаа тул хүмүүс ус хуримтлуулахын тулд далан барихыг хүсэх бөгөөд энэ нь цэнгэг усны системд сөргөөр нөлөөлөх) байж болно. Мөн уур амьсгалын өөрчлөлтийн аюул, дарамт нь уур амьсгалтай холбоогүй аюул, дарамттай хэрхэн харилцан үйлчилж байгааг тодорхойлох хэрэгтэй. Уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдлын үнэлгээ нь хэрэгтэй нэмэлт арга хэрэгсэл байж болох ч энэ нь зөвхөн уур амьсгалын аюул, дарамтад төвлөрдөг бөгөөд уламжлалт аюул, дарамттай хэрхэн харилцан үйлчилж байгааг хамардаггүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

Уур амьсгалын өөрчлөлтийн аюул, дарамтын биофизик нөлөөллийг ойлгох нь чухал. Учир нь таны анхаарах зүйл нь аюул, дарамтыг бууруулах бус, харин тэдгээрийн нөлөөнд нөлөөлөх явдал байх магадлалтай. Жишээлбэл, төлөвлөлтийн баг температурын өсөлтийг өөрчлөх боломжгүй ч экосистемийн бүрэлдэхүүнд хэрхэн нөлөөлж байгааг шинжилсний дараа ганд тэсвэртэй ургамлын зүйлийг тарьж нөхөн сэргээх шийдвэр гаргаж болно.

Үйл ажиллагаа болон нөөц боломжоо хамгийн их шаардлагатай хэсэгт төвлөрүүлэхийн тулд хамгаалах үнэт зүйлд нөлөөлж буй шууд аюул, дарамтыг эрэмбэлэх нь чухал. Ялангуяа хамгийн чухал буюу зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай **аюул, дарамтыг** тодорхойлох хэрэгтэй. Эрэмбэлэхдээ үнэлгээний олон аргуудыг ашигла. Аюул, дарамтын хамрах хүрээ болон нөлөөлөх ноцтой байдлыг харгалзан үздэг. Эдгээр хоёр шалгуурыг хамтад нь авч үзэхэд аюул, дарамтын нөлөөллийн хүч тодорхойлогдоно. Мөн нэмж хэрэглэдэг шалгуурт тогтвортой байдал/буцааж сэргээх боломжгүй байдал, хир яаралтай вэ зэрэг орно. Аюул, дарамтыг эрэмбэлэх нийтлэг аргууд: аюул, дарамт бүрийг өөр өөр хамгаалах үнэт зүйлд хэрхэн нөлөөлж байгаагаар нь үнэлэх абсолют үнэлгээ, хамгаалах үнэт зүйлд нөлөөлж буй экологийн чухал хүчин зүйлүүдийг авч үзэн, тухайн стрессэд янз бүрийн аюул, дарамт хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх **стрессэд** суурилсан үнэлгээ, аюул, дарамтуудыг хооронд нь харьцуулан эрэмбэлэх харьцуулсан эрэмбэлэлт зэрэг орно. Шууд аюул, дарамтын бүхий л хувилбарыг авч үзэх хэрэгтэй. Төлөвлөлтийн баг эсвэл байгууллага урьдчилан таамаглаж шийдвэрлэх чадвартай аюул, дарамтаар хязгаарлагдах ёсгүй. Хэрэв хүний сайн сайхны төлөөх зорилт нь тодорхой нэг онцгой ач холбогдолтой бол тухайн хэсэгт чиглэсэн аюул, дарамтыг үнэлэх шаардлагатай. Энэ тохиолдолд аюул, дарамт нь хүний сайн сайханд болон хамгаалах үнэт зүйлд хэрхэн өөр өөрөөр нөлөөлж байгааг харгалзан үзэх хэрэгтэй.



PHOTO: JASON HOUSTON FOR USAID

## ЭНЭ АЛХАМД ГАРАХ ҮР ДҮНГҮҮД:

- Шууд аюул, дарамтыг тодорхойлох, шаардлагатай тохиолдолд гол аюул, дарамт хамгаалах үнэт зүйлтэй хэрхэн огтлолцож байгааг харуулсан орон зайн зураглал хийх.
- Уур амьсгалын аюул, дарамтын биофизик нөлөөг тодорхойлох ба уур амьсгалын з болон уламжлалт аюул дарамтын харилцан үйлчлэлийг үнэлэх;
- Шууд аюул, дарамтын үнэлж, ангилах

## 1D. Нөхцөл байдлыг тодорхойлох

### Нөхцөл байдлын дүн шинжилгээ

Энэ дэд алхам нь төлөвлөгөөний хамрах хүрээ, хамгаалах үнэт зүйл болон шууд аюул, дарамттай холбоотой өмнө хийсэн ажлууд дээр тулгуурлана. Эдгээр нь **нөхцөл байдлын дүн шинжилгээний** бүрэлдэхүүн хэсэг бөгөөд төлөвлөлтийн баг болон хамтрагч талуудад биологийн, нийгмийн, эдийн засгийн, улс төрийн, институцийн системүүд (мөн холбогдох талууд) хамгаалах үнэт зүйлд хэрхэн нөлөөлж байгааг хамтдаа ойлгоход тусалдаг. Нөхцөл байдал, зан үйл болон гол хамтран ажиллах тал хэн бэ гэдгийг ойлгосноор та хамгааллын зорилго, зорилтуудаа хэрэгжүүлэхэд илүү оновчтой арга хэмжээ боловсруулах боломжтой болно.

Төлөвлөгөөний хамрах хүрээ болон нөөцөөс хамааран нөхцөл байдлын дүн шинжилгээ нь нарийвчилсан, албан ёсны судалгаа байж болохоос гадна тухайн нөхцөл байдлыг сайн мэддэг хүмүүсийн оролцоонд тулгуурласан энгийн тайлбар ч байж болно. Энэ дэд алхамд та боломжтой нотолгоог дахин авч үзэж, шууд аюул, дарамтыг бий болгож буй **гол хүчин зүйлсийг** тодорхойлох хэрэгтэй. Үүнд **шууд бус аюул, дарамт** (үндсэн шалтгаан, **хөдөлгөгч хүчин зүйл**), **боломжууд** болон биофизик хүчин зүйлс багтана. Боломжтой тохиолдолд эдгээр хүчин зүйлсийг өдөөж буй цаадах эгтгээдүүдийг тодорхойлох нь ойлгомжтой байхад тустай. Мөн мэдээл дутмаг байгаа хэсгийг тэмдэглэж үлдээх хэрэгтэй.

Хэрэв төлөвлөлтийн баг илүү нарийвчилсан судалгаа хийхээр төлөвлөж байгаа бол зах зээлийн шинжилгээ, улс төр, эдийн засгийн шинжилгээ, оролцогч талуудын үнэлгээг хийдэг арга хэрэгсэл бий. Зах зээлийн дүн шинжилгээ нь хүний зан үйл эдийн засгийн урамшуулалд хэрхэн хариу үйлдэл үзүүлдэг, энэ зан үйл хамгаалах үнэт зүйлд хэрхэн сөргөөр нөлөөлж болохыг тодорхойлоход тусална. Улс төр, эдийн засгийн дүн шинжилгээ нь эрх мэдлийн харилцаа болон хөгжлийг тодорхойлж буй эдийн засаг, нийгмийн хүчин зүйлсийг судлахад сайн арга барил болдог. Оролцогч талуудын үнэлгээ нь гол аюул, дарамтыг бий болгож буй эгтгээдүүдийг ялгаж, тэдний үүрэг, гол ашиг сонирхол, нөлөөллийн түвшин, оролцооны боломжийг тодорхойлоход тусалдаг. Нөлөө бүхий талуудыг төдийгүй болон нөлөөнд өртөж эрх, ашиг нь хөндөгдөж буй талуудыг авч үзэх хэрэгтэй. Ялангуяа төлөвлөгөө боловсруулж буй баг нь шийдвэр гаргах явцад янз бүрийн талуудын төлөөлөл, оролцоо, эцэстээ тэдний сайн сайханд байдалд хэрхэн нөлөөлөхийг бодолцох хэрэгтэй.

Оролцогч талуудын үнэлгээ хийхдээ төслийн хувьд стратегийн түншүүд хэн байх магадлалтай ([Алхам 1A, Step 1A](#)), хэний зан үйлийг өөрчлөх, эсвэл хэний дуу хоолойг илүү тодруулахыг хүсэж байгаагаа анхаарах хэрэгтэй. Та бодлого боловсруулах, хууль хэрэгжүүлэх, корпорацийн үйл ажиллагаа, үйлдвэрлэгчийн сонголт, эсвэл хэрэглэгчийн шийдвэрт нөлөөлөхийг хүссэн ч энэ бүгд хүний хандлага, зан үйлийн өөрчлөлттэй холбоотой. Тиймээс эдгээрийг сайн ойлгох нь чухал. Үүнд хүний зан үйлийг өөрчлөхөд нөлөөлж буй сэдэл, саад бэрхшээл, орон нутгийн нөхцөл байдал багтана. Энэ ойлголт нь нөхцөл байдлын шинжилгээ хийх болон үр дүнтэй арга хэмжээ боловсруулахад тусална ([Алхам 2A](#)). Мөн **урьдчилан, бүрэн мэдээлэлтэй зөвшөөрөл** (Free, Prior, and Informed Consent – FPIC) авах эрхийг хангах нь зайлшгүй чухал. Ингэснээр орон нутгийн иргэдийн амьжиргаа, газар нутаг, байгалийн баялагт нөлөөлөх аливаа шийдвэр гаргах явцад тэдний эрхийг хамгаална.

### Нөхцөл байдлын загвар

Нөхцөл байдлын дүн шинжилгээнд тодорхойлсон аюул, дарамт, боломж болон гол нөлөө үзүүлэгч талуудыг нэгтгэн баримтжуулах нэг арга нь **нөхцөл байдлын загвар** боловсруулах явдал юм. Нөхцөл байдлын загвар нь шинжилгээнд багтсан янз бүрийн **хүчин зүйлсийн** хоорондын харилцааг дүрслэн харуулсан диаграмм байдаг (Жишээ нь: [Зураг 5](#) -д ерөнхий загвар, [Зураг 6](#) -д бодит жишээг харуулсан). Сайн загвар нь төлөвлөгөөний хамрах хүрээнд орших гол шалтгаан-үр дагавар, холбогдох талуудыг тодорхой харуулдаг. Энэ нь хамгийн чухал мэдээллийг багтаасан байх ёстой ч аль болох энгийн байх хэрэгтэй. Иймээс хамрах хүрээ том төлөвлөгөөний нөхцөл байдлын загвар нь жижиг хамрах хүрээтэй төслийн загвараас илүү өргөн хүрээнд хийгдэх шаардлагатай байж болно.

Нөхцөл байдлын загварыг бүх талууд хамтдаа хийх нь ойлголтыг нэгтгэхэд тустай. Мөн аль болох байгаа нотолгоо болон олон талын мэдлэгийн системд тулгуурлах хэрэгтэй. Нөхцөл байдлын орон зайн зураг гаргах нь ч бас хэрэгтэй байж болно.


Нөхцөл байдлын загвар болон орон зайн зураг хоёуланг нь гол нөлөөлөгч, оролцогч талууд хамтдаа дахин хянаж үзэх нь хамгийн тохиромжтой. Ингэснээр гаргасан бүтээгдэхүүн нь нөхцөл байдлын талаархи хамтын ойлголтыг илэрхийлж чадна.

ЗУРАГ 5


**Төслийн нөхцөл байдлын ерөнхий загвар**

Нөхцөл байдлын загварт “**хүчин зүйл**” гэдэг нь тухайн нөхцөл байдалд нөлөөлж буй аливаа нэг зүйлийг хэлнэ. Харин “**нөлөөлөх хүчин зүйл**” нь шууд аюул, дарамтад хүргэж буй шууд бус аюул, дарамт, боломж, эсвэл бусад нөлөөлөгч хүчин зүйлсийг хэлнэ.

Тасархайтсан зураас нь **тодорхойгүй байдлыг** илэрхийлнэ.



ЗУРАГ 6 Усны сав газрын нөхцөл байдлын дүн шинжилгээ



Нөхцөл байдлын загвараа боловсруулахдаа бий болгож буй хоорондын холбоосуудын нотолгоог тэмдэглэх хэрэгтэй. Энэ нотолгоо нь олон эх сурвалжаас ирж болно. Жишээлбэл, хэвлэгдсэн судалгааны бүтээл, судалгааны өгөгдөл, уламжлалт мэдлэг, мэргэжилтний санал, эсвэл оролцогч талуудаас өгөх мэдээлэл ч байж болох бөгөөд, баталгаажуулах түвшнээрээ ялгаатай байж болно. Зарим нь тодорхой, зарим нь тодорхойгүй байж болно. Та зөвхөн өөрийн мэдэж байгаа зүйлд төвлөрөхөөс зайлсхийх хэрэгтэй. Эдгээр харилцаа болон тэдгээрийн нотолгоог ил гаргах нь багт үйл ажиллагааг тодорхойлох, эрэмбэлэхэд тусална. Мөн нөхцөл байдлын загвар болон/эсвэл үр дүнгийн хэлхээ ([Алхам 2А](#))-д байгаа сул талуудыг илрүүлэх боломж олгоно.

Хэрэв төлөвлөлтийн баг нөхцөл байдлын загвартаа хүний сайн сайхны төлөөх зорилтыг багтаасан бол тухайн загвар дахь гол хүчин зүйлс эдгээр үнэт зүйлд хэрхэн нөлөөлж байгааг харуулах хэрэгтэй. Энэ нөлөө нь шууд байж болохоос гадна хамгаалах үнэт зүйл болон холбогдох **экосистемийн үйлчилгээний** төлөв байдлаар дамжин илэрч болно. Зураг 7-д биологийн олон янз байдалд учирч буй аюул дарамт нь хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж болох жишээг харуулсан. Мөн хамгаалах үнэт зүйл болон түүний экосистемийн үйлчилгээний төлөв байдал нь хүний сайн сайхны төлөөх зорилтод хэрхэн нөлөөлж болохыг харуулсан.

**ЗУРАГ 7** Хүний сайн сайхны төлөөх зорилтыг багтаасан нөхцөл байдлын загварын жишээ



**ТАНИХ ТЭМДЭГ**

Нөхцөлдүүлэгч хүчин зүйл	Шууд аюул, дарамт	Биофизик хүчин зүйл	Хамгаалах үнэт зүйл	Хүний сайн сайхны төлөөх зорилт

Энэхүү зураг нь таны биологийн олон янз байдлын хамгаалах үнэт зүйл болон хүний сайн сайхны төлөө зорилт хоорондын харилцааг өөр аргаар харуулах боломжийг олгож байгаа бөгөөд энэ нь бусад талуудад нийцэж болох юм. Дэлгэрэнгүй удирдамжийг CMP (2016) 'Incorporating Social Aspects and Human Wellbeing in Biodiversity Conservation Projects баримт бичгээс харна уу. (Энэхүү удирдамж цаг хугацааны явцад шинэчлэгдэх магадлалтай).

АГУУЛГА  
ТАНИЛЦУУЛГА  
Тодорхойлох  
1  
2  
Төлөвлөх  
3  
Хэрэгжүүлэх  
4  
ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ & ҮЙЛДҮҮЛЭХ  
5  
ХУВААЛЦАХ  
Төлөвлөлтийн мөчлөгийгт ЗАНГИДАХ нь  
ХАВСРАЛТ



PHOTO: JUSTIN GRUBB

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

**CS Library Resources - “Assess”** гэсэн шүүлтүүрийг ашиглаад, шаардлагатай бол удирдамж, тохиолдлын судалгаа болон бусад хайлтын үгсээр дотроос нь хайлт хийх.

**Recipes for Conservation: A Conservation Standards Toolkit** доторх холбогдох зөвлөмж (Tipsheets), мөн Examples & Resources зөвлөмжийн “Assess” хэсгүүд рүү орж ашиглах.

**Real-world Examples of Applications of the Conservation Standards** – Байгаль хамгаалалтын төлөвлөлтийн стандартыг бодит амьдрал дээр хэрхэн хэрэгжүүлсэн жишээнүүд.

## ЭНЭ АЛХАМД ГАРАХ ҮР ДҮНГҮҮД:

- Шууд бус аюул, дарамт болон боломжийг тодорхойлох, шинжлэх
- Оролоцогч талууд болон тэдний ашиг сонирхлыг үнэлэх
- Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх, эсвэл загвар, тайлбар, бусад дүрслэлээр төлөвлөгөөний нөхцөл байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийн гол шалтгаан-үр дагаврын харилцан хамаарлыг илэрхийлэх



# ТӨЛӨВЛӨХ



# ТӨЛӨВЛӨХ

Байгаль хамгааллын стандартын энэ алхамд **байгаль хамгааллын төлөвлөгөө** боловсруулна. Тодорхойлох алхамд хийсэн ажлын үр дүнд тулгуурлан төлөвлөгөөний хамрах хүрээ, хэрэгжүүлэх арга хэмжээ, өөрчлөлтийн онол, тэдгээртэй уялдсан зорилго, зорилтуудыг (өөрөөр хэлбэл, **стратегийн төлөвлөгөө**) тодорхойлно. Үүнээс гадна энэ алхамд хэрэгжилтийг хянах, үнэлэхэд шаардлагатай **мэдээллийн хэрэгцээ**, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж, тэдгээрийг хэрхэн хянаж үнэлэх (**мониторингийн төлөвлөгөө**), мөн байгууллагын болон нөхцөл байдлын бусад хүчин зүйлсийг харгалзан төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлэх (**үйл ажиллагааны төлөвлөгөө**) талаар тодорхой тусгана. Байгаль хамгааллын төлөвлөгөө нь стратеги мониторинг болон үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдээс (3-р алхамд дэлгэрэнгүй) бүрдэнэ (Зураг 8).

**ЗУРАГ 8** Төлөвлөгөө хоорондын уялдаа



Эх сурвалж: Stewart 2016. Operationalizing the Open Standards for the Practice of Conservation бүтээлээс хялбаршуулав

Байгаль хамгааллын стандартын алхам, дэд алхмуудын нэгэн адил энэ алхмын хүрээнд хийж буй ажлын ихэнх нь давтамжтай, уялдаа холбоотойгоор хийгдэнэ. Тухайлбал, та [2С алхамд](#) үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулдаг ч [2А алхамд](#) арга хэмжээг сонгох үед тогтвортой байдал,

**эрсдэл**, шилжилтийн төлөвлөгөө зэрэг асуудлыг давхар харгалзан үзэх шаардлага гарч болно. Эдгээр хүчин зүйлс нь баг болон удирдлагын түвшний шийдвэр гаргагчдад тодорхой нэг, эсвэл бүх арга хэмжээг бүхэлд нь үргэлжлүүлэх эсэх талаар шийдвэрлэхэд тусална.

## 2А. Стратеги төлөвлөгөө боловсруулах: Зорилго, арга хэмжээ, таамаглал, зорилт

### Зорилго

Юунд хүрэхийг зорьж байгаагаа тодорхой ойлгох нь стратегийн төлөвлөгөөг боловсруулах эхний чухал алхам юм. **Зорилго** нь хамгаалах үнэт зүйлтэй (байгаль хамгаалал болон/эсвэл хүний сайн сайхан байдал) шууд уялдсан байх бөгөөд эдгээр үнэт зүйлсийн урт хугацаанд хүрэхийг хүссэн төлөв байдал буюу **эцсийн үр дүнг** илэрхийлсэн тодорхойлолт юм. Зорилго нь *тодорхой, хэмжигдэхүйц, хэрэгжих боломжтой, үр дүнд чиглэсэн, хугацаатай байх* гэсэн “SMART” шалгуурыг хангах ёстой (Дэлгэрэнгүйг [Хавсралт 2](#) болон Хайрцаг 6-аас харна уу). Хамгаалах үнэт зүйлийн зорилго нь тухайн багийн үнэт зүйл, итгэл үнэмшлээс ихээхэн хамаардаг тул бусад оролцогч талуудын олон талт байр суурь, үзэл бодлыг зохих ёсоор тусгасан эсэхийг анхаараарай.

Төлөвлөгөөний зорилго нь илүү өргөн хүрээтэй хөтөлбөрийн болон байгууллагын зорилгод нийцэж, тэдгээрт хувь нэмэр оруулах нь зүйтэй. Зарим тохиолдолд төлөвлөгөөний хэрэгжилтээс хүлээгдэж буй үр дүнг байгууллагын бодлого, эсвэл хууль эрх зүйн шаардлагаар урьдчилан тодорхойлсон байх боломжтой бөгөөд энэ нь арга хэмжээгээ эрэмбэлэх, сонгоход нөлөөлнө. Мөн зорилго (зорилт)-оо үндэсний, бүс нутгийн болон олон улсын санаачилга, зорилтуудтай уялдуулах боломж бий эсэхийг харгалзан үзнэ (жишээлбэл: Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц, Тогтвортой хөгжлийн зорилтууд, Биологийн олон янз байдлын тухай конвенц, Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ын тунхаглал гэх мэт). Гэхдээ энэ уялдааг хүчээр бий болгох бус, харин давхцал нийцэл хаана байгааг тогтоож, эдгээр өргөн хүрээний хүчин чармайлтад хэрхэн хувь нэмэр оруулахаа тодорхойлох нь чухал юм.

Хэрэв [1В алхамд](#) амьдрах чадварын үнэлгээ хийсэн бол зорилго тодорхойлоход шаардлагатай бүх үндсэн мэдээлэл аль хэдийн бий болсон гэж үзнэ. Учир нь хамгаалах үнэт зүйлийн эрүүл, тогтвортой байдлыг илэрхийлэх чухал хүчин зүйл, хүсэж буй төлөв байдалд хүрэх хугацаа, мөн тухайн үнэт зүйлийн нөхцөл байдлыг үнэлэхэд шаардлагатай хэмжигдэхүүнүүд тодорхой болсон байдаг. Иймд зорилгоо тодорхойлох нь амьдрах чадварын үнэлгээний мэдээллийг нэгтгэн, зорилгыг албан ёсны тодорхойлолт болгон хөрвүүлэх үйл явц юм.

### ХАЙРЦАГ 6

#### ЗОРИЛГО, ЗОРИЛТЫГ ЗӨВ ТОДОРХОЙЛОХ

Зөв зорилго ба зорилт нь дараах СМАРТ шалгуурыг хангасан байна:

**Тодорхой** – Оролцогч бүх талууд дэвшүүлж буй зорилго, зорилт нь яг ямар утгыг илэрхийлж байгаа талаар ижил түвшний ойлголт авахуйц тодорхой томъёолсон байх.

**Хэмжигдэхүйц** – Зарим стандарт хэмжигдэхүүнээр тодорхойлогдсон байх (тоо хэмжээ, хувь, эсвэл төлөв байдал).

**Хэрэгжихүйц** – Тухайн төлөвлөгөө хэрэгжих газрын онцлог, түүх, төр, нийгэм, санхүүгийн нөхцөл байдалд нийцсэн байх (энэ шалгуур нь зорилтод илүү хамааралтай, харин зорилго илүү тэмүүлэлтэй байж болно).

**Үр дүнд чиглэсэн** – Зорилтот хүрэх түвшин, аюул дарамтын бууралт болон бусад хүлээгдэж буй гол үр дүнгийн өөрчлөлтийг илэрхийлсэн байх.

**Цаг хугацаатай** – Тодорхой цаг хугацаанд биелэгдэхүйц байх. Ерөнхийдөө зорилгод 10–20 жил, зорилтод 1–10 жилийн дотор хүрэхээр тооцож төлөвлөдөг.

Жишээлбэл, [Зураг 6](#)-д үзүүлсэн “ойн коридор” гэдэг хамгаалах үнэт зүйлийн зорилгыг дараах байдлаар тодорхойлж болно: “2035 он гэхэд Цагаан голын сав газрыг Лос Гриллостой холбосон ойн коридор нь дор хаяж 5 км өргөнтэй болж, экосистемийн бүрэн бүтэн байдал хадгалагдсан байна.”

Хэрэв төлөвлөгөөндөө хүний сайн сайхны төлөөх зорилт тавьсан бол эдгээр хамгаалах үнэт зүйлсийг сайжруулахад чиглэсэн зорилгыг тодорхойлох шаардлагатай. Үүний тулд хүний сайн сайхны төлөөх зорилтыг илэрхийлэх чухал хүчин зүйлсийг тодорхойлж, түүнд үндэслэн зорилгоо томъёолно.

Байгаль хамгааллын төслүүдэд дээрхи хүчин зүйлс нь ихэвчлэн хамгаалах үнэт зүйлийн бий болж буй экосистемийн үйлчилгээ эсвэл хүний сайн сайхан байдалд шууд ашиг тусаа өгдөг байгаль хамгааллын үйл ажиллагааны үр дүнтэй уялдсан байдаг. Хүний сайн сайхан байдал олон хэмжүүрүүдтэй бөгөөд үүнийг байгаль хамгааллын ажлын үр дүнтэй бүгдийг нь шууд холбон тайлбарлах боломжгүй. Тухайлбал, хүний эрүүл мэндэд зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх нь чухал боловч байгаль хамгааллын үүднээс хүний сайн сайхны төлөөх зорилтыг холестерины түвшин бууруулах гэж дэвшүүлэх боломжгүй. Харин хамгаалах үнэт зүйлсийн төлөв байдал сайжирч тариалангийн ургамлын тоос хүртэх үйлчилгээ нэмэгдснээр хүнсний эх үүсвэрийн

хүртээмж нэмэгдэж байгааг хүний сайн сайхан байдлын төлөөх зорилго болгон тавьж болно.

Зарим тохиолдолд биологийн олон янз байдал болон хүний сайн сайхан байдлыг ижил түвшинд анхаарсан зорилготой байж болох ч хүний сайн сайхан байдалд чиглэсэн үйл ажиллагааныхаа хамрах хүрээг тодорхой тогтоож, бодитой зорилтуудыг сонгоход анхаарна. Байгаль хамгааллын болон хүний сайн сайхны төлөөх зорилтууд хоорондоо зөрчилдөх нөхцөлүүдийг харгалзаж, хэрэгжүүлэх боломжтой, эсвэл боломжгүй зүйлсийг тодорхой зааглах нь чухал. Хүний сайн сайхны төлөөх зорилтыг холбогдох бүх оролцогч талуудтай хамтран тодорхойлох нь оновчтой.




PHOTO: FELIX CYBULLA

## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ХАРГАЛЗАН ҮЗЭХ НЬ 4

### ЗОРИЛГО ТОДОРХОЙЛОХ

Амьдрах чадварын үнэлгээнд үндэслэн зорилгоо тодорхойлохдоо хамгаалах үнэт зүйл бүрт уур амьсгалын өөрчлөлт хэрхэн нөлөөлж болохыг харгалзан үзнэ. Мөн зорилгууд нь уур амьсгалын нөхцөлийг харгалзсан, бодитой хүрэх боломжтой ирээдүйн төлөв байдлыг тусгасан эсэхийг нягтална. Зорилгоо тодорхойлохдоо түүхэн төлөв байдлыг хадгалах эсвэл сэргээх, ямар нэг арга хэмжээ авахгүйгээр экологийн өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх, эсвэл ирээдүйд чиглэсэн экологийн төлөвт шилжүүлэхээр зорьж байгаа эсэхээ нягтлана. Аюул, дарамтын үнэлгээгээр тухайн хамгаалах үнэт зүйл устах магадлалтай байсан ч, боломжит арга хэмжээг бүрэн судалж үзэхээс өмнө түүнийг төлөвлөлтөөс бүр мөсөн хасахгүй байх нь зүйтэй. Төлөвлөлтийн явцад зорилгыг дахин эргэн харж, шинэчлэх шаардлага гарч болохыг мөн анхаарбал зохилтой.

Харин тухайн төлөвлөлт хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах эсвэл шингээхэд чиглэсэн бол зорилгууд нь энэхүү өөрчлөлтийг бий болгохын тулд ямар экосистем, газар нутаг, усан орчныг хамгаалах, зохистойгоор менежмент хийх, эсвэл сэргээх шаардлагатайг тодорхой илэрхийлэх ёстой. Жишээлбэл: 2035 он гэхэд Андын нурууны парамо хүлэрт газрын дор хаяж 100,000 га талбайг сэргээж, хөрсний нүүрстөрөгч шингээх чадварыг нэмэгдүүлсэн байна.

## Арга хэмжээ

Зорилгоо тодорхойлсны дараа түүнд хүрэхийн тулд хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаагаа төлөвлөнө. Сайн стратегийн төлөвлөгөө нь та хаана, хэрхэн оролцох болон эс оролцох чиглэлийг тодорхойлохын зэрэгцээ хэнд нөлөөлөх, хэн түүхэн нөлөөтэй байсныг, мөн хэний дуу хоолойг нь илүү тодруулах шаардлагатай гэдгийг ил тод, хүртээмжтэйгээр тодорхойлох явдал юм.

## Нөлөөллийн гол цэгүүдийг сонгох

Хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлохдоо нөхцөл байдлыг сайжруулахад нөлөөлөх гол хүчин зүйлсийг эрэмбэлж түүнийгээ **нөлөөлөх гол цэгүүд** гэж үзнэ. Ингэхдээ хүчин зүйлсийг үнэлж, боломжит нотолгоонд (уламжлалт мэдлэгийг оролцуулан) тулгуурлан аль хүчин зүйлс нь хамгийн үр дүнтэй хөшүүрэг байх боломжтой, мөн хамгаалах үнэт зүйлд хамгийн их нөлөө үзүүлэх магадлалтай болохыг тогтоох шаардлагатай.


Хөшүүргийг аюул, дарамтыг бууруулахад оруулах хувь нэмэр оруулах, олон хүчин зүйлд нөлөөлөх чадвар, мөн тухайн хүчин зүйлийг (эсвэл түүнээс үүдэх үр дагавар) шийдвэрлэх зайлшгүй нөхцөл зэргийг харгалзан үнэлнэ.

Онолын хувьд нөхцөл байдлын дүн шинжилгээ нь аль хүчин зүйлд ямар арга хэмжээ авахыг харуулдаг. Зарим тохиолдолд шууд аюул, дарамт (жишээлбэл, харь зүйлийг устгах эсвэл тоо толгойн зохицуулалт хийх) эсвэл хамгаалах үнэт зүйл (жишээлбэл, экосистемийг нөхөн сэргээх) өөрөө нөлөөлөх гол цэг байж болно. Харин ихэнхи нөхцөлд шууд бус аюул, дарамт, түүнийг нөхцөлдүүлж буй хүчин зүйлсэд илүү олон боломж агуулагддаг (жишээлбэл, бодлогод нөлөөлөх, эсвэл менежментийн оновчтой арга нэвтрүүлэх). Аль хүчин зүйлд илүү үр дүнтэй нөлөөлөх эсэх нь оролцогч талуудтай тогтоосон харилцаа, нөлөөллийн түвшнээс хамаарна. Зураг 9-д нөлөөллийн гол цэгүүд болон тэдгээрийг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээний жишээг (зургаан өнцөгтөөр дүрслэн) харуулав.



PHOTO: ERIC RENSEL

**ЗУРАГ 9** Нөлөөллийн гол цэгүүд (тодруулсан) ба арга хэмжээг харуулсан нөхцөл байдлын дүн шинжилгээний жишээ



**ТАНИХ ТЭМДЭГ**

Арга хэмжээ	Нөхцөлдүүлэгч хүчин зүйл	Шууд аюул, дарамт	Био-физик хүчин зүйл	Хамгаалах үнэт зүйл	Хүний сайн сайхны төлөөх зорилт

## Хаана, хэрхэн оролцохоо тодорхойлох нь

Нөлөөллийн гол цэгүүд нь тухайн нөхцөл байдлыг өөрчлөхийн тулд байгаль хамгааллын арга хэмжээг хаана авах шаардлагатайг тогтооход ашиглагддаг. Байгаль хамгааллын стандартын хувьд **арга хэмжээ** гэдэг нь нийтлэг нэг зорилгод чиглэсэн, нэг буюу хэд хэдэн **үйл ажиллагааны** цогц бөгөөд эдгээр нь нөлөөллийн гол цэгүүдэд чиглэн, боломжуудыг оновчтой ашиглаж, хязгаарлалтыг багасгах замаар тодорхой зорилго, зорилтод хүргэнэ<sup>9</sup>. Арга хэмжээнүүд нь *уялдаа холбоотой, төвлөрсөн, хэрэгжих боломжтой, мөн тохирхонжтой* байх зэрэг шалгууруудыг хангасан байх шаардлагатай ([Хавсралт 2](#)-ыг үзнэ үү). Арга хэмжээ нь стратегийн хүрээнд хэрэгжих нэг буюу түүнээс олон арга хэмжээ, тэдгээртэй уялдсан хүлээгдэж буй үр дүн, зорилго болон зорилтуудтай байна.

Зорилгоосоо хамаараад арга хэмжээ нь олон төрлийн байх боломжтой. Жишээ нь экосистем эсвэл зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх, хүний хандлага өөрчлөхөд чиглэсэн шууд арга хэмжээ (Хайрцаг 7) байж болохоос гадна стратегийг үр дүнтэй хэрэгжүүлэх **боломжит нөхцөлийг** бий болгох арга хэмжээнүүд мөн багтдаг (боломжит бүх арга хэмжээний жагсаалтыг [IUCN-CMP Conservation Actions Classification](#)). Нөхцөл байдлын шинжилгээндээ тулгуурлан тодорхойлсон нөлөөллийн гол цэгүүдэд үйлчлэх боломжит арга хэмжээны жагсаалтыг гаргах нь зүйтэй.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээгээ зураглан холбож үзэх нь тустай. Ингэснээр хамгаалах үнэт зүйлс болон аюул дарамтад нөлөөлөхийн тулд зөв цэгүүдэд, зөв чиглэлээр арга хэмжээ авч байгаа эсэхээ шалгаж баталгаажуулж чадна ([Зураг 10](#)).

## ХАЙРЦАГ 7

### ЗАН ҮЙЛИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨШҮҮРЭГ


шинжлэх ухаанд суурилсан, баталгаатай зарчмуудад тулгуурласан зан үйлийн хөшүүргүүдийг ашиглаж болно. Эдгээр хөшүүргүүд нь хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь гол оролцогч талуудын сэтгэлзүй, нийгмийн хандлагад хэрхэн нөлөөлж, улмаар тэдний зан үйл хэрхэн бодитоор өөрчлөгдөхөд хүргэж байгааг тайлбарлахад тусалдаг. Зан үйлийн хөшүүргүүдийг байгууллагын, нийгмийн болон хувь хүний түвшинд оролцогч талуудад нөлөөлж буй ялгаатай сэдэл, саад бэрхшээлүүдийг хамтад нь харгалзан, уялдуулан хэрэглэх үед хамгийн үр дүнтэй байдаг. Үүнд:

- Мэдээлэл, дэмжлэг олгох (*бодитоор харуулж, заах*)
- Урамшуулал, хөшүүргийг өөрчлөх (*жишээлбэл: материаллаг зардал ба ашиг, цаг хугацаа, хөдөлмөрийн ачаалал татан оролцуулах, туслах*)
- Дүрэм журам тогтоох, хэрэгжилтийг хангах (*дагаж мөрдүүлэх/биелүүлэх*)
- Нийгмийн нөлөө, хэм хэмжээ, хэвшлийг ашиглах (*хэвшүүлэх / нормчлох*)
- Сэтгэл хөдлөл, гол үнэт зүйлс болон ашиг сонирхлыг хөшүүрэг болгох (*ятгах*)
- Сонголт болон шийдвэр гаргах орчныг зохион байгуулах (*зөөлөн чиглүүлэх*)


Ямар төрлийн хөшүүргийг, аль төрлийн үйл ажиллагаатай хослуулан хэрэгжүүлэх нь тухайн гол оролцогч эсвэл талуудын ашиг сонирхол, орчны нөхцөл байдал, танин мэдэхүйн хэвшмэл хандлага, саад бэрхшээл, мөн зан үйлийг өөрчлөх сэдлийг хэр сайн ойлгосноос шууд хамаарна.

9 5.0 хувилбарт нэр томьёоны хэрэглээг олон улсын нийтлэг жишигтэй уялдуулах үүднээс өмнө хэрэглэж байсан "стратеги" гэсэн ойлголтыг "арга хэмжээ" гэж шинэчилсэн бөгөөд ингэснээр арга хэмжээ нь стратегийн нэг хэсэг болон тодорхойлогдож байна

**ЗУРАГ 10 Шимпанзе хамгаалах нутаг дэвсгэрийн стратегийг харуулсан орон зайн хялбаршуулсан**



ХАА-н нөлөөллийн аюул, дарамт ба амьдрах орчны алдагдал



Ирээдүйн өөрчлөлтийг хязгаарлах тусгай хамгаалалттай газрын боломжит хувилбар

Эх үүсвэр: Лилиан Пинтеагийн Байгаль хамгааллын стандарт хэрэглэсэн жишээнээс авав Jane Goodall Institute

Арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхээс өмнө үр нөлөөг нь туршиж шалгана. Хэрэв тухайн арга хэмжээ төслийн хэрэгжих орчин нөхцөлд үр дүнтэй байх хөдлөшгүй нотолгоо тогтоогдвол, уг арга хэмжээг зохих хэмжээнд хэрэгжүүлж болно. Харин нотолгоо нь тодорхой бус, зөрүүтэй эсвэл огт байхгүй тохиолдолд, нэмэлт туршилт хийх, эсвэл уг арга хэмжээг туршилтын байдлаар хэрэгжүүлж, тухайн нөхцөлд үр дүнтэй эсэхийг уян хатан менежментийн аргачлалаар тодорхойлно. Хэрэв тухайн орчин нөхцөлд үр нөлөөтэй болох нь хангалттай нотлогдоогүй арга хэмжээг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн бол, үүнтэй холбоотой төслийн эрсдэлийг урьдчилан үнэлэх, мөн тухайн арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг нягт, тогтмол хянах шаардлагатай.

Хэрэгжүүлэх арга хэмжээнүүдээс үүдэн гарч болзошгүй **нийгэм, байгаль орчинд** үзүүлэх сөрөг нөлөөнөөс зайлсхийх эсвэл хэрхэн бууруулах талаар тооцоолох хэрэгтэй бөгөөд ялангуяа нөлөөлөл багатай боловч сонирхол өндөртэй

оролцогч талуудад учирч болзошгүй нөлөөллийг онцгойлон авч үзэх шаардлагатай. Төслийн хэрэгжилтийн туршид нөлөөлөлд өртөх бүлгүүдийн эмзэг байдал, нэр төр, хүний эрх, уламжлалт мэдлэг, газар болон байгалийн нөөцийн өмчлөл, ашиглалтын эрх, мөн соёлын өв, уламжлал, зан заншил зэрэг асуудлуудыг тогтмол харгалзан үзнэ. Мөн үйл ажиллагааны явцад үүсч болзошгүй санамсаргүй үр дагавар, эргэх холбоо болон ашиг сонирхлын зөрчил, зэргийг урьдчилан тодорхойлох нь чухал бөгөөд эдгээр нь хүмүүс, биологийн олон янз байдал болон төлөвлөгөөний хэрэгжилтийн ерөнхий үр дүнд нөлөөлж болзошгүй. Нийгэм, байгаль орчны хамгааллын асуудлуудыг төслийн хэрэгжилтийн хугацаанд тогтмол хянан үзэх нь зүйтэй ч, стратеги боловсруулах үе шатанд онцгой анхаарах шаардлагатай. Учир нь стратеги боловсруулах үе шатанд болзошгүй сөрөг нөлөөг тооцож, стратеги болон арга хэмжээнд шаардлагатай өөрчлөлт, зохицуулалтыг тусгах нь онцгой чухал байдаг.



PHOTO: FELIX СУВЦЛА

## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ХАРГАЛЗАХ НЬ 5А

### УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ, ТЭСВЭРЛЭХ ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ СТРАТЕГИУДЫГ ТОДОРХОЙЛОХ

Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан экологийн хариу үйлдэл нь нарийн төвөгтэй бөгөөд тодорхой бус байдаг. Үүнийг хамтад нь шийдвэрлэж болох, олон талт стратегиудыг авч үзэх шаардлага гардаг. Байгаль хамгааллын стандартын өмнөх алхамуудад (ялангуяа амьдрах чадварын үнэлгээ болон аюул дарамтын үнэлгээ) хийсэн ажлуудаа ашиглан хамгаалах үнэт зүйлсийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлэх стратегиудыг хэрхэн тодорхойлж болохыг дараах хүснэгтэд харуулсан болно.

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх чадварыг сайжруулах	Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлэх
Хамгаалах үнэт зүйлийн <b>амьдрах чадварыг</b> хадгалж эсвэл сайжруулж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэх	Далайн түвшин нэмэгдэхийн хэрээр далайн намаг эх газарт дотогш шилжин нүүх боломжийг хангахын тулд газар нутгийг хамгаалах, эргийн шугам өөрчлөгдөхийг хүлээн зөвшөөрөх
Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд харьцангуй бага өртөх боломжтой зүйлүүд болон <b>газар нутгийг</b> хамгаалах	Усны температур нэмэгдэхийн хирээр газрын доорх усны хүйтэн урсгалыг хамгаалах замаар хүйтэн усанд амьдардаг загасны зүйлийн амьдрах орчныг бүрдүүлэх
Биофизик хүчин зүйлийн нөлөө түүнийг нөхцөлдүүлж буй уур амьсгалын бус аюул дарамтад чиглэн арга хэмжээ авах замаар уур амьсгалтай холбоотой <b>аюул дарамт</b> (жишээлбэл, усны температурын өсөлт) бууруулах	Агаарын хэм нэмэгдэхийн хэрээр голын эргийн ургамлыг хамгаалж, усны урсгалыг сүүдэрлэн сэрүүн байлгах замаар хүйтэн усанд амьдардаг загасны амьдрах орчныг бүрдүүлэх
Уур амьсгалын эмзэг байдлыг нэмэгдүүлэх хүний <b>буруу дасан зохицох арга хэмжээ</b> болон үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх	Хүний үйл ажиллагааны улмаас түймрийн давтамж болон эрчим өөрчлөгдсөн газруудад нутгийн уугуул иргэдтэй хамтран ажиллаж, байгалийн жамыг сэргээх



## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ХАРГАЛЗАХ НЬ 5В

### УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ СААРУУЛАХ СТРАТЕГИУДЫГ ТОДОРХОЙЛОХ

Парисын хэлэлцээрийн хүрээнд хүлээсэн улс орнуудын үндэсний тодорхойлсон хувь нэмэрийг (NDC) хэрэгжүүлэхэд байгальд суурилсан уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга замууд чухал хувь нэмэр оруулдаг. Арга замууд нь ой, намгархаг газар (мангро, хүлэрт газар зэрэг), мөн хөдөө аж ахуйн газрыг хамгаалах, зохистойгоор ашиглах, эсвэл нөхөн сэргээхэд чиглэнэ. Доорх хүснэгтэд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга замууд түүнд тохирох стратегийн жишээнүүдийг харуулав.

Сааруулах арга хэмжээ	Нөлөөллийг бууруулах арга зам нь хүлэмжийн хийн ялгаруулалтад үзүүлэх нөлөө	Сааруулах стратегийн жишээ
Мангро ойг нөхөн сэргээх	Хүлэмжийн хийг шингээж хуримтлуулна	Усны урсгалыг хянах байгууламжийг нээж, усзүйн горимыг сэргээх замаар мангро ойн бүрхэвчийг нэмэгдүүлэх
Ойг хөндөхгүй байх	Хүлэмжийн хийн ялгаралаас зайлсхийнэ	Ойг хууль бус алт олборлолтод өртөхөөс сэргийлэх зорилгоор хуулийн хэрэгжилтийг чангатгах
Ойг зохистой ашиглах	Хүлэмжийн хийн ялгаралыг бууруулна	Засгийн газрын ойн ашиглалтын концессуудад байгалийн ойг зохистой ашиглах удирдамжийг сайжруулах

## Таамаглал ба Өөрчлөлтийн онол

Хэрэгжүүлэх арга хэмжээг сонгосны дараа тухайн арга хэмжээ бүр нь **дунд хугацааны** үр дүн болон биологийн олон янз байдал, хүний сайн сайхан байдалд чиглэсэн урт хугацааны зорилгод хэрхэн хүргэх талаар баримтлах шалтгаан-хамаарлын **таамаглалуудыг** тодорхой болгоно. Мөн арга хэмжээ амжилттай хэрэгжихэд зайлшгүй шаардлагатай бусад хүчин зүйлсийн талаарх таамаглалууд ч үүнд хамаарна. Эдгээр таамаглалын цогц нь **өөрчлөлтийн онолыг** бүрдүүлнэ. Өөрчлөлтийн онолыг бичвэр хэлбэрээр, зурагчилсан байдлаар (жишээлбэл, **үр дүнгийн гинжин хэлхээ**), эсвэл бусад тохиромжтой хэлбэрээр илэрхийлж болно.<sup>10</sup>

Хэрэв нөхцөл байдлын дүн шинжилгээг диаграмм хэлбэрээр дүрсэлсэн бол үүнийг үр дүнгийн хэлхээ боловсруулах суурь болгон

ашиглаж болдог (**11-р зурагт** ерөнхий жишээг, **12-р зурагт 9-р зураг** дээр үндэслэсэн жишээг харуулсан). Ингэснээр хэрэгжүүлэх арга хэмжээ нь одоогийн байдалд (таны нөхцөл байдлын диаграм дүрслэгдсэн) хэрхэн нөлөөлж, хүссэн үр дүнд хүрэхийг (үр дүнгийн хэлхээ дүрслэгдсэн) ил тод харуулж чадна. Өөрчлөлтийн онолын үр дүн ба таамаглал нь баримт дээр суурилсан байх ёстой ч зарим таамаглалд баримт нотолгоо дутагддаг. Иймээс төлөвлөлтийн энэ алхамд үр дүнд хүрэх боломжтой эсэх, хүсээгүй үр дагавар гарах эрсдэл байгаа эсэх зэрэг тодорхойгүй байдал үүсч болно. Иймд байхгүй баримтуудыг тодорхойлж эрэмбэлэх нь чухал юм (жишээлбэл, **12-р зурагт** цэгтэй шугам нь багийн таамаглал дахь тодорхойгүй байдлыг илэрхийлж байна).


Үр дүнгийн хэлхээ (өргөн утгаар нь авч үзвэл өөрчлөлтийн онол) нь тухайн арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай гол үйл ажиллагаануудыг багтаасан байна.

10 Зарим хүмүүс үр дүнгийн гинжин хэлхээг логик бүдүүвч эсвэл логик загвартай ижил гэж үздэг ч ялгаатай талууд бий. Логик бүдүүвч бол зорилго, зорилтуудыг эмх цэгцтэйгээр зохион байгуулах энгийн хэрэгсэл боловч, үр дүнгийн гинжин хэлхээнээс ялгаатай нь арга хэмжээ, зорилт, зорилгуудын хоорондын шалтгаан-үр дагаврын шууд уялдаа холбоог ил тод харуулдаггүй. Мөн үр дүнгийн гинжин хэлхээ нь илүү дэлгэрэнгүй, салаалсан бүтэцтэй, нэг үр дүн нөгөө үр дүнтэй хэрхэн шууд холбогдож байгааг харуулах боломжтой байдаг.

Эдгээр **үйл ажиллагаануудыг** нэмснээр нэг буюу хэд хэдэн үр дүнд хэрхэн хүрэхээр төлөвлөж байгааг илүү тодорхой болгоход тусална. Түүнчлэн үр дүнг тодорхойлохдоо оролцогч талуудын **сэтгэлзүйн болон нийгмийн** төлөв байдал, тухайлбал тэдний итгэл үнэмшил, хандлага, мэдлэг, мөн зан төлвийн талаархи мэдээллийг тусгах нь зүйтэй. Ингэснээр

тодорхой үйл ажиллагаанууд яагаад зан төлвийн өөрчлөлтөд хүргэнэ гэж үзэж байгааг илүү ойлгомжтой болгодог. Мөн энэ алхам нь оролцогч талууд, тэдний зан үйл нөхцөл байдлыг өөрчлөхөд тулгарч болзошгүй эрх мэдлийн харилцаа болон саад бэрхшээлүүдийн талаар зөв, бодитой таамаглал дэвшүүлэх чадвартай эсэхээ нягтлахад тохиромжтой мөч юм.


**ЗУРАГ 11** Үр дүнгийн хэлхээтэй холбогдох ерөнхий нөхцөл байдлын дүн шинжилгээний хүчин зүйлс



Үр дүнгийн хэлхээ нь хүрэхээр зорьж буй үр дүн буюу “хүссэн төлөв”-ийг харуулдаг

АГУУЛГА  
ТАНИЛЦУУЛГА  
ТОДОРХОЙЛОХ  
1  
2  
ТӨЛӨВЛӨХ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ  
3  
ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ & ҮЙЛДҮҮЛЭХ  
4  
ХУВААЛЦАХ  
5  
ТӨЛӨВЛӨЛТИЙН МЭЧЛӨГИЙГТ ЗАНГИДАХ НЬ  
ХАВСРАЛТ

**ЗУРАГ 12** Гол мөрний урсац бүрэлдэх эхэд уур амьсгалд ухаалгаар дасан зохицсон хотын хандлагыг дэмжих үр дүнгийн хэлхээний жишээ



Засгийн газрын зүгээс 2028 он гэхэд Цагаан голын сав газар дахь суурин газрын бүх төвүүдийн ногоон дэд бүтцийг дэмжиж, санхүүжүүлсэн байна

2035 он гэхэд сав газар дахь суурин газрын бохир гол руу халих үзэгдлийг 2025 онтой харьцуулахад хамгийн багадаа 35%-иар бууруулна


2040 он гэхэд болон цаашид, сав газрын хэмжээнд тархсан Цагаан голын хясааны популяцийн тоо толгой ба олон янз байдал нь (амьдрах чадварын үнэлгээнд тодорхойлсноор) “сайн” түвшинд хүрсэн байна.

ТАНИХ ТЭМДЭГ				
Арга хэмжээ	Нөхцөлдүүлэгч хүчин зүйлс	Шууд аюул, дарамт	Био-физик хүчин зүйл	Хамгаалах үнэт зүйл
Үйл ажиллагаа	Дунд шатны үр дүн	Аюул, дарамтыг бууруулсан үр дүн	Био-физик үр дүн	

Хэрэв нөхцөл байдлын дүн шинжилгээндээ хүний сайн сайхны төлөөх зорилтыг тодорхойлсон бол, арга хэмжээнүүд хүний сайн сайхан байдлыг хэрхэн сайжруулна гэж үзэж байгаагаа өөрчлөлтийн онолоороо мөн адил харуулах шаардлагатай. 13-р зурагт экосистемийн үйлчилгээ хүний сайн сайхан байдалд хэрхэн хувь нэмэр оруулж болохыг харуулсан жишээг үзүүлсэн. Байгаль хамгааллын ажил бол зөвхөн биологийн олон янз байдлаар хязгаарлагддаггүй, өргөн хүрээний нийгмийн чухал асуудлуудад ч мөн оролцдог гэдгийг бодолцоорой (жишээлбэл, сайн засаглалыг бэхжүүлэх, эсвэл тогтвортой амьжиргааг дэмжих). Нэг үгээр байгаль хамгааллын арга хэмжээний үр дүн байгаль


хамгааллыг дэмжих зорилгоор нийгмийн үр өгөөжийг бий болгодог. Үүнийг экосистемийн үйлчилгээгээр дамжин хүний сайн сайхны төлөө зорилтод хувь оруулж байгаа эсэх, эсвэл байгаль хамгааллын арга хэмжээний шууд үр дүн үү гэдгийг тодруулах нь зүйтэй. 14-р зурагт эдгээр харилцан хамаарлыг ерөнхий байдлаар, харин 15-р зурагт эко гэрчилгээжүүлэлтийн арга хэмжээ нь мод бэлтгэгчдийн орлогыг нэмэгдүүлэх (энэ нь мөн байгаль хамгааллын зайлшгүй шаардлагатай үр дүн) замаар шууд, мөн экосистемийн үйлчилгээгээр дамжин хүний сайн сайхан байдалд шууд бусаар хэрхэн хувь нэмэр оруулж болох тодорхой жишээг харуулсан байна.

**ЗУРАГ 13** Хүний сайн сайхны төлөөх зорилт экосистемийн үйлчилгээтэй уялдсан үр дүнгийн гинжин




ЗУРАГ 14

Байгаль хамгааллын арга хэмжээ хүний сайн сайхан байдалд хувь нэмэр оруулах ерөнхий бүдүүвч



ЗУРАГ 15

Байгаль хамгааллын арга хэмжээ хүнд шууд ашиг өгч буй жишээ



ТАНИХ ТЭМДЭГ


Арга хэмжээ	Үйл ажиллагаа	Дунд шатны үр дүн	Аюул дарамтыг бууруулсан үр дүн	Хамгаалах үнэт зүйл	Хүний сайн сайхны төлөөх зорiot

Үр дүнгийн хэлхээг төслийн тодорхой ажил үүргийн **үр дүнг** харуулахад ашиглаж болохоос гадна, төслийн хяналт, сонирхлын хүрээнээс гадуур удаан хугацааны үр дүнгүүдийг ч дүрслэн харуулах боломжтой. Зарим төсөл хамгаалах үнэт зүйлээ сайжруулахыг зорьдог бол, зарим нь зөвхөн аюул, дарамтыг бууруулах үр дүнд хүрэхийг (жишээ нь,

далай дахь хуванцар хог хаягдлыг багасгах, Зураг 16) эсвэл дунд шатны үр дүнд хүрэхийг (жишээ нь, шийдвэр гаргагчид хуванцар хэрэглэхийг хязгаарлах хууль батлах) зорьдог. Эдгээр сүүлчийн тохиолдолд, эцсийн аюул, дарамт бууруулах болон/ эсвэл байгаль хамгааллын үр дүн нь ил тод бус, харьцангуй далд хэлбэртэй байж болох юм.

ЗУРАГ 16

Төслийн хүрээнд нөлөөлж чадах байгаль хамгаалалтай шууд холбогдоогүй ажлын жишээ



## Зорилт

Зорилт нь зорилгод хүрэхэд зайлшгүй шаардлагатай үр дүнг (эсвэл үр дүнгийн хэлхээн дэх дунд шатны үр дүнгүүдийг) албан ёсоор тодорхойлсон мэдэгдэл бөгөөд богино болон дунд хугацаанд ямар хэмжээний өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзэж байгааг тодорхой заасан байдаг. Мөн ямар оролцогч талууд болон ямар зан үйлийн өөрчлөлтөд чиглэж байгаагаа тодорхой илэрхийлэх ёстой. Сайн зорилт (мөн зорилго) нь “SMART” буюу *тодорхой, хэмжигдэхүйц, хүрэх боломжтой, үр дүнд чиглэсэн, хугацаатай байх* зэрэг шалгууруудыг хангасан байна ([Хавсралт 2](#)-ыг үзнэ үү).

[12-р зурагт](#) үзүүлснээр, зорилт нь өөрчлөлтийн онол хүчин төгөлдөр хэрэгжихэд зайлшгүй шаардлагатай үр дүнтэй шууд уялдаж байдаг. Ерөнхийдөө шууд аюул, дарамтад чиглэсэн зорилттой байхыг сайн туршлага гэж үздэг

(хэрэв нөлөөллийн хүрээнээс гадуур биш бол, 16-р зурагт харуулсанчлан). Шууд аюул, дарамт руу чиглэсэн зорилт нь хамгаалах үнэт зүйлд зориулан тогтоосон зорилгод тулгуурласан байх ёстой. Зорилт бүрийн хувьд ямар түвшин, шалгуур тохиромжтой вэ гэдгийг нарийвчлан тодорхойлж, сайн зорилтын шалгуурууд хангагдаж буй эсэхийг баталгаажуулах нь чухал. Илүү их мэдээлэл бий болохын хэрээр зорилтуудаа (мөн шаардлагатай бол арга хэмжээнүүд болон тэдгээртэй холбоотой өөрчлөлтийн онолыг) дахин эргэн харж, сайжруулах шаардлага гарна. [8-р хайрцагт](#) зорилт тодорхойлоход анхаарах зарим нэмэлт асуудлуудыг багтаасан болно.

Өөрчлөлтийн онолоор зорилго, зорилт нь та юунд хүрэх шаардлагатайг илэрхийлэхээс гадна арга хэмжээ хэрхэн үр дүнд хүргэх тухай таамаглалуудыг тодруулж, мөн төслийн ахицыг хэрхэн хэмжих, үнэлэхийг тодорхой болгодог.

## Стратегийн төлөвлөгөө – Бүгдийг нэгтгэх нь

Хамрах хүрээ, нөхцөл байдлын шинжилгээ, мөн арга хэмжээнүүдийг (үүнд өөрчлөлтийн онол, зорилго, зорилт багтана) стратегийн төлөвлөгөөнд албан ёсоор тусган баримтжуулна (8-р зургийг дахин харна уу). Арга хэмжээнүүдийг үр дүн, зорилго, зорилтуудтай уялдуулан холбож технологид суурилсан бүтэц бий болгох нь хяналт, хариуцлагыг илүү сайжруулдаг. Хэрэгцээнээс хамааран уг систем нь энгийн хүснэгтээс эхлээд мэдээллийн сан хүртэлх илүү цогц хэлбэртэй байж болно.

Тодорхой, ойлгомжтой мониторингийн систем нь холбогдох бүх өгөгдөл, мэдээ, баримт бичгийг эмх цэгцтэй, хялбар хүртээмжтэй, мөн шинэчлэхэд төвөггүй байдлаар хадгалах боломжийг бүрдүүлдэг.

### ХАЙРЦАГ 8

#### ЗОРИЛТ ТОДОРХОЙЛОХОД АНХААРАХ БУСАД АСУУДЛУУД

SMART шалгуураас гадна зорилт тодорхойлоход дараах асуудлууд чухал:

- Байгаа мэдээлэлд тулгуурлах. Боломжтой тохиолдолд одоогийн буюу суурь нөхцөл байдлыг ойлгож, шаардлагатай өөрчлөлтийн хэмжээг тодорхойлоход ашиглана.
- Тоон утгыг нотолгоонд суурилан тогтоох. Боломжтой бөгөөд тохиромжтой тохиолдолд онолын загварууд, мэргэжилтний санал, болон бусад боломжит нотолгоог ашиглан зорилт (зорилго)-ын тоон үзүүлэлтийг тогтооно.
- Ямар хэмжээний өөрчлөлт шаардлагатайг тодорхой болгох. Байгаль хамгааллын үр дүнг харахын тулд ямар түвшний өөрчлөлт хэрэгтэйг тодорхойлно. Зорилго болон/эсвэл дунд шатны үр дүнгээс ухраан тооцоолж, гинжин хэлхээ үргэлжлэхийн тулд өмнөх зорилт бүрээс ямар түвшний үр дүн шаардагдахыг тогтооно.
- Нийлбэр нөлөөг харгалзан үзэх. Нэг үр дүнд олон арга хэмжээ зэрэгцэн хувь нэмэр оруулах боломжтой тул тухайн үр дүнд зориулсан зорилтыг тогтоохдоо эдгээр арга хэмжээнүүдийн нийлбэр нөлөөг харгалзан үзнэ.



PHOTO: JUSTIN GRUBB

#### ЭНЭ АЛХМЫН ХҮРЭЭНД ГАРАХ ҮР ДҮН:

- Хамгаалах үнэт зүйл бүрт (шаардлагатай тохиолдолд хүний сайн сайхны төлөөх үнэт зүйл) чиглэсэн зорилгууд
- Нөлөөллийн гол цэгүүдийг тодорхойлж, эхний байдлаар арга хэмжээг төлөвлөх
- Арга хэмжээнүүдийг эрэмбэлэх
- Арга хэмжээ болон тэдгээртэй холбоотой үйл ажиллагаа нь хүлээгдэж буй үр дүнд хэрхэн хүргэх талаарх таамаглалуудыг тодорхойлсон өөрчлөлтийн онолууд, мөн дунд шатны үр дүнд зориулсан зорилтууд
- Эцэслэн боловсруулсан стратегийн төлөвлөгөө

## 2В. Үнэлгээ мониторингийн төлөвлөгөө боловсруулах

Энэхүү дэд алхам нь мониторингийн систем, аргачлалыг тодорхойлон, иж бүрэн үнэлгээ **мониторингийн төлөвлөгөө** боловсруулахад чиглэнэ. Мониторингийн төлөвлөгөө нь зорилго, зорилтуудад хүрэх явцыг хянах, өөрчлөлтийн онолтой холбоотой гол таамаглалуудын дагуух ахицыг үнэлэх, тодорхойгүй байдалтай холбоотой мэдээллийн хэрэгцээг хангахад (жишээлбэл, нөхцөл байдлын шинжилгээ, арга хэмжээ сонголт, эсвэл өөрчлөлтийн онолын үе шатанд) тусална.

Түүнчлэн мониторингийн төлөвлөгөө нь хэрэгжилтэд шаардлагатай нөөцийг тодорхойлох, өгөгдөл цуглуулах болон тэдгээрийг шинжлэх хугацааны хуваарь гаргах, мөн болзошгүй эрсдлийг тооцоолох боломжийг өгдөг. Гол таамаглалуудад итгэх итгэл (өөрөөр хэлбэл, таамаглалыг нотлох баримт хангалттай эсэх), алдаанаас гарах үр дагавар, төлөвлөгөөний хэрэгжилтийн үе шат, мөн боломжит нөөц зэргээс ямар түвшний, аль төрлийн мониторинг хийх нь хамаардаг.

### Зорилтот бүлэг ба мэдээллийн хэрэгцээ

Мониторингийн төлөвлөгөөг боловсруулахын тулд эхлээд ямар **зорилтот бүлэг** байгаа болон тэдэнд **ямар мэдээлэл хэрэгтэйг** тодорхойлно. Бага зардал, нөөц зарцуулж, гол эргэлзээтэй асуудлуудыг тайлбарлах болон зорилго, зорилтууд биелж байгаа эсэхийг мэдэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулж байвал сайн **мониторинг** гэж үздэг.

Эхний алхам бол хэнд зориулж мониторинг хийх вэ, шийдвэр гаргахад тэд юу мэдэх шаардлагатай вэ, тухайн мэдээлэл хэзээ хэрэгтэй вэ, ямар нарийвчлалтай мэдээлэл шаардагдах вэ гэдгийг тодорхой болгоно. Жишээлбэл, нэг зорилтот бүлэг нь төслийг санхүүжүүлэгчид байж болох бөгөөд тэд хөрөнгө нь зориулалтын дагуу, зөв зарцуулагдаж байгаа эсэхийг мэдэхийг хүсдэг. Харин өөр нэг бүлэг нь төслөөс шууд нөлөөлөл хүртэж буй оролцогч талууд (нутгийн уугуул иргэд)



PHOTO: ERICA COCHRANE

байж болох бөгөөд тэдний хувьд төсөл өөрсдөд нь ямар өөрчлөлт үр дүн авчирах, ашиг сонирхол нь бодитоор тусгагдаж байгаа эсэхийг ойлгох нь чухал байдаг.

Багийн гишүүд өөрсдөө үнэлгээ мониторингийг үр дүнг хүлээж авах хамгийн гол субъект байдаг. Үнэлгээ мониторинг нь арга хэмжээнүүд хэрхэн хэрэгжиж байгаа, зорилго, зорилтууд биелж байгаа эсэх, өөрчлөлтийн онолд дэвшүүлсэн таамаглалууд үнэн зөв эсэхийг шалгах, тодорхойгүй байдлыг багасгах, цуглуулсан өгөгдөл, мэдээллээс суралцах, мөн одоогийн болон ирээдүйн хөтөлбөр, үйл ажиллагааг сайжруулахад зайлшгүй шаардлагатай. 2-р хүснэгтэд түгээмэл оролцогчид болон тэдгээрийн ерөнхий мэдээллийн хэрэгцээг харуулсан болно.

Үнэлгээ мониторингийг таамаглалууддаа (нөхцөл байдлын дүн шинжилгээ болон үр дүнгийн хэлхээнд харуулсан) болон тодорхой бус байгаа мэдээлэлд төвлөрүүлснээр, зөвхөн хэрэгцээтэй өгөгдлийг цуглуулах боломж нэмэгдэнэ. Ингэснээр

мэдээллийн хэрэгцээг хангахад чиглэсэн өгөгдөл (жишээлбэл, аюул, дарамтын төлөв байдал, үр дүнгийн биелэлт, тодорхойгүй хэвээр байгаа асуудал) илүү үр дүнтэйгээр бүрдэнэ.

Арга хэмжээнүүд үр дүнтэй эсвэл эсрэгээрээ үр дүн өгөхгүй байгаагийн учир шалтгааныг ойлгохын тулд мониторинг байгаа бол зөвхөн тодорхой үр дүн, зорилт, зорилгуудыг хянахаас гадна, хүсэж буй үр дүнд хүрэхэд нөлөөлж буй гол хүчин зүйлсийг мөн хамтад нь хянах шаардлагатай. Үүнд төслийн хяналтаас гадуур нөлөөлөх саад бэрхшээлүүд, дэмжих нөхцөлүүд, мөн гол оролцогч талуудын зан үйлийн өөрчлөлт болон түүнтэй холбоотой сэтгэлзүй-нийгмийн төлөв байдал (итгэл үнэмшил, хандлага, мэдлэг зэрэг) орж болно.

Мэдээллийн хэрэгцээнд эрэмбэ тогтоохдоо, уг мэдээлэл байхгүйгээс шалтгаалан ямар эрсдэл үүсэх, тухайн мэдээллийг удирдлагын шийдвэр гаргахад хэрхэн ашиглах, мөн боломжит нөөц, хугацааны хүрээнд уг мэдээллийг бүрдүүлэх боломжтой эсэхийг харгалзан үзэх нь зүйтэй.

**ХҮСНЭГТ 2**

**Үнэлгээ мониторингд оролцогчид ба тэдгээрийн мэдээллийн хэрэгцээ**

ЗОРИЛТОТ БҮЛГҮҮД	МЭДЭЭЛЛИЙН ЕРӨНХИЙ ХЭРЭГЦЭЭ/СОНИРХОЛ
Төслийн баг ба хамтрагчид	Үйл ажиллагаа нь төлөвлөсний дагуу хэрэгжиж байна уу, зорилтууд тогтоосон хугацаанд биелж байна уу, дэвшүүлсэн таамаглалууд бодитой байна уу, юу сайн ажиллаж байна вэ, юу хангалтгүй байна вэ, үүний шалтгаан нь юу вэ, мөн стратегийг хэрхэн сайжруулах эсвэл өөрчлөх шаардлагатай вэ?
Донорууд	Үйл ажиллагаа нь төлөвлөсний дагуу хэрэгжиж байна уу, зорилтуудаа тогтоосон хугацаанд биелүүлж байна уу, мөн төслийн үндсэн таамаглалууд бодитой, хүчинтэй хэвээр байна уу?
Оролцогч талууд	Үйл ажиллагааны төлөвлөсний дагуу хэрэгжиж байна уу, мөн төсөл нь оролцогч талуудад хэрхэн, ямар нөлөө үзүүлж байна вэ?
Байгаль хамгааллын салбарынхан	Юу нь илүү эсвэл үр дүнгүй байв? түүний шалтгаан нь юу вэ, мөн ямар туршлага, сургамжийг бусад нөхцөл байдалд ерөнхийлөн ашиглах боломжтой вэ?
Судлаачид болон оюутнууд	Юу нь илүү эсвэл үр дүнгүй байв? түүний шалтгаан нь юу вэ,
Аудитор болон баталгаажуулах субъект	Холбогдох хууль, журамд нийцэж байна уу, мөн сайн туршлагаудыг мөрдөж хэрэгжүүлж байна уу?

- АГУУЛГА
- ТАНИЛЦУУЛГА
- 1 ТОДОРХОЙЛОХ
- 2 ТӨЛӨВЛӨХ**
- 3 ХЭРЭГЖҮҮЛЭХ
- 4 ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ & ҮЙЛДҮҮЛЭХ
- 5 ХУВААЛЦАХ
- ТӨЛӨВЛӨЛТИЙН МӨЧЛӨГИЙГ ЗАНГИДАХ НЬ
- ХАВСРАЛТ




PHOTO: AUDREY BRISSEAU

## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ХАРГАЛЗАН ҮЗЭХ НЬ 6

### УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨ БА СТРАТЕГИЙГ ХЯНАХ НЬ

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлтэй холбоотой хувирамтгай байдал болон тодорхойгүй нөхцөлүүдэд уян хатан менежментийн арга барил онцгой ач холбогдолтой байдаг. Уур амьсгалын өөрчлөлтийг болон/эсвэл тодорхой зүйлүүд, экосистемүүд уур амьсгалын өөрчлөлтөнд хэрхэн хариу үйлдэл үзүүлж байгааг хянахын тулд тусгай мониторингийн арга барил ашиглах шаардлага гарч болзошгүй (жишээлбэл, хөрсний чийгшил, шуурганы давтамж, шуурганы эрчим зэрэгт тусгайлсан үзүүлэлтүүдийг ашиглах). Энэ үзүүлэлтүүдийн босго түвшинг (жишээлбэл, амьдрах чадварын үнэлгээнд ашиглагддаг “сайн” ба “дунд” түвшний хоорондын босго) тодорхойлох нь чухал бөгөөд эдгээрийг дохио болгон ашиглаж стратегийг нэмэх, өөрчлөх, хасах, эсвэл хамгаалах үнэт зүйлийг дахин авч үзэх эсэхийг шийдвэрлэхэд хэрэглэнэ.


## Шалгуур үзүүлэлт

Зорилтот бүлгийн мэдээллийн хэрэгцээг тодорхойлсны дараа, үүнийг хангахын тулд цуглуулах шаардлагатай өгөгдөл, мэдээ бүрт тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлно. Сайн шалгуур үзүүлэлт нь *хэмжигдэхүйц, нарийвчлалтай, тогтвортой, мөн өөрчлөлтөд мэдрэг* байх шалгуурыг хангах бөгөөд нөхцөл байдлын дүн шинжилгээ эсвэл өөрчлөлтийн онолд тодорхойлсон гол хүчин зүйлс, үр дүн, эсвэл таамаглалтай уялдсан байх ёстой ([Хавсралт 2](#)-ыг үзнэ үү). Зарим шалгуур үзүүлэлт нь чанарын, харин зарим нь тоон шинжтэй байдаг. Үүний нэгэн адил, нэг шалгуур үзүүлэлтийг хэмжих олон төрлийн аргачлал байж болно. Шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо орон нутгийн иргэдийн биологийн олон янз байдлын талаарх үзэл баримтлал, үнэт зүйлсийг мөн харгалзан үзэх нь зүйтэй.

Нөхцөл байдлын дүн шинжилгээ, өөрчлөлтийн онол, мөн зорилго, зорилтуудаар дамжуулан анхаарах чиглэл болон мэдээллийн хэрэгцээг тодорхойлон эрэмбэлсэн байна. Нөхцөл байдлын

дүн шинжилгээнд буй мэдээллийн хэрэгцээг нөхөх, дэвшүүлсэн таамаглалуудыг шалгах, мөн тогтоосон зорилтуудад хүрэх ахицыг нотлон харуулах шаардлагатай. Эдгээр нь шалгуур үзүүлэлтийн маш олон боломжит хувилбараас бодитой, хэрэгжүүлэхэд боломжтой жагсаалтыг сонгоход тусалж, өгөгдөл цуглуулах, дүн шинжилгээ хийх, **үнэлэх**, суралцах үйл явцыг төвлөрсөн, үр дүнтэй зохион байгуулах суурь болдог. [17-р зураг](#)т өөрчлөлтийн онол болон түүнтэй уялдсан SMART зорилтууд нь шалгуур үзүүлэлтийг хэрхэн оновчтой сонгоход тусалдгийн жишээг харуулсан болно. Мэдээллийн хэрэгцээг хангахад зайлшгүй шаардлагатай хамгийн бага хэмжээний өгөгдлийг цуглуулахыг зорих нь зүйтэй. Өөрчлөлтийн онолын дагуу ахицыг хянах явцад төслийн хяналтаас гадуур боловч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнд ихээхэн нөлөөлж болох хүчин зүйлс (жишээлбэл, улс төрийн нөхцөл байдал, зах зээлийн өөрчлөлт) байж болохыг анхаарах хэрэгтэй. Иймд эдгээр хүчин зүйлсийг цөөн тооны шалгуур үзүүлэлтээр хянаснаар хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхээ мэдэхэд дөхөм болдог.

**ЗУРАГ 17** Байгаль хамгаалалд ээлтэй бүсчлэлийн үр дүнгийн хэлхээ ба шалгуур үзүүлэлт




## Арга зүй

Шалгуур үзүүлэлт, гол мэдээллийн хэрэгцээг тодорхойлохын зэрэгцээ түүнийг хэрхэн хэмжих, өөрөөр хэлбэл ямар **аргачлал** ашиглахаа тооцоолно. Шугаман замналын дагуу зэрлэг амьтдын тооллого хийхээс эхлээд газар ашиглалтын хэв маягийг судлах зорилгоор хиймэл дагуулын зургийг татаж ашиглах, эсвэл талуудын мэдлэг, хандлага, итгэл үнэмшил, зан үйлийг ойлгохын тулд ярилцлага хийх зэрэг олон янзын аргачлалууд байж болдог. Аргачлалууд нь *үнэн зөв, найдвартай, зардал багатай, хэрэгжүүлэх боломжтой, мөн тухайн нөхцөлд тохирсон байх* шалгуурыг хангах ёстой ([Хавсралт 2](#)-ыг үзнэ үү). Мониторингийн аргачлалууд нь оролцоонд суурилсан, мэдээллийг “шахаж авах” бус, мөн хувийн нууц, өгөгдлийн эзэмших эрхийн асуудлыг давхар харгалзан үзсэн байх нь зүйтэй.

Заримдаа аргачлалыг сонгох үед нарийвчлал болон гарах зардлын хооронд сонголт хийх шаардлагатай болдог. Нарийвчлалтай, найдвартай бөгөөд шийдвэр гаргалтад хэрэгцээт мэдээллээр хангах, зардал бага, үр ашигтай аргыг сонгох нь чухал. Зарим нөхцөлд анхдагч өгөгдөл цуглуулах шаардлагагүй байж болох бөгөөд харин байгаа өгөгдлийг ашиглах боломжтой. Жишээлбэл, загасны нөөцийн талаарх мэдээллийг төрийн байгууллагаас цахим орчинд байршуулсан агнуурын бүртгэлээс татаж авч ашиглаж болно. Гэхдээ зарим тохиолдолд анхдагч өгөгдөл цуглуулах зайлшгүй шаардлагатай байдаг.

Ашиглаж буй аргачлалуудыг хэрэгжүүлэхдээ мөрдөх тодорхой протоколыг баримтжуулах нь зүйтэй. Ингэснээр өгөгдлийг тайлбарлахад дөхөм болохоос гадна ижил шалгуур үзүүлэлтүүдийг цаашид хянах замаар цаг хугацааны явц дахь хэв шинжийг илрүүлэх боломж бүрдэнэ. Шалгуур үзүүлэлт болон аргачлалуудыг ашиглахаас өмнө туршиж, сайжруулах нь зүйтэй. Тухайлбал, асуумжийн хэрэгслийг туршилтаар ашиглаж, шаардлагатай мэдээллийг үнэхээр өгч байгаа эсэх болон буруу ойлгогдох эрсдэлгүй эсэхийг шалгана. Үүнтэй адил, төслийн эхний үед суурь өгөгдөл цуглуулах нь аргачлалаа шалгах боломж олгоно. Хэрэв төслийн эхний хэдэн сард суурь өгөгдөл бүрдүүлэх боломжгүй байвал, ашиглаж буй аргачлал эсвэл шалгуур үзүүлэлтүүдийг дахин нягтлах шаардлагатай гэсэн дохио байж болно.



## Мониторингийн төлөвлөгөө – Бүгдийг нэгтгэх нь

Мониторингийн төлөвлөгөө нь шалгуур үзүүлэлт, түүнийг хэмжих аргачлал, зорилтот бүлгүүд, мэдээллийн хэрэгцээ зэргээс бүрддэг. Мөн төлөвлөгөөнд өгөгдлийг хэзээ, хаана, хэн цуглуулах зэргийг тодорхой тусгана (жишээг [3-р хүснэгт](#) ээс харна уу).

Мониторингийн төлөвлөгөөг боловсруулахдаа өгөгдөл цуглуулах үйл явц нь оролцогч талуудад хэрхэн нөлөөлөх, мөн цуглуулсан өгөгдөл, мэдээ хаана, хэрхэн хадгалах талаар урьдчилан тооцно. Үүнд хувийн нууц болон өгөгдлийг эзэмших эрхтэй холбоотой асуудлууд багтдаг. Үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв боловсруулах явцдаа ([Алхам 3](#)) **мониторингийн үйл ажиллагаа** болон өгөгдлийн менежментийг дэмжихэд шаардлагатай хугацаа, санхүүгийн нөөцийг тусгана.

Цаашлаад, [Алхам 3 \(Хэрэгжүүлэх\)](#) болон [Алхам 4 \(Дүн шинжилгээ хийх ба уялдуулах\)](#)-т бэлтгэхийн тулд өгөгдөлд хэрхэн менежмент хийх, хэн хэрхэн ашиглах, мөн цуглуулсан өгөгдөл, мэдээг ямар аргаар шинжилж, ямар шийдвэр гаргахад ашиглах талаархи протоколуудыг урьдчилан тодорхойлох нь зүйтэй. Үзүүлэлт, аргачлал, холбогдох мэдээлэл зэргийг үйл ажиллагаа, үр дүн, зорилго, зорилтуудтай холбосон нэгдсэн системд оруулснаар эдгээр мэдээллийг нэгтгэн ойлгож, дүгнэлт хийхэд илүү хялбар болно. Түүнчлэн [Алхам 5](#)-д гарах мэдээллийн хэрэгцээг тооцоолж, бусад хүмүүс мэдээллийг ойлгох, дахин ашиглах боломжтой байх нээлттэй мэдээллийн сан бүрдүүлэх нь чухал. Үүний тулд өгөгдөл цуглуулах, хадгалах, ашиглахтай холбоотой тодорхой, ойлгомжтой журам, протоколуудыг бий болгох шаардлагатай.

## ХҮСНЭГТ 3

## Уур амьсгалд зохицсон шийдлүүдийг дэмжих мониторингийн төлөвлөгөөнөөс авсан жишээ хэсэг

ЗҮЙЛ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	МОНИТОРИНГ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭН	ХУГАЦАА
<p><b>УА ЗОРИЛТ-1.</b></p> <p>2028 он гэхэд Цагаан голын ус хурах сав газрын бүх хот суурин газарт төрөөс ногоон дэд бүтцийг дэмжин хэрэгжүүлж, санхүүжүүлдэг</p>	Ногоон дэд бүтцийг дэмжих бодлого болон санхүүжилт хэрэгжиж буй хот суурин газруудын хувь	Аймгийн засаг захиргааны албан ёсны баримт бичгийг хянах, хот суурин газрын орон нутгийн албан тушаалтнуудтай зөвлөлдөх	LS	Q4, 2027 Q4, 2028
<p><b>УА ЗОРИЛТ-2.</b></p> <p>2035 он гэхэд Цагаан голын сав газар дахь хот суурин газруудад бохирын халилтын тохиолдлын тоог 2025 онтой харьцуулахад дор хаяж 35 хувиар бууруулсан байна</p>	# бохир хальсан тохиолдол/жилээр	Бохирын шугамын зураглал болон халилтын үргэлжлэх хугацааны өгөгдлийг ашиглах	LS	2028 оноос эхлэн жил бүр (2025 оны түвшин)
<p><b>ЗОРИЛГО.</b></p> <p>2040 он болон түүнээс цааш Цагаан голын ус хурах сав газрын хэмжээнд хясааны популяцийн элбэгшил болон зүйлийн олон янз байдал нь амьдрах чадварын үнэлгээнд тодорхойлсон “сайн” түвшинд хүрсэн байна.</p>	#Хясааны зүйлийн бүрдэл болон тоо	Судалгааны байгууллагын өгөгдлийг ашиглах (ус зайлуулах цэгүүд ба доод урсгал)	AM, JB	2025-2040 (2025 оны түвшин) 5 жил тутамд
<p><b>ТОДОРХОЙ БУС БАЙДАЛ</b></p> <p>Төрийн байгууллагын ногоон дэд бүтцийн талаарх ойлголт, дэмжлэг нь бодитой санхүүжилтэд бий болгох уу? Үүнд нөлөөлж болохтомоохон бэрхшээлүүдийг орхигдуулсан байж болох уу?</p>	<p>-Төрийн ойлголт, дэмжлэгийн нотолгоо</p> <p>-Гол саад бэрхшээлүүд</p> <p>-Төрийн албан тушаалтнуудын санал, байр суурь</p>	<p>Холбогдох төрийн албан тушаалтнуудтай уулзаж, санал солилцох</p> <p>Бусад бүс нутагт хэрэгжсэн туршлага, сургамжид судалгаа хийх</p>	LS, AM, JB	2026

 ЭНЭ АЛХМЫН ХҮРЭЭНД ГАРАХ ҮР ДҮН:

- Зорилтот бүлгүүд, тэдний мэдээллийн хэрэгцээ болон мэдээлэл дамжуулах хэлбэрүүд
- Шалгуур үзүүлэлтүүд болон арга зүй
- Үнэлгээ мониторингийн төлөвлөгөө

## 2С. Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

Байгаль хамгааллын ажлыг эцсийн дүндээ хүмүүс болон байгууллага хэрэгжүүлдэг. Бодит ажил хэрэг болгож чадахгүй бол хамгийн сайн стратегийн төлөвлөгөө эсвэл мониторингийн төлөвлөгөө байгаад ч төдийлөн ач холбогдол өгдөггүй. Иймээс энэ дэд алхам нь үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад чиглэнэ. **Үйл ажиллагааны төлөвлөгөө** нь үндсэндээ дараах чиглэлтэй байна:

- **Хүний нөөц ба чадавх**-Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, ур чадвар болон санхүүгийн бус бусад нөөцийг тодорхойлох ба хэрхэн хөгжүүлэх (хамтын ажиллагааг бэхжүүлэхийг оролцуулан) арга замаа олж тогтооно. Өөрчлөлтийн онол, үйл ажиллагаанд тулгуурлан хугацаа, шаардлагатай ур чадварыг тодорхойлно.
- **Санхүүжилт**-Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг тодорхойлж, одоогийн болон боломжит эх үүсвэрүүдийг нэгтгэнэ. Тонго төхөөрөмжийн зардлуудыг мөн тусгана.
- **Эрсдэлт хүчин зүйлс**-Төлөвлөгөөний хэрэгжилт болон зорилгод сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдлүүдийг (хөтөлбөрийн болон үйл ажиллагааны) тодорхойлж, энэ эрсдлүүд тохиолдох магадлал, нөлөөллийг мөн үнэлнэ. Түүнчлэн эрсдлийг бууруулах, зайлсхийхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг тодорхойлно. Эрсдэлийн үнэлгээ нь арга хэмжээ сонгох үйл явцад чухал суурь мэдээлэл болдог.
- **Нийгмийн хамгааллын арга хэмжээ**-Хувь хүн, орон нутгийн иргэдэд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэх нийгмийн хамгааллын зохицуулалтуудыг тодорхойлно. Энэ нь эмзэг болон тусгаарлагдсан бүлгүүдийн эрх, сайн сайхан байдал, ашиг сонирхлыг хүндэтгэн хамгаалахад чиглэнэ. Жишээлбэл, FPIC, өргөдөл гомдол шийдвэрлэх механизм, ажилтнуудад зориулсан ёс зүйн сургалт гэх мэт.

- **Шилжилтийн ба тогтвортой байдлын стратеги** Төлөвлөгөө хэрэгжээд дууссаны дараа үр дүнгээ тогтвортойгоор хэрхэн хангахаа тодорхойлох нь зүйтэй. Хэдийгээр үүнийг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан ч гэлээ төлөвлөлтийн эхний алхамд ч тогтвортой байдал, шилжилтийн хувилбаруудыг тооцож оруулах нь чухал. Ингэснээр холбогдох үйл арга хэмжээнүүд ажлын төлөвлөгөөнд багтаж, хэрэгжилтийн явцад сайжруулах боломж бүрддэг. Үүнийг орхигдуулбал оролцогч талуудын дунд бодит бус хүлээлт үүсгэж, цаашид зохицуулалт хийхэд хүндрэлтэй болгодог.

Үйл ажиллагааны төлөвлөгөө гэдэг бол үндсэндээ ажлын төлөвлөгөө болон төсөв хоёрын нийлбэр юм. Үүнийг [Алхам 3](#)-т дэлгэрэнгүй авч үзнэ. Гүйцэтгэлийн төлөвлөгөө хэр зэрэг дэлгэрэнгүй байх, албан ёсны хэлбэр нь ямар түвшинд байх нь ерөнхий байгаль хамгааллын төлөвлөлтийн цар хүрээ болон бүтцээс хамаардаг. Жижиг хэмжээний төслүүд товчхон үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байдаг бол том төслүүдийн хувьд дээр дурдсан чиглэл тус бүрийг нэлээд дэлгэрэнгүй, албан ёсны байдлаар тусгасан гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй байна.

Энэ алхмын төгсгөлд байгаль хамгааллын төлөвлөгөөний үндсэн бүтээгдэхүүн бүрдсэн байдаг ([Зураг 8](#)). Хэрэгцээнээсээ шалтгаалан энэ мэдээллүүдийг нэгтгэн албан ёсны төлөвлөгөө болгон эмхэтгэж болно. Эсвэл Miradi зэрэг програм ашиглаж байгаа бол мэдээллээ тухайн програмд хадгалж, шаардлагатай үед холбогдох төлөвлөгөө, баримт бичгийг гарган ашиглах боломжтой. Ингэснээр хийж буй ажил хөгжихийн хэрээр хялбархан шинэчилж болдог “амьд” төлөвлөгөө бий болно. Үүнээс гадна энэ нь төсөв гэх мэт бусад системтэй тасралтгүй уялдуулах боломжийг олгодог.

## ЭНЭ АЛХМЫН ХҮРЭЭНД ГАРАХ ҮР ДҮН:

- Хүний нөөц, санхүү болон бусад нөөцийн үнэлгээ
- Эрсдлийн үнэлгээ болон эрсдлийг бууруулах арга хэмжээ
- Нийгмийн хамгааллын зохицуулалтууд
- Төслийн үргэлжлэх хугацааны тооцоо болон шилжилтийн стратеги

## АШИГЛАХ МАТЕРИАЛ

Байгаль хамгааллын стандартын цахим сан (“Plan” шүүлтүүрийг сонгож, дараа нь шаардлагатай бол guidance, case studies зэрэг нэр томъёогоор хайлт хийнэ)

Байгаль хамгааллын практик аргачлал: Байгаль хамгааллын стандарт (Аргачлалтай холбоотой зөвлөмжтэй танилцахын зэрэгцээ “Examples & Resources” “Plan” хэсгүүдийг харж болно)

Байгаль хамгааллын стандартыг практикт хэрэгжүүлсэн туршлага



PHOTO: SARA ESTLANDER



# ХЭРЭГЖҮҮЛЭХ



# ХЭРЭГЖҮҮЛЭХ

Энэ алхамд төлөвлөлтийн менежментийн зарчмуудыг ашиглан 1, 2-р алхамд хийсэн төлөвлөлтийн ажлыг бодит хэрэгжилтэд шилжүүлнэ. 3-р алхам нь тодорхой ажлын төлөвлөгөөг (8-р зураг) боловсруулж хэрэгжүүлэх бөгөөд үүний зэрэгцээ хүний нөөц, тоног төхөөрөмж, санхүү, шаардлагатай ур чадвар, мэдлэг, мөн хамтрагч талуудыг хангалттай бүрдүүлсэн байх шаардлагатай. Эдгээр ажлыг хэрэгжүүлэхдээ тухайн хэрэгжүүлэгч баг байгууллагын бодлого, журам, мөн ажлын төлөвлөгөө, төсөв батлах шийдвэр гаргах үйл явцын хүрээнд ажиллана. Хэрэгжилтийн шатанд бүгдийг төгс байлгах, эсвэл бүх нөхцөл бүрэн бүрдэхийг хүлээх шаардлагагүй. Ажлын төлөвлөгөө (мөн стратегийн төлөвлөгөө) нь цаг хугацааны явцад тасралтгүй сайжирч, хөгжиж байдаг.

## 3А. Багийн бүтэц, ажлын үйл явцыг эргэн нягтлах


Багийн бүтэц, бүрэлдэхүүн цаг хугацааны явцад өөрчлөгдөж байдаг. Заримдаа төлөвлөлтийн хэрэгжүүлэх алхамд оролцож буй хүмүүс бүх үе шатанд оролцоогүй байх тохиолдол бий. “Хэрэгжүүлэх” алхам нь төлөвлөлтийн баг, дэмжлэг үзүүлэх мэргэжилтнүүдийг (жишээ нь санхүү, хөрөнгө босголт, харилцаа холбоо) дахин авч үзэх тохиромжтой үе шат юм. Ингэснээр хэрэгжилтийг дэмжихэд шаардлагатай зөв бүтэц, зөв түншлэл бүрдсэн эсэхийг нягталж, төлөвлөлтийн багт дутагдаж буй мэргэжлийн ур чадвар, туршлагыг нөхөх боломж бүрдэнэ.

**2-р алхамд** боловсруулсан мониторингын төлөвлөгөө нь гол оролцогч талууд болон тэдний мэдээллийн хэрэгцээг тодорхойлсон байх ёстой. Гэхдээ ажлын төлөвлөгөөг боловсруулах явцад төслийн амжилттай хэрэгжихээд нөлөөлж болох нэмэлт хүмүүс, талууд байгаа эсэхийг мөн бодолцох хэрэгтэй. Иймээс талуудтай мэдээлэл солилцох үйл ажиллагааг ажлын төлөвлөгөөнд тусгах нь чухал бөгөөд төслийн хугацаанд оролцогч талуудтай мэдээлэл хуваалцах тусгай харилцаа холбооны стратеги боловсруулах шаардлага ч гарч болно.

Энэ шатанд багийн дүрэм, хамтын ажиллагаатай холбоотой гэрээ, тохиролцоонуудыг (1-р алхмыг харна уу) дахин нягталж, шаардлагатай бол шинээр боловсруулан байгууллага болон хувь хүмүүсийн үүрэг, хариуцлагыг тодорхой болгоно. Хэрэв хараахан хийгдээгүй бол боломжит хамтрагч талуудыг эргэн харах тохиромжтой үе.

Багийн бүтцийг эргэн харахдаа багийн ажлыг уялдуулж, чиглүүлэн авч явах тодорхой, хариуцсан ахлагч байгаа эсэхийг баталгаажуулна. Мөн ажлыг хэрхэн хэрэгжүүлэх талаар багийн бүх гишүүд нэг ойлголттой байхын тулд хамтран мөрдөх нийтлэг зарчим, хэм хэмжээг тодорхойлох нь зүйтэй. Эдгээр зарчим нь багийн гишүүд болон сонирхогч талуудад шударга, тэгш хандах үйл явцыг хангахад чиглэсэн байх ёстой.

Энэхүү ойлголт нь багийн дотоод зохион байгуулалт, мөн ажлыг хэрхэн хэрэгжүүлж буй арга барилд тусгалаа олох ёстой. Хэрэв төсөл олон жилийн турш үргэлжлэхээр байвал багийн залгамж халааг хэрхэн зохион байгуулах талаар урьдчилан бодолцох нь зүйтэй. Тухайлбал, гаргасан шийдвэрүүд болон явцын мэдээллийг тогтмол баримтжуулснаар шинэ гишүүдийг багт хялбар, үр дүнтэйгээр ажлаа эхлүүлэх боломжийг бүрдүүлнэ.



### ЭНЭ АЛХАМААС ГАРАХ ҮР:

- Шинэчилсэн багийн дүрэм болон шаардлагатай тохиолдолд хамтын ажиллагааны бусад гэрээ, тохиролцоонууд
- Оролцогч талуудыг төслийн явцын талаар тогтмол мэдээлэлтэй байлгаж, оролцоог хадгалах арга замыг тодорхойлсон шинэчилсэн харилцаа холбооны стратеги

## 3В. Нарийвчилсан, богино хугацааны ажлын төлөвлөгөө боловсруулах

Байгаль хамгааллын стандартын өмнөх алхмуудад стратегийн төлөвлөгөө, мониторингийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулсан ([8-р зураг](#)). Энэ алхамд эдгээр ерөнхий төлөвлөгөөнүүдийг илүү тодорхой, хэрэгжихүйц төлөвлөгөө болгон, тасралтгүй хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ алхмын эхний хэсэгт төлөвлөлтийн баг болон хамтрагч талуудын оролцоотой стратегийн төлөвлөгөө (ялангуяа зорилго, зорилтууд, өөрчлөлтийн онол), үйл ажиллагааны төлөвлөгөөнд тулгуурлан ойрын хугацаанд хэрэгжүүлэх **ажлын төлөвлөгөөг** боловсруулна.

Энэхүү ажлын төлөвлөгөөний хугацаа нь ихдээ нэг жил байна. Ажлын төлөвлөгөө нь баг, байгууллага бүрт өөр өөр хэлбэртэй байж болох ч, дор хаяж дараах агуулгыг заавал багтаасан байх ёстой.

- Стратегийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай **тодорхой үйл ажиллагаа, даалгаврууд**. Үйл ажиллагааны хүрээнд дараах ажлуудыг мөн тусгана. Үүнд:
  - » Төслийн уялдаа, зохицуулалтыг хангах (жишээлбэл, долоо хоногийн уулзалт зохион байгуулах/оролцох, түншлэл хөгжүүлэх, оролцогч талуудтай харилцах, FPIC үйл явцыг эцэслэх);
  - » Ахиц дэвшил болон/эсвэл тодорхойгүй асуудлуудыг хянах;
  - » Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх (жишээлбэл, харилцаа холбоо, санхүүжилт босгох, зөрчил шийдвэрлэх үйл явц);
  - » Үнэлгээнүүдийг хянах, шинэчлэх (жишээлбэл, нөхцөл байдлын дүн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ, оролцогч талуудын үнэлгээ);
  - » Ахицыг дүн шинжилж, шаардлагатай өөрчлөлтийг хийх;
  - » Төслийн явц, шинэчлэлийг талуудтай хуваалцах.

- **Үйл ажиллагаа, даалгавар бүрийг хэн гүйцэтгэх, хэн хариуцах** зэргийг тодорхойлж, үүрэг гүйцэтгэхэд нөлөөлж болзошгүй саад бэрхшээл, эрх мэдлийн харилцаа, нийгмийн хэвшмэл ойлголтыг харгалзан үзнэ. Олон талт төслүүдэд үүрэг, хариуцлагыг тодорхой болгохын тулд албан тушаал, хувь хүн эсвэл байгууллагын нэрийг зааж, шаардлагатай тохиолдолд RACI, MOSNA зэрэг аргуудыг ашиглана.
- **Үйл ажиллагаа бүрийг хэзээ, ямар** дарааллаар хэрэгжүүлэхийг тодорхойлж, зорилго, зорилтуудад заасан хугацаатай уялдуулна.
- **Зарим үйл ажиллагаа тодорхой газар нутагт** хамаардаг тул үйл ажиллагааны байршлыг тодорхой тусгах.

Таны байгууллага эсвэл багийн дүрэмд ажлын төлөвлөгөөний хугацааг зааж өгсөн байж болно. Ерөнхийдөө ирэх 3–12 сарын дэлгэрэнгүй ажлын төлөвлөгөө боловсруулж, урт хугацааны хувьд ерөнхий байх нь тохиромжтой. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр ерөнхий төлөвлөгөөг нарийвчилж, зорилго, зорилтуултай нийцүүлэн нарийвчлан боловсруулж болно.








Дэлгэрэнгүй ажлын төлөвлөгөө нь төслийн хугацааг боловсруулах үндэс болно. Цагийн хуваарийг зөв гаргах нь багийн гишүүд төслийн хэрэгцээнд тохируулан өөрийн цагийг төлөвлөхөд чухал. Мөн ажлын төлөвлөгөө нь аль гишүүд боломжтой цагтай, аль нь хэт ачаалалтай байгааг тодорхойлоход тусална. Хэрэв мэргэжилтнүүд хэт ачаалалтай бол баг дотроо эсвэл хамтрагч талуудын оролцоотой дахин хувиарлаж, зарим үйл ажиллагааг хойшлуулах эсвэл цуцлах зэрэг арга хэмжээ авах шаардлагатай.

Төлөвлөлтийн явцад өөрчлөлтийн онолыг эргэн харж, ажлын төлөвлөгөөгөө тогтмол шинэчилж байх, ингэснээр ингэснээр ойрын хугацаанд хийх тодорхой үйл ажиллагаанд төвлөрөх нь зүйтэй. Жишээ нь [Зураг 18](#) -д төслийн үйл ажиллагаа, мониторингийн үйл ажиллагаанд хуваарилагдсан хүмүүстэй хүснэгтийг үзүүлж байна.




Ерөнхийдөө багийн ажлын төлөвлөлтөө баримтжуулах, мөн хэрэгжилтийг тогтмол хянах тогтолцоотой байх нь чухал (жишээлбэл, ажлын төлөвлөлтийн программ, хүснэгт, төслийн календарь). Ямар ч хэрэгсэл ашигласан бай, тухайн хэрэгсэл нь нөхцөл байдал өөрчлөгдөхөд ажлын төлөвлөгөөг хялбархан тохируулж, шинэчлэх боломжтой байх ёстой.

Мөн төслийн хэрэгжилтийн явцыг төслийн багаас гадна оролцогч талуудад (жишээлбэл, санхүүжүүлэгчид, төслийн баг, түншүүд) хялбархан хуваалцах боломжтой системийг бий болгох нь зүйтэй. Жишээ нь Dashboard-мэдээллийн самбар нь хэрэгжилтийн явцыг ойлгомжтой, үр дүнтэй харуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

**ЗУРАГ 18** Ажлын төлөвлөгөөний жишээ ба ажлын нэгжүүдийн хуваарь

АРГА ХЭМЖЭЭ & ҮЙЛ АЖИЛЛАГАА	1-P CAP	2-P CAP	3-P CAP	Q1
<b>АКУЛЫН СЭРВЭЭНИЙ ШӨЛ ИДЭХИЙГ ЗОГСООХ СУРТАЛЧИЛГААНЫ АЖИЛ</b> 	<b>7</b>	<b>3.5</b>	<b>24</b>	<b>34.5</b>
<b>SHARK 1. CAI-тай хамтран сурталчилгааны ажил төлөвлөх</b> 	<b>7</b>	<b>1.5</b>	<b>1</b>	<b>9.5</b>
AT: Anna Thomas	5	1	1	7
EM: Elena Martin	2	0.5	-	2.5
<b>SHARK 2. Танилцуулга/сурталчилгааны ажил хэрэгжүүлэх</b> 	-	-	<b>15</b>	<b>15</b>
AT: Anna Thomas	-	-	10	10
EM: Elena Martin	-	-	5	5
<b>SHARK M1. Сурталчилгааны ажлын бүртгэлүүдийг хянах</b> 	-	-	<b>2</b>	<b>2</b>
AT: Anna Thomas	-	-	2	2
<b>SHARK M2. Орон нутгийнханыг сургах</b> 	-	<b>2</b>	<b>5</b>	<b>7</b>
AT: Anna Thomas	-	2	5	7
<b>SHARK M3. Сурталчилгааны ажлын үр дүнд дүн шинжилгээ хийх</b> 	-	-	<b>1</b>	<b>1</b>
EM: Elena Martin	-	-	1	1
<b>АЯЛАЛЫН ЗАВЬНУУД ЗААВАЛ ХАРХНЫ ХААЛТТАЙ БАЙХ БОДЛОГО</b> 	<b>4</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>7</b>

### ТАНИХ ТЭМДЭГ

-  Арга хэмжээ
-  Үйл ажиллагаа
-  Мониторинг ү/а

### ЭНЭ АЛХАМААС ГАРАХ ҮР ДҮН:

- Стратеги, мониторинг, үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдтэй уялдсан үйл ажиллагаа, даалгавар, үүрэг хариуцлагыг нарийвчлан тусгасан ажлын төлөвлөгөө
- Төслийн хугацааны хуваарь буюу хуанли

### 3С. Төслийн төсвийг боловсруулж, сайжруулах

Ажлын төлөвлөгөө нь төслийн төсөв боловсруулахад чухал суурь мэдээлэл болдог. Энэ үед хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаа, даалгаврууд тодорхой болсон байх тул стратегийн төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай хугацаа болон санхүүгийн нөөцийг илүү бодитойгоор тооцоолох боломж бүрдэнэ. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд ([Алхам 2С](#)) боловсруулсан санхүүжилтийн анхан шатны тооцоог эхний суурь болгон ашиглана. Үүнийг стратегийн төлөвлөгөө болон ажлын төлөвлөгөөтэй уялдуулснаар тодорхой үйл ажиллагаа, тэдгээрийг нэгтгэсэн өргөн хүрээний арга хэмжээ, стратегийн зардлыг илүү нарийвчлан тооцоолж чадна.







Төлөвлөгөөний төсвийг боловсруулахдаа (шаардлагатай тохиолдолд) байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудтай хамтран ажиллах хэрэгтэй. Ихэнх төслүүдийн хувьд хамгийн их зардал нь ажилтнуудын цаг хугацаа байдаг. Үүнээс гадна тоног төхөөрөмж, аяллын зардал, бараа, үйлчилгээ зэрэг бусад томоохон зардлуудыг тооцох шаардлагатай. Үйл ажиллагаа бүртэй холбоотой ажилтнаас бусад зардлыг орхигдуулахгүй байхад анхаарна. Мөн мониторинг, удирдлага, хамгаалаллын арга хэмжээ, захиргаа, логистик, чадавх бэхжүүлэх зэрэг нэмэлт чиг үүрэг, дэмжих нөөцүүдийн зардлыг тусгана. Түүнчлэн хүртээмж болон сайн дурын үйл ажиллагаатай холбоотой зардлууд (жишээлбэл, тээвэр, хоол)-ыг тооцох нь зүйтэй.

Олон байгууллага, агентлаг, эсвэл улс оролцсон төслүүдийн хувьд төсөвлөлт илүү төвөгтэй байж болох бөгөөд санхүүжүүлэгч эсвэл хяналт тавих байгууллагын шаардлага төсөв боловсруулах арга барилд нөлөөлнө. Ашиглах төсөвлөлтийн систем нь төслийн нөхцөл байдлаас хамаарна. Жижиг төслүүдэд хүснэгт хангалттай байж болох бол, илүү том төслүүдэд Мирази зэрэг хэрэгсэл ашиглах нь стратеги, ажлын төлөвлөгөөг төсөвтэй уялдуулах боломж олгодог. Ийм хэрэгслийн тусламжтайгаар санхүүжилтгүй үлдсэн үйл ажиллагаа, зардлыг хурдан илрүүлж, санхүүжилтын цоорхойг тодорхой харах боломж бүрдэнэ.



[19-р зурагт 18-р зурагт](#) үзүүлсэн ажлын төлөвлөгөөг төслийн арга хэмжээ болон мониторингийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлуудыг нэмж тусган харуулсан болно. Ажилтнаас бусад зардлуудыг тухайн үйл ажиллагаанд хуваарилагдсан хүмүүсийн ажлын цагийн зардалтай нэгтгэсэнээр ажил бүрийн нийт төсөв бүрдэнэ. Энэ жишээнд ажилтнуудын зардал болон бусад зардлыг нэгтгэн үйл ажиллагаа тус бүрийн зардал, тухайн арга хэмжээнд хамаарах бүх үйл ажиллагааны нийт зардал, мөн төслийн стратеги бүрийн хүрээнд хэрэгжих бүх арга хэмжээний зардлыг харуулсан байна. Төслийн төсөвт мөн тоног төхөөрөмж болон ерөнхий үйл ажиллагааны зардлууд зэрэг, тодорхой нэг арга хэмжээ эсвэл үйл ажиллагаатай шууд холбоогүй бусад зардлуудыг тусгасан байдаг.

ЗУРАГ 19 Ажлын төлөвлөгөөний жишээ-зардал болон нэмэлт өртгүүдийг оруулсан

АРГА ХЭМЖЭЭ & ҮЙЛ АЖИЛЛАГАА	АЖЛЫН НЭГЖ				ТӨСЛИЙН ЗАРДАЛ				НИЙТ ТӨСӨВ
	2025	2026	2027	НИЙТ	2025	2026	2027	НИЙТ	НИЙТ
<b>АКУЛЫН СЭРВЭЭНИЙ ШӨЛ ИДЭХИЙГ ЗОГСООХ СУРТАЛЧИЛАГААНЫ АЖИЛ</b> 	<b>36.5</b>	<b>14</b>	<b>9</b>	<b>52.5</b>	<b>5,000</b>	<b>1,250</b>	<b>1,250</b>	<b>8,100</b>	<b>13,625</b>
<b>SHARK 1. CAI-тай хамтран сурталчилгааны ажил төлөвлөх</b> 	<b>11.5</b>	-	-	<b>11.5</b>	<b>5,000</b>	-	-	<b>5,000</b>	<b>5,925</b>
AT: Anna Thomas	8	-	-	8	-	-	-	-	400
EM: Elena Martin	3.5	-	-	3.5	-	-	-	-	525
Уулзалт хийх аялалын зардал	-	-	-	-	5,000	-	-	5,000	5,000
<b>SHARK 2. Танилцуулга/сурталчилгааны ажил</b> 	<b>15</b>	<b>5</b>	-	<b>20</b>	-	-	-	-	<b>1,700</b>
AT: Anna Thomas	10	3	-	13	-	-	-	-	650
EM: Elena Martin	-5	2	-	7	-	-	-	-	1,050
<b>SHARK M1. Сурталчилгааны ажлын бүртгэлүүдийг хянах</b> 	<b>2</b>	<b>4</b>	<b>4</b>	<b>10</b>	-	-	-	-	<b>500</b>
AT: Anna Thomas	2	4	4	10	-	-	-	-	500
<b>SHARK M2. Орон нутгийнханыг сургах</b> 	-	<b>4</b>	<b>4</b>	<b>8</b>	-	<b>1,250</b>	<b>1,250</b>	<b>2,500</b>	<b>4,750</b>
EM: Elena Martin	-	4	4	8	-	-	-	-	2,250
Өгөгдөл цуглуулах аялалын зардал	-	-	-	-	-	1,250	1,250	2,500	2,500
<b>SHARK M3. Сурталчилгааны ажлын үр дүнд дүн шинжилгээ хийх</b> 	<b>1</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>3</b>	-	-	-	<b>600</b>	<b>750</b>
AT: Anna Thomas	1	1	1	3	-	-	-	-	150
Худалдан авалтын тайлан	-	-	-	-	-	-	-	600	600
<b>БУСАД ЗАРДАЛ</b>	-	-	-	-	<b>55,000</b>	<b>25,000</b>	<b>20,000</b>	<b>100,000</b>	<b>100,000</b>
<b>ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ</b>	-	-	-	-	<b>20,000</b>	<b>5,000</b>	-	<b>25,000</b>	<b>25,000</b>
Компьютер	-	-	-	-	-	5,000	-	5,000	5,000
Тэргэнцэрт ээлтэй тээврийн хэрэгсэл	-	-	-	-	20,000	-	-	20,000	20,000
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	-	-	-	-	<b>35,000</b>	<b>20,000</b>	<b>20,000</b>	<b>75,000</b>	<b>75,000</b>
Менежментийн зардал	-	-	-	-	35,000	20,000	20,000	75,000	75,000

## ТАНИХ ТЭМДЭГ

 Арга хэмжээ
  ү/а
  Мониторинг ү/а

Төслийн төсвийг боловсруулсны дараа боломжит санхүүжилтийн эх үүсвэрүүдийг тодорхойлж, төслийн санал илгээх шаардлага ихэнхдээ гардаг. Стратегийн төлөвлөгөө болон ажлын төлөвлөгөөнд нэгтгэсэн мэдээллүүд нь найдвартай, үндэслэлтэй санхүүжилтийн санал боловсруулахад ашиглагдана. Ихэнх төлөвлөгөөнүүд олон жилийн турш санхүүжилт шаарддаг тул хөрөнгө босголт нь төлөвлөгөөний хэрэгжилтийн туршид тасралтгүй үргэлжлэх үйл явц байдаг. Иймээс хөрөнгө босгох тодорхой стратеги боловсруулах, мөн түншүүдтэйгээ санхүүжилтийг хамтад нь эсвэл тус тусад нь босгох эсэхийг урьдчилан тохиролцох нь зүйтэй.

Санхүүжилтийн санал боловсруулахдаа стратегийн төлөвлөгөөнд тулгуурахаас гадна төслийн явцад гарсан үр дүн, сургамж, өөрчлөлтүүдийг тусган санхүүжүүлэгчдэд ахиц дэвшил, суралцах үйл явц, дасан зохицох чадамжтай байгаагаа харуулах боломжтой. Ингэснээр Байгаль хамгааллын стандартыг ашиглахын үнэ цэнийг санхүүжүүлэгчид ойлгуулах боломжтой юм. Үүнд стратегийн шийдвэр гаргалтаас эхлээд ахиц, үр нөлөөг хэмжих тодорхой аргачлал, мөн мониторинг, дүн шинжилгээ, уян хатан менежментэд суурилсан шүүмжлэлт сэтгэлгээ багтана. Санхүүжүүлэгчид өөрчлөлтийн онол зэрэг тодорхой бүрэлдэхүүн хэсгүүдийг шаардах нь нийтлэг. Иймд Байгаль хамгааллын стандартын аргачлалаар ажиллах нь эдгээр шаардлагыг хангахад давуу тал болдог.

Юун түрүүнд хамгийн чухал, ач холбогдолтой арга хэмжээнүүдэд санхүүжилт татах нь зохимжтой. Гэвч бодит нөхцөл байдал санхүүгийн боломж, хязгаарлалтаа нийцүүлэн уян хатан хандах шаардлага үүсч, ач холбогдлын хувьд дунд эсвэл бага ач холбогдолтой арга хэмжээнд төвлөрөх тохиолдол бий. Энэ нь байж болох зүйл бөгөөд гол нь өндөр ач холбогдолтой арга хэмжээнүүдээ марталгүй, боломж бүрдэх үед аль болох хурдан хэрэгжүүлэхэд анхаарах явдал юм.

Мөн энэ үе шатанд төслийн зорилго, зорилтуудыг төлөвлөсөн хугацаанд, боломжит хүний нөөц ба санхүүжилтийн хүрээнд биелүүлэх боломжтой эсэхийг эргэн тунгаах нь зүйтэй. Үүний хүрээнд зарим чухал шийдвэрүүд гаргах шаардлага гарч болно. Тухайлбал, зарим арга хэмжээ, үйл ажиллагаа, даалгаврыг хасах, хойшлуулах, багасгах, эсвэл чадавхтай хамтрагч талд шилжүүлэх зэрэг. Мөн шаардлагатай дасан зохицох өөрчлөлтүүдийг тодорхойлж, төсөл бүхэлдээ үр дүнтэй хэвээр үлдэх эсэх, цааш үргэлжлүүлэх нь зүйтэй эсэхийг нухацтай авч үзнэ.

### ЭНЭ АЛХАМААС ГАРАХ ҮР ДҮН:

- Төслийн төсөв
- Боломжит санхүүжилтийн жагсаалт
- Санхүүжилт авах төслийн санал (боловсруулагдсан бас илгээгдсэн)



### 3D. Төлөвлөгөө хэрэгжүүлэх

Стратеги, мониторинг болон үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг төлөвлөсөн хугацаа, батлагдсан төсвийн хүрээнд бодит ажил болгох үйл явцыг төлөвлөгөө хэрэгжүүлэх гэж тодорхойлдог. Юун түрүүнд төлөвлөгөө хэрэгжүүлэх багаараа анхны уулзалтыг зохион байгуулах нь (ялангуяа шинэ гишүүд байгаа тохиолдолд) зүйтэй. Энэ нь багийн уялдаа холбоог бэхжүүлэхийн зэрэгцээ төслийн загвар, багийн дүрэм, төсвийн хуваарилалт, санхүүжүүлэгчдийн гэрээний нөхцөл, байгууллагын дотоод журам болон бусад холбогдох мэдээлэлийг жигд танилцуулах боломж юм.

Мөн дотоод шийдвэрийг ямар зарчимд үндэслэн гаргах, үүсэж болзошгүй маргаан, зөрчлийг хэрхэн шийдвэрлэх талаар нэгдсэн ойлголттой болоход тохиромжтой мөч юм. Багийн гишүүд төслийн талаар дотооддоо хэрхэн мэдээлэл солилцох, үр дүн, явцыг олон нийтэд хэрхэн тайлагнах талаар нэгдсэн, тодорхой ойлголттой болоход харилцаа холбооны Багийн уулзалтуудыг тогтмол зохион

байгуулах нь төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг тогтмол хянах, нэн тэргүүний ажлуудаа төлөвлөх, харилцаа холбоотой байх, асуудлуудыг хамтран шийдвэрлэх, бие биеэ дэмжих боломж бүрдэнэ. Мөн эдгээр уулзалтууд нь [4-р болон 5-р алхмын](#) тогтмол хэрэгжүүлэх орон зай болох ёстой.




Хэрэгжилтийн явцыг хянахдаа (жишээ нь: үйл ажиллагааны явц, санхүү, эрсдэлийн удирдлага, нийгмийн хамгааллын асуудлууд) олон аргачлал, хэрэгслүүдийг ашиглаж болно. Хэрэгжилтийн талаар богино, тогтмол явцын тайлан гаргаж байх нь дараагийн алхмуудад илүү гүнзгий дүгнэлт хийхэд дэмжлэг болно. Үүнийг санхүүжүүлэгчдэд тайлагнах хэрэгсэл болгон ашиглаж болдог.

Жилд дор хаяж нэг удаа өөрчлөлтийн онолоо эргэн харж ахиц дэвшлээ үнэлэх нь чухал ([4В алхамд](#) дэлгэрэнгүй тайлбарласан). Зураг 20 ба [21](#) нь үйл ажиллагааны явцыг тайлагнах өөр өөр хэлбэрүүдийг харуулсан.


**ЗУРАГ 20** Явцын тайлангийн жишээ (хүснэгтээр илэрхийлсэн)

АРГА ХЭМЖЭЭ & ҮЙЛ АЖИЛЛАГАА	ЯВЦ	ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ
<b>АКУЛЫН СЭРВЭЭГЭЭР ШӨЛ ХИЙХИЙГ ЗОГСООХ СУРТАЛЧИЛГААНА АЖИЛ</b>	Хэвийн	-
SHARK 1. CAI-тай хамтран сурталчилгааны ажил төлөвлөх	Хэрэгжсэн	Хэрэгжсэн
SHARK 2. Танилцуулга/сурталчилгааны ажил хэрэгжүүлэх	Хэвийн	Эхэлсэн боловч түлхэц хэрэгтэй
SHARK M1. Сурталчилгааны ажлын бүртгэлүүдийг хянах	Жижиг асуудал	Найдвартай өгөгдөл цуглуулах үйл явцыг байгуулахад одоо хүртэл хүндрэлтэй байна
SHARK M2. Орон нутгийнханыг сургах	Хуваарьт орсон	-
SHARK M3. Сурталчилгааны ажлын үр дүнд дүн шинжилгээ хийх	Жижиг асуудал	Өнгөрсөн улирлын мэдээлэл хараахан цуглуулаагүй байна.
<b>ХАРХ УСТГАЛ</b>	<b>Том асуудал</b>	Хавхны стратеги урагшилж байгаа боловч хархнаас хамгаалах хаалт үр ашигтай байгаа эсэх нь эргэлзээтэй
2А. ГОЛ АРЛУУДАД ХАРХЫГ ХАВХААР БАРИХ	Хэвийн	-
2В. АЯЛАЛЫН ЗАВЬНУУД ЗААВАЛ ХАРХНЫ ХААЛТТАЙ БАЙХ БОДЛОГО	Хэвийн	-
RAT 1-1. Бодлого боловсруулахад ашиглахын тулд хархнаас хамгаалах хаалтын технологийг судлах	Хэрэгжсэн	Бодлого боловсруулахад ашиглахын тулд хархнаас хамгаалах технологийг судлах
RAT 1-2. Яамны албан тушаалтнуудад сургалт явуулах	Хэвийн	Компаниуд манай утасны дуудлагад хариу өгөхгүй байна
RAT 1-3. Жуулчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх	Хэвийн	Ажил эрчээ авч эхэлж байна

#### ТАНИХ ТЭМДЭГ

 Арга хэмжээ  Ү/а  Мониторинг үйл ажиллагаа

ЗУРАГ 21 Үр дүнгийн хэлхээний диаграммд суурилсан үйл ажиллагааны явцын тайлангийн жишээ



ҮР ДҮНГИЙН ХЭЛХЭЭ					
Арга хэмжээ	Үйл ажиллагаа	Мониторинг Ү/а	Дунд шатны үр дүн	Аюул дарамт буурсан үр дүн	Био-физик үр дүн
Хамгаалах үнэт зүйл	Хүний сайн сайхны төлөөх зорилт	Зорилт	Зорилго	Шалгуур үзүүлэлт	

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ	
	Бүрэн хэрэгжсэн
	Хуваарийн дагуу явж байгаа
	Жижиг асуудал
	Том асуудал
	Ирээдүйд хийнэ
	Зогсоосон
	Мэдээлэлгүй

Баг мониторингийн өгөгдлийг (хэрэгжилт, үр дүн болон бусад мэдээллийн хэрэгцээтэй холбоотой) цуглуулж эхлэх үед өгөгдлийг цуглуулах, хадгалах, цаашид ашиглах тогтолцоо бүрдсэн байх нь чухал. Энэ үед өгөгдлийн өмчлөл, эрх, хувийн нууц, мөн талуудын хүртээмж зэрэг асуудлыг дахин нягтлах нь зүйтэй.

Хүртээмжийн хувьд жижиг төслүүдэд цаасан эсвэл энгийн компьютерт суурилсан систем хангалттай байж болох бол, илүү нарийн төвөгтэй төслүүдэд байгууллагынхаа олон хэлтэс, нэгжүүд болон/эсвэл түншүүдтэй хамтран ажиллаж, мониторингийн өгөгдлийн

урсгалыг нэг мөр болгох, ашиглах системүүдийг одоогийн системүүдтэй уялдуулах, шаардлагатай сайжруулалт, өөрчлөлтийг тодорхойлох хэрэг гарч болно. Мөн эдгээр системийг бүрдүүлэхэд шаардлагатай хугацаа, нөөцийг ажлын төлөвлөгөө болон төсөвт заавал тусгахыг санана уу.

**Алхам 4** (Дүн шинжилгээ хийх ба дасан зохицох)-д шилжихийн өмнө өгөгдөл нэгтгэгдсэн, бүрэн, үнэн зөв, энгийн, боловсруулж ашиглах боломжтой эсэхийг шалгах нь зүйтэй. 22-р зурагт Харх устгах стратегийн хүрээнд сонгосон цөөн шалгуур үзүүлэлтийн хяналт-шинжилгээний өгөгдлийн жишээг үзүүлсэн болно.

**ЗУРАГ 22** Мониторингийн жишээ

ИТЕМ	ДЭЛГЭРЭНГҮЙ	ХЭМЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ	ХЭМЖИЛТИЙН УТГА	ЧИГ ХАНДЛАГА	ЭХ СУРВАЛЖ
<b>2. ХАРХ УСТГАЛ</b>	Хархнууд гол арлууд дээр байх далайн шувуудын үүрлэлтийг сүйтгэж байгааг их сургуулийн судлаачдын мониторингийн үр дүн харуулж байна	-	-	-	-
<b>RAT 1. АЯЛЛЫН ЗАВИНД ХАРХНЫ ХААЛТ БАЙРШУУЛАХ</b>	2026 оны 6-р сарын байдлаар Eastern Bay арлуудыг зорьж буй аяллын завь бүрт хархны хаалт байрлуулсан байна	-	-	-	-
<b>Rat1. Хархны хаалттай аяллын завьны хувь</b>	Арал руу зорчдог бүх аяллын завинуудын хэдэн хувь нь хархнаас хамгаалах хаалтаар тоноглогдсон	2026-06-30	70	Тодорхойгүй	Багацаалдах
<b>RAT 2. ГОЛ АРЛУУДААС ХАРХЫГ УСТГАХ</b>	2029 оны зургадугаар сар гэхэд бүх үржлийн арлуудаас хархыг бүрэн устгасан байна	-	-	-	-
<b>Rat 2a. Хавханд орсон хархны тоо</b>	Нэг арлын хувьд нэг долоо хоногийн турш байрлуулсан хавханд баригдсан хархны нийт тоо, популяцыг бүрэн устгасан гэдэгт бүрэн итгэлтэй болохын тулд дараалан гурван долоо хоногт нэг ч харх баригдахгүй байх шаардлагатай гэж бид үздэг	2026-06-30	Их хэмжээний	Аажим буурах	Түргэвчилсэн үнэлгээ
<b>Е. ХЭВИЙН ҮҮРЛЭСЭН ДАЛАЙН ШУВУУДЫН ПОПУЛЯЦИ</b>	2035 он гэхэд Eastern Bay арлууд дээр дор хаяж 750 паффин шувууны үржлийн хостой болсон байх	-	-	-	-
<b>E1. Паффин шувууны үржлийн хосийн тоо</b>		2026-06-30	210	Эрчимтэй буурах	Эрчимжүүлсэн үнэлгээ
		2016-03-31	1200	Хэвийн	Эрчимжүүлсэн үнэлгээ



PHOTO: CLEMENT KOLOPP

## АШИГЛАХ МАТЕРИАЛ

Байгаль хамгааллын стандартын цахим сан (“Implement” гэснийг сонгож, дараа нь шаардлагатай бол guidance, case studies зэрэг нэр томъёогоор хайлт хийнэ)

Байгаль хамгааллын практик аргачлал: Байгаль хамгааллын стандартын арга зүй (Аргачлалтай холбоотой зөвлөмжтэй танилцахын зэрэгцээ “Examples & Resources” “Implementation” хэсгүүдийг харж болно)

Байгаль хамгааллын стандартыг практикт хэрэгжүүлсэн туршлага

## ЭНЭ АЛХАМЫН ХҮРЭЭНД ГАРАХ ҮР ДҮН:

- Ажлын төлөвлөгөөнд тусгасны дагуу стратеги, мониторинг, үйл ажиллагааны төлөвлөгөөг төсөв, хугацаанд нийцүүлэн хэрэгжүүлэх
- Өгөгдөл хадгалах, ашиглах системүүд
- Мониторингийн өгөгдлийг цуглуулах тогтсон систем
- Байгууллага, санхүүжүүлэгчид болон бусад талуудад мэдээллийг тогтмол түгээх төслийн хэрэгжилтийн явцын тайлан

АГУУЛГА

ТАНИЛЦУУЛГА

1 ТОДОРХОЙЛОХ

2 ТӨЛӨВЛӨХ

3 ХЭРЭГЖҮҮЛЭХ

4 ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ &amp; ҮЙЛДҮҮЛЭХ

5 ХУВААЛЦАХ

ТӨЛӨВЛӨЛТИЙН МӨЧЛӨГИЙГ ЗАНГИДАХ НЬ

ХАВСРАЛТ



# ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ & УЯЛДУУЛАХ



# ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ & УЯЛДУУЛАХ

Байгаль хамгааллын стандартын энэ алхамд цуглуулж буй өгөгдлийг нэгтгэн боловсруулж, тогтмол дүн шинжилгээ хийснээр хэрэгцээт мэдээлэл, мэдлэг болгон хувиргана. Хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, таамаглал, эргэлзээ, оролцогч талуудаас ирсэн санал, гомдол, түүнчлэн холбогдох үйл ажиллагаа, санхүүгийн өгөгдөл, мэдээнд дүн шинжилгээ хийн, шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөгөө уялдуулан өөрчлөх боломжтой. 2-р алхмын хүрээнд боловсруулсан мониторингийн систем нь энэхүү дүн шинжилгээний цар хүрээг тодорхойлж өгнө. Хэрэв Байгаль хамгааллын стандартыг энэ алхмаас эхлэн хэрэгжүүлж байгаа бол цуглуулсан өгөгдөл, мэдээ, олж авсан сургамж нь цаашдын ажлыг чиглүүлэхийн зэрэгцээ бусад алхмуудтай уялдах, эсвэл тэдгээрийн суурь, үндэслэл болж өгдөг.

Дүн шинжилгээ хийхэд энгийн, хурданаас эхлээд нэлээд цаг хугацаа, нөөц шаардсан нарийн төвөгтэй аргачлал ашиглаж болно. Дүн шинжилгээний түвшин нь мониторингийн аргачлалтай уялдан, тухайн нөхцөл байдалд шаардагдах нотолгоо болон мэдээлэл хүлээн авах талуудын хэрэгцээнд нийцсэн байх ёстой. Түүнчлэн, Байгаль хамгааллын стандартын бусад алхмын нэгэн адил, зөвхөн амжилтаа бус, алдаа, сургамжаа ч эргэцүүлэн харж, хүлээн зөвшөөрөх боломжтой суралцах орчныг бүрдүүлэх нь нэн чухал юм.

## 4А. Өгөгдөл бэлтгэх

Дүн шинжилгээ гэдэг нь анхдагч өгөгдөл, мэдээг шийдвэр гаргахад ашиглаж болохуйц мэдлэг, мэдээлэл болгон хувиргах үйл явц бөгөөд мөчлөгийн турш нэг удаа эсвэл тогтсон нэг хугацаанд хийгдэх түр зуурын шинжтэй үйл явц биш юм. Үйл ажиллагааны явц хэрхэн өрнөж байгааг тасралтгүй ойлгож, шаардлагатай өөрчлөлтийг цаг тухайд нь хийхийн тулд [3-р алхамд](#) боловсруулсан мониторингийн төлөвлөгөөний дагуу өдөр тутмын ажлын нэг хэсэг болгон өгөгдөл, мэдээгээ тогтмол бүртгэн цуглуулж, дүн шинжилгээ хийх шаардлагатай.

Өгөгдөл, мэдээнд дүн шинжилгээ хийх бэлтгэл ажил нь 3 ба 4-р алхмуудын хооронд тасралтгүй үргэлжлэх үйл явц юм. Хөтөлбөр, үйл ажиллагаа болон санхүүгийн бүх өгөгдөл, мэдээгээ тогтмол бүртгэж, хадгалж, боловсруулж, мөн хамгаалж байх ёстой. Анхдагч өгөгдөл, мэдээгээ цуглуулах явцдаа системтэйгээр шалган цэвэрлэж, кодлон, өгөгдлийг эмх цэгцтэй бүртгэн хадгалах нь ажлыг илүү хялбар болгодог. Мөн өгөгдлийг нэг дор төвлөрүүлэн хадгалах мэдээллийн сан бүхий тогтолцоо бий болгож, өгөгдөлд хаанаас, хэрхэн хандах талаар тодорхой заавар гаргах нь үр дүнтэй. Хамтрагч талууд өгөгдөл, мэдээллээ хэрхэн хадгалж, удирдаж байгаагаа харилцан ойлголцож, хоорондоо нийцэхүйц програм хангамж, мэдээллийн урсгалын схем ашиглах нь зүйтэй. Энэ нь ялангуяа хамтын оролцоотой

үнэлгээ, мониторингийн систем (MEL)-д чухал. Үнэлгээ, мониторингийн системийг төлөвлөлтийн эхэн үед бий болгосноор хэрэгжилтийн явцад өгөгдлийг системтэйгээр тасралтгүй цуглуулах, дүн шинжилгээ хийх үйл явцыг үр дүнтэй болгодог.

Үнэлгээ, мониторингийн систем нь төлөвлөгөөнд тодорхойлсон мэдээллийн хэрэгцээг хангахуйц байдлаар өгөгдөл, мэдээг цуглуулан боловсруулж, танилцуулдаг байх ёстой. [4В алхамд](#) шилжих үед оролцогч талууд өгөгдлөөс гарч буй мэдээллийг ойлгон, түүнд тулгуурлан шийдвэр гаргах боломжтой байхаар дүрслэн харуулахад анхаарах хэрэгтэй. Боломжтой бол өгөгдлийг цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, дүрслэн харуулахад зориулсан програм хангамж ашиглан нэгдсэн тайлан болон хянах самбар (dashboard) хийж болно.

### ЭНЭ АЛХМЫН ХҮРЭЭНД ГАРАХ ҮР ДҮН:

- Тогтмол баяжуулж, аюулгүй байдлыг хангаж бүрдүүлсэн мэдээллийн сан
- Шийдвэр гаргахад ашиглах зорилгоор боловсруулан гаргасан мэдээлэл

## 4В. Үр дүнг шинжилж дүгнэлт гаргах

Стратегийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээг хэрэгжүүлж буй болон зорилго, зорилтодоо хүрч буй эсэхээ тогтмол хянаж, системтэйгээр үнэлж байх нь байгаль хамгааллын сайн жишиг юм. Мониторингийн өгөгдөл болон бусад холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл нь менежментийн оновчтой шийдвэр гаргах суурь үндэс болдог.

Мониторингийн өгөгдөл, мэдээлэл нь мэдлэгийн хэрэгцээг нөхөх, үйл ажиллагааны явцыг хянах, дунд шатны үр дүнг тодорхойлох, урт хугацааны зорилгодоо хүрч буй эсэхийг үнэлэх, үйл ажиллагааны явцад санаандгүйгээр гарсан сөрөг үр дагавруудыг баримтжуулахад тусалдаг. Мониторингийн өгөгдлөөс гадна төслийн үнэлгээ, хөндлөнгийн шинжилгээ, оролцогч талуудын үзэл бодол зэрэг бусад нэмэлт мэдээллийг харгалзан үзэх хэрэгтэй. Мониторингийн өгөгдөл, бусад мэдээллийн эх сурвалжид дүн шинжилгээ хийх нь төлөвлөх алхамд (ялангуяа нөхцөл байдлын шинжилгээ болон өөрчлөлтийн онол) дэвшүүлсэн таамаглалууд бодит байдалд хэр биелж байгааг тодорхойлоход тусална. Энэ нь ямар арга хэмжээ амжилттай хэрэгжсэн, аль нь үр дүнгээ өгсөнгүй вэ гэдгийг ойлгоход туслахаас гадна таамаглалуудаа туршиж, дүн шинжилгээ хийснээр төлөвлөгөөгөө нөхцөл байдалдаа нийцүүлэн өөрчлөх, сайжруулах боломжийг олгоно. Ийнхүү хуримтлуулсан мэдлэг, туршлага нь байгаль хамгааллын бусад санаачилгыг чиглүүлэх, улмаар нотолгоонд суурилсан байгаль хамгааллыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна.

Танай баг ажлын төлөвлөгөөгөө хэрэгжүүлж, мониторингийн өгөгдөл, мэдээлэлд дүн шинжилгээ хийн, амжилт, сургамжидаа тулгуурлан төлөвлөлтөө сайжруулан ажиллаж байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор тогтмол дүгнэлт хийж байх хэрэгтэй. Энэ төрлийн дүн шинжилгээг “амсхийх, эргэцүүлэн тунгаах” (pause-reflect) эсвэл “**эргэцүүлэн дүгнэж дасан зохицох**” (reflect-adapt) гэж нэрлэдэг. Энэ арга хэмжээ нь өөр өөр цаг хугацаанд (улирал тутам, хагас жил тутам, жил бүр), өөр өөр хэлбэрээр (албан ёсны семинар, зорилтот хэлэлцүүлэг), өөр өөр түвшинд (төсөл, хөтөлбөр, багц түвшинд) зохион байгуулагдаж болно. Мөн хөндлөнгийн үнэлгээ, **аудитын** дүнд үндэслэн эдгээр арга хэмжээг зохион байгуулах боломжтой. Түүнчлэн, өөрчлөлтийн онолд тусгагдсан сэтгэлзүй, нийгмийн болон зан төлвийн хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийхдээ нийгмийн шинжлэх ухааны арга хэрэгсэл, хандлагуудыг ашиглах нь үр дүнтэй.



Дүн шинжилгээ хийхдээ дараах чиглүүлэх асуултуудыг харгалзан үзнэ үү:

- Нөхцөл байдал өөрчлөгдсөн үү? Хэрэв тийм бол энэ нь танай багийн ажилд хэрхэн нөлөөлж байна вэ?
- Танай баг төлөвлөсөн ажлуудаа хийж байна уу? Үгүй бол яагаад?
- Хүлээгдэж буй үр дүндээ хүрч байна уу? Яагаад тийм эсвэл яагаад үгүй вэ?
- Хүний зан үйл, итгэл үнэмшил, хандлага, зорилгод өөрчлөлт ажиглагдсан уу? Эдгээр нь танай ажлын үр дүн үү, эсвэл нөхцөл байдлын өөрчлөлтөөс шалтгаалсан уу?
- Танай ажлын нөлөөгөөр урьдчилан тооцоолоогүй сөрөг үр дагавар гарсан уу?
- Нэмэлт мэдээллийн хэрэгцээ, тодорхой бус байдал, эсвэл эрсдэл байсаар байна уу?
- Энэхүү дүн шинжилгээнд үндэслэн ямар шийдвэр гаргах шаардлагатай вэ?

Дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах, баримтжуулах олон арга зам бий. [23-р зураг](#) үйл ажиллагааны хэрэгжилт болон үр дүнгийн явцыг хянах хүснэгтийн загвар жишээг үзүүлсэн бөгөөд энэ нь цаашид өөрчлөх шаардлагатай арга хэмжээ болон гаргасан шийдвэрийг хялбараар бүртгэн баримтжуулахад тусалдаг. [24-р зураг](#) дахь жишээ дээр үр дүнгийн хэлхээ, түүний хүрээнд хийсэн ажлын явц болон үр дүнг хэрхэн хянаж, бүртгэж буйг хамтад нь харуулсан. Хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг мөн хүснэгтээс харах боломжтой.

**ЗУРАГ 23** Үйл ажиллагааны хэрэгжилт болон үр дүнгийн хяналт, мониторингийн жишээ


Хэрэгжилтийн явц					
Арга хэмжээ	Арга хэмжээний төлөв	Үйл ажиллагааны төрөл	Үйл ажиллагааны төлөв	Яагаад энэ үнэлгээг өгсөн бэ? Үйл ажиллагаа болон үр дүнг харгалзан үнэлгээгээ тайлбарлана уу.	Энэ үйл ажиллагааг илүү сайн хэрэгжүүлэхэд ямар өөрчлөлт хийх хэрэгтэй вэ?
Акулын сэрвээгээр шөл хийхийг зогсоох кампанит ажил	Хэвийн явж байна			Төлөвлөсөн ёсоор хийгдэж байна	Үндэсний цэцэрлэгт хүрээлэнг хамгаалах бодлогын хэрэгжилт хойшилсноос үүдэх нөлөө, энэ ажилд хэрхэн нөлөөлөх талаар хороо хэлэлцэнэ
Үр дүн	Үйл ажиллагаа	Үйл ажиллагааны төрөл	Үйл ажиллагааны төлөв	Яагаад энэ үнэлгээг өгсөн бэ? Тулгарсан бэрхшээл, амжилт, авсан сургамж зэргийг оруулна уу.	Энэ үйл ажиллагааг илүү сайн хэрэгжүүлэхэд ямар өөрчлөлт (шаардлагатай бол) хийх хэрэгтэй вэ?
Нийслэл хотын томоохон ресторонуудад мэдээлэл хүрсэн	Сурталчилгааны кампанит ажлыг зохион байгуулах	Хөтөлбөр	Хэвийн явж байна	Хүргэх мессежийг тодорхойлж, сурталчилгааны материалыг түгээж эхэлсэн	Өөрчлөлт шаардлагагүй – зорилтот бүлгүүдэд чиглэсэн үйл ажиллагааг үргэлжлүүлэх
Ресторанууд шөл санал болгохоо больсон	Кампанит ажлын бүртгэл, баримтыг хянах	Мониторинг	Төлөвлөгдсөн	2026 онд мониторинг хийхээр төлөвлөсөн	Нөөц боломж байвал мониторингийн сургалтыг аль болох эрт зохион байгуулах

Үр дүнгийн мониторинг						
Арга хэмжээ	Үр дүн	Зорилт хэрэв боломжтой бол	Шалгуур үзүүлэлт хэрэв боломжтой бол	Хэлэлцүүлэгт болон үнэлгээ өгөхдөө шалгуур үзүүлэлтийн өгөгдөл болон бусад нотолгоо (мөн зорилтот ярилцлага)-г ашиглана.		
Арга хэмжээ	Үр дүн	Зорилт хэрэв боломжтой бол	Шалгуур үзүүлэлт хэрэв боломжтой бол	Яагаад энэ үнэлгээг өгсөн бэ? Тулгарсан бэрхшээл, амжилт, авсан сургамжийг оруулна уу.	Энэ үр дүнд хүрэх явцыг сайжруулахад ямар өөрчлөлт хийх хэрэгтэй вэ?	
Акулын сэрвээтэй шөл хийхийг зогсоох кампанит ажил	Нийслэл хотын томоохон ресторонуудад мэдээлэл хүрсэн	2025 он гэхэд нийслэл хотын далайн бүтээгдэхүүн борлуулдаг ресторонуудын 50-иас дээш хувь нь “Акулын сэрвээтэй шөл зогсооё” кампанит ажилд идэвхтэй оролцдог болсон байна.	Кампанит ажилд хамрагдсан ресторонуудын хувь	Хэрэгжсэн	Нийслэл хотын далайн бүтээгдэхүүн борлуулдаг ресторонуудын 77% нь кампанит ажилд оролцож байна.	Кампанит ажлын хамрах хүрээг нэмэгдүүлэхийн тулд нийслэлийн захын дүүргүүдэд үйл ажиллагааг өргөжүүлэх
	Ресторанууд шөл санал болгохоо больсон	Хамааралгүй	Хамааралгүй	Хэвийн явж байна	Олон ресторонуудад очиж акулын сэрвээтэй шөл санал болгохоо больсныг баталгаажуулсан. Гэвч хотын хэмжээнд тогтмол хяналт хийхэд хүндрэлтэй байна.	Орон нутгийн ажиглагчдыг сургах, дэмжлэг үзүүлэх



PHOTO: RACHEL NEUGARTEN

**ЗУРАГ 24** Хэрэгжилт, үр дүнгийн явцыг харуулсан үр дүнгийн хэлхээнд суурилсан өөрчлөлтийн онолын жишээ



ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ		
Арга хэмжээ	Үйл ажиллагаа	Мониторинг
Хэрэгжсэн	Хэрэгжиж байна	Төлөвлөгдсөн
Бага асуудал	Томоохон асуудал	Хоцрогдсон
		Тодорхойгүй

ҮР ДҮНГИЙН МОНИТОРИНГ		
Дунд хугацааны үр дүн	Аюул дарамтыг бууруулсан үр дүн	Хамгаалах үнэт зүйл
Биелсэн	Хэрэгжиж байна	Харахан биелээгүй
Хэсэгчлэн биелсэн	Биелээгүй	Хамааралгүй
		Тодорхойгүй

Хөтөлбөрийн (агуулгын) дүн шинжилгээнээс гадна менежментийн дотоод үйл ажиллагаа хэвийн үр дүнтэй явагдаж байгаа эсэхийг анхаарч үзэх нь чухал. Зарим тохиолдолд хамгаалах үнэт зүйлд нөлөөлж буй ачуул, дарамт, боломжийг шийдвэрлэхэд чиглэсэн оновчтой арга хэмжээг төлөвлөсөн байж болох ч, багийн дотоод үйл ажиллагаа үр ашиггүй байх, эсвэл ажлаа чанартай гүйцэтгэхэд шаардлагатай захиргааны болон санхүүгийн дэмжлэг учир дутагдалтай байж болзошгүй юм. Бодит нөхцөл байдал хэрхэн өрнөж байгааг илүү сайн ойлгоход энэ төрлийн дүн шинжилгээнд багийн бүх гишүүдийн идэвхтэй хамтын оролцоо чухал ач холбогдолтой. Менежментийн дүн шинжилгээний хүрээнд дараах асуудлуудыг авч үзэх нь зүйтэй. Үүнд:

- Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хангалттай нөөц (санхүүгийн, хүний нөөц, захиргааны, улс төрийн гэх мэт) бүрдсэн эсэх;
- Багийн гишүүдийн ур чадвар хангалттай эсэх;
- Шаардлагатай дэд бүтэц, тоног төхөөрөмж (ажлын байр, тээврийн хэрэгсэл, компьютер гэх мэт) хангалттай эсэх;
- Нийгмийн хамгааллын механизм, арга хэмжээнүүд хэрэгжиж байгаа эсэх;
- Багийн гишүүд хоорондын ажлын уялдаа хэвийн бөгөөд үүрэг хариуцлага шударгаар хуваарилагдсан, хэвийн үйл ажиллаж байгаа эсэх.

Амжилт, сургамжаасаа суралцах, талуудтай үр дүнтэй харилцааг бий болгохын тулд дүн шинжилгээ хийхдээ холбогдох хүмүүсийг оролцуулах, эсвэл урьдчилсан байдлаар дүн шинжилгээний үр дүнг тэдэнтэй хуваалцах нь чухал. Мөн багийн гишүүдийг заавал оролцуулах шаардлагатай. Учир нь тэд үйл ажиллагааны явц, ерөнхий нөхцөл байдлын талаар хамгийн сайн ойлголт, мэдээлэлтэй байдаг. Нөхцөл байдал, хэрэгцээнээс хамааран багийн гишүүд дүн

шинжилгээг өөрсдөө гүйцэтгэх, эсвэл хийсэн дүн шинжилгээг хянан үзэж, тайлбарлахад оролцож болно. Гэхдээ, багийн оролцоо нь шинжилгээний үр дүнд үндэслэлгүйгээр нөлөөлөхөөс зайлсхийх хэрэгтэй. Багийн гишүүдийн оролцоо чухал боловч оролцогч талууд, хөндлөнгийн шинжээчид болон өөр үзэл бодолтой хүмүүсийн санал, оролцоо нь мониторингийн үр дүнг илүү тэнцвэртэй, бодитой тайлбарлахад үнэтэй хувь нэмэр оруулдаг.

### ЭНЭ АЛХМЫН ХҮРЭЭНД ГАРАХ ҮР ДҮН:

- Төслийн үр дүн, таамаглалд хийсэн шинжилгээ
- Үйл ажиллагаа, санхүүгийн өгөгдлийн шинжилгээ
- Хэлэлцүүлэг, шийдвэр, тэдгээрийн тэмдэглэл



PHOTO: GERNANT MAGNIN

АГУУЛГА

ТАНИЛЦУУЛГА

1  
ТОДОРХОЙЛОХ

2  
ТӨЛӨВЛӨХ

3  
ХЭРЭГЖҮҮЛЭХ

4  
ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ  
& ҮЙЛДҮҮЛЭХ

5  
ХУВААЛЦАХ

ТӨЛӨВЛӨЛТИЙН  
МӨЧЛӨГИЙГ  
ЗАНГИДАХ НЬ

ХАВСРАЛТ

## 4С. Төлөвлөгөө, төсвийг тодотгох

Өгөгдөл, мэдээлэл тогтмол цуглуулан дүн шинжилгээ хийх нь хэрэгжүүлж буй арга хэмжээ хэр үр дүнтэй байгааг тогтоох, зорилго, зорилтодоо хүрэхийн тулд ямар өөрчлөлт, шинэчлэл хийх шаардлагатайг тодорхойлох үндэс болдог. Энэ алхмын төгсгөлд дүн шинжилгээ болон хэлэлцүүлгийн явцад олж авсан мэдлэг, сургамжидаа тулгуурлан (шаардлагатай тохиолдолд) стратегийг шинэчилэн сайжруулах, түүнчлэн нөөц (хүний болон санхүүгийн)-ийн хуваарилалтыг уялдуулан хийх хэрэгтэй. Энэ нь байгаль хамгааллын сайн туршлага, дасан зохицох менежментийн мөн чанар юм.

Өмнөх төлөвлөгөө нь нэг удаа хийгдээд дахин хэзээ ч ашиглагдахгүй зүйл биш юм. Харин цаг хугацааны явцад ажлаа сайжруулж, тасралтгүй суралцахын тулд стратегийн төлөвлөгөөгөө (мөн нөхцөл байдлын дүн шинжилгээ, өөрчлөлтийн онол), мониторингийн төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө болон төсвөө тогтмол эргэн хянаж, шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулах нь зүйтэй. Өөрчлөлт хийх санаа нь багийн дотоод хэлэлцүүлэг, үнэлгээ, аудитын үр дүн, үйл ажиллагааг сайн мэдэх гол оролцогч талуудын санал, мөн холбогдох судалгааны үр дүнгээс үүдэн гарч болно. Зарим тохиолдолд төлөвлөгөөг 5–10 жил тутамд “албан ёсоор” шинэчилдэг. Гэсэн хэдий ч байгаль хамгааллын сайн туршлагын үүднээс авч үзвэл 6–12 сар тутамд зохих завсарын өөрчлөлт хийж, улмаар тохиромжтой үед нь тэдгээрийг албан ёсоор тусган шинэчлэх нь зүйтэй.

Өөрчлөлт хийх бүртээ тухайн шийдвэрийг гаргах болсон үндэслэл болон/эсвэл түүний нотолгоог баримтжуулах нь зүйтэй. Ингэснээр бусад хүмүүс танай баг юу сурсан, яагаад ийм өөрчлөлт хийснийг ойлгоно. Баримт бүрдүүлэх нь [5-р алхамд](#) чухал мэдээлэл болдог. Баримтжуулах олон арга байдаг ба үүнд өөрчлөлтийг дэлгэрэнгүй тайлбарласан бичвэр, бүртгэлийн маягт, диаграм зэрэг орно. Ямар ч арга сонгосон бай тухайн арга нь төлөвлөгөөгөө үр ашигтайгаар сайжруулахад дэмжлэг үзүүлэхүйц уян хатан байх ёстойг анхаараарай.

Гэхдээ аливаа өөрчлөлт, сайжруулалтыг хийх нь өгөгдөл, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, түүндээ үндэслэн шийдвэр гаргаж, бүртгэж тэмдэглэх төдий энгийн зүйл биш юм. Тухайн нөхцөлд ийм өөрчлөлтийг хийхэд юу нөлөөлж, ямар шинэ боломж олгож байгааг, энэ өөрчлөлтийг бодит

амьдрал дээр хэрэгжүүлэх боломж хэр зэрэг байгааг сайтар ойлгох нь чухал. Өөрчлөлтийг ямар түвшинд хийх шаардлагатай вэ, хэн хариуцах вэ, шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийг хүлээн зөвшөөрүүлэхийн тулд гол зорилтот бүлгүүдэд ямар мэдээлэл өгөх, ямар нотолгоо шаардлагатай болох вэ гэдгийг анхаарч үзэх хэрэгтэй. Эцэст нь, зарим арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж байгаа бөгөөд нэмэлт өөрчлөлт хийх шаардлагагүй гэдгийг ч мөн олж мэдэх боломжтойг санаарай. Хамгийн чухал нь дүн шинжилгээ хийхэд хангалттай цаг гаргаснаар яг аль хэсэгт өөрчлөлт, сайжруулалт хийх шаардлагатай байгааг тодорхойлох боломж бүрдэнэ.



PHOTO: CAROLINE STEM

### ЭНЭ АЛХМЫН ХҮРЭЭНД ГАРАХ ҮР ДҮН

- Шинэчлэн боловсруулсан баримт бичгүүд, тухайлбал стратегийн төлөвлөгөө (нөхцөл байдлын дүн шинжилгээ, өөрчлөлтийн онол), мониторингийн төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө, төсөв;
- Нотолгоо, хэлэлцүүлэг, олж авсан сургамж, болзошгүй эрсдэл эсвэл тодорхойгүй байдал, гаргасан



PHOTO: JASON HOUSTON FOR USAID

АШИГЛАХ МАТЕРИАЛ

Байгаль хамгааллын стандартын цахим сан (“Analyze & Adapt” шүүлтүүрийг сонгож, дараа нь шаардлагатай бол guidance, case studies зэрэг нэр томъёогоор хайлт хийнэ)

Байгаль хамгааллын практик аргачлал: Байгаль хамгааллын стандарт (Аргачлалтай холбоотой зөвлөмжтэй танилцахын зэрэгцээ “Examples & Resources” “Analyze & Adapt” хэсгүүдийг харж болно)

Байгаль хамгааллын стандартыг практикт хэрэгжүүлсэн туршлага



# ХУВААЛЦАХ



# ХУВААЛЦАХ

Байгаль хамгааллын стандартын энэ алхамд гол зорилтот бүлгүүдэд үйл ажиллагааны явцад олж авсан сургамж, үр дүнг хуваалцахын зэрэгцээ харилцан санал солилцох байдлаар суралцах соёлыг дэмжих ажлууд багтана. Багийн гишүүд төдийгүй, түнш байгууллага, бусад оролцогч талуудтай хамтран суралцахуйг дэмжих нь нэн чухал юм. Дүн шинжилгээ хийх явцад олж авсан ойлголт, мэдлэг нь дараагийн мөчлөгийн бүх алхамд ач холбогдолтой байж, оролцогч бүх талд суралцах боломжийг бүрдүүлнэ. Мөн байгууллагын түвшинд, цаашлаад байгаль хамгааллын салбарын хэмжээнд суралцах үйл явцыг дэмжих нь чухал юм. Үүнийг харгалзан Байгаль хамгааллын стандарт нь баг болон байгууллагууд суралцах, туршлагаа хуваалцах соёлыг төлөвшүүлэхэд дэмжлэг болохуйц туршлагауудыг багтаасан байдаг.

## 5А. Баримтжуулах

Байгаль хамгааллын стандартад тодорхойлсон арга хэмжээг хэрэгжүүлэх явцдаа олж авсан мэдлэг, туршлагаа тэмдэглэн баримтжуулж, мэдээллийн сан үүсгэн тогтмол баяжуулж байх нь зүйтэй. Мөчлөгийн туршид тодорхойлсон мэдээлэл, нотолгооны хэрэгцээнд тулгуурлан [4-р алхамд](#) та аль хэдийн олон үр дүн, үнэ цэнтэй мэдлэг, мэдээллийг хуримтлуулсан байдаг. Иймээс энэ шатанд тэдгээр мэдлэг, сургамж, мөн хараахан хариултаа олоогүй асуулт, мэдээллийн хэрэгцээг тодорхойлон тохирох хэлбэрээр баримтжуулж, цаашид танай баг, байгууллага төдийгүй нийт байгаль хамгааллын салбарынхан бүхэлдээ ашиглах боломжтой байхаар хадгалах нь чухал.

Үр дүн, олж авсан мэдлэг, сургамжаа баримтжуулах олон арга бий. Үүнд дотоод хэрэгцээнд зориулсан албан бус тэмдэглэл, санхүүжүүлэгч, бусад оролцогч талуудад зориулсан тайлан, гар бичмэл зэрэг багтана. Гэвч ихэвчлэн өдөр тутмын ажлын ачаалал, цаг хугацаа шахуу нөхцөлд эдгээр баримтжуулалтыг хийх нь хүндрэлтэй байдаг. Иймд урт хугацаанд тогтвортой ашиглаж болох, хамгийн хялбар аргачлалыг сонгохын зэрэгцээ байгууллагын зүгээс энэ ажлыг хийхэд шаардлагатай цаг хугацаа зарцуулах, урамшуулал олгоход дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Тухайлбал, цахим бүртгэл, хүснэгт ашиглан олж авсан мэдлэг, сургамжийн нэгдсэн жагсаалтыг хөтөлж, багийн бүх гишүүд түүнийг чөлөөтэй үзэх, засварлах

боломжтой газар байршуулах нь энгийн бөгөөд үр дүнтэй хувилбар байж болно ([Зургаг 23](#)).

Үр дүнгийн нотолгоо болон сургамжаа тогтмол баримтжуулсанаар жилээс жилд ямар ажлууд хийсэн, аль нь үр дүнтэй, аль нь үр дүнгүй байсныг, мөн цаашид юу хийхээр төлөвлөж байгаагаа илүү тодорхой санаж байх боломж бүрдэнэ (Өгөгдлийн менежментийн талаар [4А алхмаас](#) харна уу). Энэ нь одоо ажиллаж буй багт урт хугацаанд ашиг тустай байхаас гадна шинээр ажилд орсон ажилтанд өмнө нь хийсэн ажил, олж авсан сургамжийн талаар тодорхой баримт, мэдээлэл өгөх ач холбогдолтой. Хамгийн чухал нь өмнөх алдааг дахин давтахгүй байх нөхцлийг бүрдүүлнэ. Хэрэв Miradi зэрэг менежментийн программ ашигладаг бол тайлбар, тэмдэглэл оруулсанаар тухайн мэдлэгийг түүхэн бүртгэлийн нэг хэсэг болгон хадгалах боломжтой.

### ЭНЭ АЛХМЫН ХҮРЭЭНД ГАРАХ ҮР ДҮН

- Гол үр дүн, олж авсан мэдлэгийн баримтжуулалт

## 5В. Мэдлэгээ хуваалцах

Байгаль хамгааллын стандарт нь тасралтгүй сайжирч хөгжиж байдаг тул энэ “Хуваалцах” алхмыг мөчлөгийн туршид анхаарч үзэх шаардлагатай. Хуримтлуулсан мэдлэг, сургамжаа баримтжуулж, бусадтай хуваалцах нь ижил төстэй нөхцөлд ажиллаж буй, эсвэл ижил арга барил ашиглаж байгаа бусад мэргэжилтнүүдэд таны туршлагаас суралцах, тулгарсан бэрхшээлээ даван туулах, алдааг давтахгүй байх, улмаар байгаль хамгааллын зорилгодоо илүү үр дүнтэй хүрэхэд нь бодит дэмжлэг болдог.

Олж авсан мэдлэг, сургамжаа хуваалцахаасаа өмнө тэдгээрийг ямар зорилтот бүлэгт хүргэх, танилцуулах шаардлагатайг тодорхойлох нь зүйтэй. Өөрийн баг, оролцогч талууд, хандивлагч эсвэл санхүүжүүлэгчид, мөн байгаль хамгааллын мэргэжилтнүүдтэй юуг хуваалцах шаардлагатайг бодолцох нь зүйтэй. Мэдээллийг үр дүнтэй хүргэхийн тулд зорилтот бүлгүүдэд тохирсон мэдээлэл, сурталчилгааны стратеги шаардлагатай. Ийм стратегийг 2–4-р алхмуудад хийсэн ажлын үр дүнд тулгуурлан боловсруулсан байх учиртай. Энд зорилтот бүлэг бүрийн сонирхол, хэрэгцээнд тулгуурлан ямар мэдлэг, сургамжийг хуваалцах, тэдэнд хүрэх хамгийн тохиромжтой хэлбэр, арга зам (Жишээлбэл тайлан, товч мэдээлэл, уулзалт гэх мэт)-ыг сонгох, сурталчилгааны материалыг боловсруулах, түгээх үйл явцыг тодорхой тусгасан байх ёстой. Амжилт, сургамжаа хуваалцахдаа үр дүнгийн шинжилгээнд үндэслэсэн менежментийн тодорхой зөвлөмжийг холбогдох хүмүүст хүргэхийн зэрэгцээ тэдгээрийг ойлгож, хэрэгжүүлэхэд хэрэг болохуйц дэлгэрэнгүй мэдээлэл, тайлбарыг мөн өгөх нь чухал юм.

Багийн гишүүд болон хамтрагч талуудтайгаа цахим шуудан, уулзалт, бусад сувгуудыг ашиглан өдөр тутамдаа харилцаж, олж авсан мэдлэг, сургамж, туршлагаа тогтмол хуваалцсанаар хамтдаа суралцаж хөгжих дотоод орчныг бүрдүүлэх боломжтой.

Оролцогч талуудтай юуг, хэрхэн хуваалцах нь тухайн бүлгүүдийн хэрэгцээ, сонирхол, хүсэлтээс хамаарна. Зарим тохиолдолд албан бус яриа өрнүүлэх, туршлага солилцох уулзалт, сургалт зохион байгуулах, цахимаар санал хүсэлт авах, эсвэл хамтрагч талуудын зохион байгуулж буй арга хэмжээнд оролцох зэрэг төрөл бүрийн арга хэлбэр байж болно. Мэдээллийг өргөн хүрээнд түгээхдээ нууцлалын асуудлыг зайлшгүй харгалзан үзэх хэрэгтэй бөгөөд оролцогч талууд мэдээлэл хуваалцахтай холбоотой өөр өөр түвшний хүлээлтэй, өөр өөр байр сууринаас ханддаг

болохыг анхаарах хэрэгтэй. Мэдээлэл хуваалцах эсвэл хуваалцахгүй байх нь орон нутгийн хэрэгцээ, талуудын хамтын ажиллагаа, харилцаанд хэрхэн нөлөөлөхийг урьдчилан тооцоолох нь зүйтэй. Мөн мэдээллийг түгээхдээ бүх зорилтот бүлэгт хүртээмжтэй байх талаас анхаарах шаардлагатай.

Байгаль хамгааллын мэргэжилтнүүдтэй сургамж, мэдээлэл хуваалцах олон хэлбэр бий. Үүнд мэдээллийн санд хувь нэмэр оруулах ([Conservation Actions and Measures Library](#) гэх мэт), шинжлэх ухааны сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх, бодит туршлагад тулгуурласан тайлан, судалгааны материал боловсруулах, вэбсайт, цахим шуудангийн жагсаалтаар сургамж, туршлагаа түгээх, олон нийтийн сүлжээгээр хуваалцах, сургалт зохион байгуулах, зочин илтгэгчээр оролцох, семинар, хурал, зөвлөгөөн дээр туршлагаа танилцуулах зэрэг арга хэлбэрүүд багтана. Мэдээллээ илүү ойлгомжтой, сонирхол татахуйц байдлаар харуулахын тулд StoryMaps, хяналтын самбар (dashboard), орон зайн технологийг ашиглах боломжийг авч үзээрэй. Ерөнхийдөө мэдлэг, сургамжаа бусадтай солилцох, тэдний туршлагаас суралцахын тулд **мэргэжлийн бүлэг, нийгэмлэгт** нэгдэх, эсвэл холбогдох цахим шуудангийн жагсаалтад бүртгүүлэх нь маш ач холбогдолтой.



### ЭНЭ АЛХМЫН ХҮРЭЭНД ГАРАХ ҮР ДҮН

- Зорилтот бүлгүүд, тэдний мэдээллийн хэрэгцээ, мэдээлэл хүлээн авах тохиромжтой сувгуудыг тодорхойлох, шаардлагатай бол сайжруулах
- Багийн гишүүд, хамтрагч байгууллага, оролцогч талуудтай тогтмол харилцах
- Нотолгоонд суурилсан мэдээллийн санг баяжуулахад хувь нэмэр оруулах
- Зорилтот бүлэгт чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны материал боловсруулах, түгээх

## 5С. Суралцах орчинг бүрдүүлэх

Байгаль хамгааллын сайн туршлага гэдэг нь зөвхөн багийн хүрээнд төдийгүй, байгууллага, хамтрагчид, цаашлаад дэлхийн хэмжээнд ажиллаж буй байгаль хамгааллын мэргэжилтнүүдийн дунд гүйцэтгэлд суурилсан, суралцах соёлыг төлөвшүүлэхийг хэлнэ. Ийм соёл нь бүх оролцогч талууд багийн хуримтлуулсан туршлагаас суралцаж, бодит үр өгөөж хүртэх боломж бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой. Хэдийгээр энэ нь хамгийн сүүлийн алхам боловч, бодит байдал дээр уг соёлыг мөчлөгийн бүхий л алхамын туршид төлөвшүүлэн, тасралтгүй хэрэгжүүлэх шаардлагатай ([Close the Loop](#)-ын үндсэн ойлголт төдийгүй, төлөвлөлтийн бүх алхамыг хамарсан суурь зарчим). Байгаль хамгааллын стандартыг хамгийн үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд ил тод, нотолгоонд суурилсан байгаль хамгаалал болон дасан зохицох менежментийг дэмжсэн орчинд ажиллах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, та, танай баг болон байгууллага үйл ажиллагаагаа тогтмол хэлэлцэн дүгнэж, санал авах, санал өгөх үйл явцыг хэвшил болгох ёстой гэсэн үг. Санал, хүсэлт нь албан ёсны эсвэл албан бус байж болох бөгөөд багийн гишүүд болон бусад ажилтнуудаас ирж болно. Мөн санал хүсэлт нь гаднын механизмаар дамжин ирж болно. Тухайлбал, төлөвлөгөөний үнэлгээ, эсвэл тодорхой шалгуурын дагуу үнэлдэг аудитын дүгнэлт зэрэг байж болно. Суралцах орчныг бүрдүүлэхдээ шинэ, өгөөжтэй өнцгөөс харах боломж олгох бусдын санал, байр сууринд нээлттэй байх нь чухал.

Суралцах орчныг төлөвшүүлэх нь амар ажил биш юм. Үүний тулд хязгаарлагдмал нөөцийг богино хугацааны шууд үйл ажиллагаанаас нотолгоонд суурилсан байгаль хамгаалал, дасан зохицох менежментийн урт хугацааны ажилд шилжүүлэх шаардлагыг ойлгодог удирдлага, хандивлагчид хэрэгтэй. Энэ нь байгаль хамгааллын тодорхой арга барил, үйл ажиллагаатай холбоотой хэвшмэл ойлголт, тогтсон хандлагыг шүүн тунгаах, шинэ туршилт хийх боломжийг мэргэжилтнүүдэд олгохыг шаарддаг. Өөрөөр хэлбэл, шинэ санаачилга дэвшүүлэх, таамаглалд шүүмжлэлтэй хандах нь байгууллагын хэмжээнд үнэлэгддэг гэдгийг баталгаажуулсан орчныг бүрдүүлэхийг хэлнэ. Түүнчлэн амжилт, сургамж хоёуланг нь дэлхийн өнцөг булан бүрт байгаа мэргэжилтнүүдтэй нээлттэй хуваалцаж, мэргэжлийн хамтын нийгэмлэгийг хөгжүүлэхэд тууштай байх шаардлагатай. Үүний хүрээнд Байгаль хамгааллын стандартаар ажиллаж, мэргэшиж буй мэргэжилтнүүд энэхүү стандартыг өөрсдийн байгууллагын түвшинд хэрхэн хэрэгжүүлж буй туршлага, тулгарч буй сорилт, ололт амжилтаа хоорондоо хуваалцах нь тэдэнд бодит үр өгөөж авчирдаг. Ингэснээр Байгаль хамгааллын стандартыг өөрсдийг нь байгууллагын түвшинд илүү үр дүнтэй нутагшуулах, тасралтгүй сайжруулах, мөн нөхцөл байдалд нийцүүлэн хөгжүүлэх арга замыг илүү сайн ойлгож, хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.



PHOTO: FELIX CYBULLA

### ЭНЭ АЛХМЫН ХҮРЭЭНД ГАРАХ ҮР ДҮН:

- Албан болон албан бус хэлбэрээр тогтмол санал солилцох
- Байгаль хамгааллын сайн туршлагыг хэрэгжүүлж буй эсэхийг үнэлэх зорилгоор шаардлагатай тохиолдолд аудит хийх
- Суралцах, шинэ санаа, инновацийг дэмжсэн аюулгүй орчныг бүрдүүлэхэд удирдлага, ажилтнуудын зүгээс тууштай хандлага, идэвхтэй оролцоог бодитоор харуулах
- Дэлхий даяарх мэргэжилтнүүдтэй ололт, амжилт төдийгүй алдаа, сургамжаа хуваалцах



PHOTO: KATHLEEN FLOWER

**АШИГЛАХ  
МАТЕРИАЛ**

Байгаль хамгааллын стандартын цахим сан (“Share” шүүлтүүрийг сонгож, дараа нь шаардлагатай бол guidance, case studies зэрэг нэр томъёогоор хайлт хийнэ)

Байгаль хамгааллын практик аргачлал: Байгаль хамгааллын стандарт (Аргачлалтай холбоотой зөвлөмжтэй танилцахын зэрэгцээ “Examples & Resources” “Share” хэсгүүдийг харж болно)

Байгаль хамгааллын стандартыг практикт хэрэгжүүлсэн туршлага

# ТӨЛӨВЛӨЛТИЙН МӨЧЛӨГИЙГ ЗАНГИДАХ НЬ

Байгаль хамгааллын стандартыг багууд өөрсдийн нөхцөл байдалд хамгийн ихээр тохирох аль ч алхмаас эхлэн хэрэгжүүлэх боломжтой байдлаар энд танилцуулж байна. Шинээр эхэлж буй багийн хувьд стратегийн төлөвлөгөөг тоймлон боловсруулахын тулд 1 (Тодорхойлох) болон 2-р алхам (Төлөвлөх)-ыг харьцангуй богино хугацаанд, жишээлбэл 4–5 өдрийн семинарын хүрээнд хийж болох юм. Үүний дараа 3-р алхам (Хэрэгжүүлэх)-ын хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлүүлэхийн зэрэгцээ, дараагийн хэдэн сард нарийвчилсан мэдээллийг нөхөж, сайжруулж болно. Улмаар 6–12 сарын дараа 4-р алхам (Үр дүнг үнэлэх, уялдуулах)-ын хүрээнд анхан шатны дүн шинжилгээ хийж, үр дүнд тулгуурлан 5-р алхам (Хуваалцах)-д мэдээлэл сурталчилгааны материал боловсруулах боломж бүрдэнэ. Зарим тохиолдолд олон баг энэ мөчлөгт илүү хожуу шатнаас, тухайлбал хийсэн ажлууд нь үнэхээр үр дүнтэй байгаа эсэхийг ойлгох зорилгоор 4-р алхмаас эхлэх нь бий. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр тэд өмнөх алхмууд руу буцаж, гаргасан шийдвэр, дэвшүүлсэн таамаглалуудыг дахин нягталж, илүү тодорхой болгож сайжруулж болно.

Стандартын алхамуудын онцлогоос хамааран мөчлөгийг бүхэлд нь, эсвэл тодорхой нэг алхмыг дахин давтан хэрэгжүүлж болно. Мөчлөгийн зарим эсвэл бүх алхамд ажиллаж байх явцад өмнө нь хараахан тодорхой болоогүй байсан зүйлс тодорч ирдэг. Ийнхүү шинээр гарч ирсэн мэдлэг, ойлголт нь холбогдох хэсгүүдэд нэгтгэгдэж, байгаль хамгааллын ерөнхий төлөвлөгөө болон газар дээрх үйл ажиллагааг илүү бодитой, үр дүнтэй болгоход чухал нөлөө үзүүлдэг. Тухайлбал, алсын хараа, хамгаалах үнэт зүйлсээ дахин эргэн харж илүү тодорхой болгох, нөхцөл байдлын дүн шинжилгээнд тусгах шаардлагатай шинэ хүчин зүйлс, тэдгээрийн уялдаа холбоог тодорхойлох, зорилтот бүлэг эсвэл мэдээллийн хэрэгцээг шинэчлэх, мөн стратеги, мониторинг болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд шаардлагатай өөрчлөлт оруулах боломжтой. Энэ мөчлөгийн гол зорилго нь багийг төгсгөлгүй ажлын тойрогт оруулах явдал биш юм. Харин нотолгоонд суурилсан байгаль хамгаалал, дасан зохицох менежмент нь цаг хугацааны явцад тасралтгүй суралцаж, сайжруулж байх шаардлагатай, амьд үйл явц гэдгийг сануулахад чиглэдэг.

“Мөчлөгийг зангидах” гэдэг нь мөчлөгийн алхмуудыг давтан хэрэгжүүлэх замаар өөрийн үйл ажиллагаа, тэдгээрийн үр нөлөөг тогтмол сайжруулахын зэрэгцээ багийн сэтгэлгээ, бүтээгдэхүүн, үйл явцыг цаг хугацааны туршид улам

боловсронгуй болгон хөгжүүлэхийг хэлнэ. Энэ нь зөвхөн танай багийн хэрэгцээг хангаад зогсохгүй, байгаль хамгааллын салбарын мэдлэг, туршлагыг баяжуулахад чухал хувь нэмэр оруулдаг. Энэ нь энгийн менежментийг нотолгоонд суурилсан байгаль хамгаалал, дасан зохицох менежмент болгон хөгжүүлэх гол суурь ойлголт юм.



## АШИГЛАХ МАТЕРИАЛ

[Байгаль хамгааллын  
стандартыг практикт  
хэрэгжүүлсэн туршлага](#)



PHOTO: JUSTIN GRUBB


# ХАВСРАЛТ



# ХАВСРАЛТ 1. НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Төлөвлөгчдийн дунд зорилго, зорилт, зорилтот түвшин, үе шат, нөлөөлөл, үр нөлөө, үр дүн, үр дагавар зэрэг мэргэжлийн үг хэллэг, нэр томъёоны хэрэглээний талаар хэзээ ч дуусашгүй маргаан өрнөдөг. Байгууллага, агентлаг, төсөл, бүр цаашлаад хувь хүн бүр өөр өөрийн зөв гэж үздэг нэр томъёотой байх нь бий. Энэ нь зөв, тэр нь буруу гэсэн нэгдсэн нэг хариулт байхгүй боловч хамгийн чухал нь тухайн багийн гишүүд болон хамтран ажиллаж буй талууд тэдгээр нэр томъёог тодорхой, нэгэн ижил утгаар ойлгож байх явдал юм. Стандарт нэр томъёоны тайлбар тольтой байх нь олон давуу талтай. Иймд энэхүү гарын авлагад хэрэглэсэн мэргэжлийн нэр томъёог хянамгай сонгож, анх хэрэглэхдээ тодруулан (тод үсгээр) тэмдэглэн, цаашид энэ хэлбэрээр нь хэрэглэхийн зэрэгцээ нэр томъёоны тайлбар тольд орууллаа.

## Нэр томъёоны тайлбар толь ашиглах заавар



## Хувилбар 5.0 дахь гол өөрчлөлтүүд

CS 5.0-д нэр томъёоны хэрэглээнд хэд хэдэн онцлох өөрчлөлт орсон. Үүнд дараах өөрчлөлтүүд багтана:

- **Target болон value нэр томъёоны хэрэглээг өөрчлөх** – [WCPA 2024](#)-д дурдсанаар дээрх хоёр нэр томъёоны хэрэглээ олон жилийн турш хэлзүйн төөрөгдөл дагуулж ирсэн тул тодорхой ялгаж хэрэглэх шаардлагатай гэж үзсэн. Үүнд:
  - » **Ойлголт А:** Төслийн баг эцсийн дүндээ нөлөөлөхийг зорьж буй тогтолцооны хүчин зүйл
  - » **Ойлголт В:** SMART зорилго эсвэл зорилтын хүрээнд хүрэхээр толорхойлсон шалгуур үзүүлэлтийн тоон эсвэл чанарын хэмжүүр

СМР-ийн хувилбар 4.0 болон өмнөх хувилбаруудад *target* нэр томъёог Ойлголт А-г илэрхийлэхэд, харин *desired future values* нэр томъёог Ойлголт В-г илэрхийлэхэд ашиглаж ирсэн. Харин CBD, WCPA зэрэг олон улсын бодлого, мэргэжлийн форумуудын практикт *target*-ыг Ойлголт В-д, *value*-г Ойлголт А-д хэрэглэдэг. Эдгээр олон улсын түвшинд тогтсон нэр томъёоны хэрэглээг өөрчлөх боломжгүйг харгалзан үзэж, энэхүү 5.0 хувилбарт тэдгээрийн хэрэглээг нийцүүлэн дагаж мөрдөхөөр шийдвэрлэсэн бөгөөд хувилбар 4.0-д *target* гэж нэрлэж байсан ойлголтыг цаашид *focal value* хэмээн нэрлэхээр тогтлоо.

- **“Арга хэмжээ” болон “Стратеги” нэр томъёоны хэрэглээг өөрчлөх** – Хувилбар 4.0-д *strategy*-г нэг чиглэлд төвлөрсөн *үйл ажиллагааны* багц гэж, харин *action*-ыг гүйцэтгэж буй бүх ажлыг (үүнд стратеги, үйл ажиллагаа, даалгаврууд багтана) хамарсан ерөнхий нэр томъёо болгон ашиглаж байсан. Гэвч хөгжлийн, бизнесийн болон цэргийн салбаруудад эдгээр нэр томъёог хэрэглэдэг нийтлэг ойлголт, шаталсан бүтэцтэй нийцэхгүй байв. Иймд бид үйл явцын дараалалд тулгуурлан нэр томъёоны хэрэглээг дараах байдлаар уялдуулан шинэчлэн тогтоосон: *стратеги* → *арга хэмжээ* (*action*) → *үйл ажиллагаа* (*activity*) → *даалгавар* (*task*).
- **Stakeholder нэр томъёог *interested party* -аар солих** – *Stakeholder* гэдэг нэр томъёо нь колоничлолын өнгө аяс бүхий утга, агуулгатай тул бид илүү төвийг сахисан *interested party* гэсэн нэр томъёог хэрэглэхээр болсон.

Дээрх өөрчлөлтүүд нь гарын авлага, материалуудыг шинэчлэх шаардлага үүсгэх, мөн хэрэглэгчдийн дунд тодорхой хугацаанд төөрөгдөл үүсгэх зэрэг сорилтыг дагуулж болох ч, нэр томъёоны хэрэглээг дэлхийн түвшинд нийтлэг ойлголт, практиктой нийцүүлэх зорилгоор тэдгээрийг ашиглахыг зөвлөж байна. Мөн хувилбар 4.0 болон 5.0-д эдгээр нэр томъёог өөр өөр утгаар хэрэглэсэн нь тодорхой хугацаанд зэрэгцэн ашиглагдах, өөрөөр хэлбэл шилжилтийн үе үргэлжлэхийг бид бүрэн тооцоолж байна.

## Тодорхойлолтууд

**Арга хэмжээ** – Арга хэмжээ гэдэг нь нийтлэг нэг зорилгод чиглэсэн, нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны цогц бөгөөд эдгээр нь нөлөөллийн гол цэгүүдэд чиглэн, боломжуудыг оновчтой ашиглаж, хязгаарлалтыг багасгах замаар тодорхой зорилго, зорилтод хүргэнэ. Арга хэмжээнүүд нь уялдаа холбоотой, төвлөрсөн, хэрэгжих боломжтой мөн тохиромжтой байх зэрэг шалгууруудыг хангасан байх шаардлагатай “үйл ажиллагаа” болон “стратеги”-тэй харьцуулна уу.

**Тайлбар:** Хувилбар 5.0-д “Арга хэмжээ” нэр томъёо нь өмнө хэрэглэж байсан “стратеги”-г орлох бөгөөд энэ нь нийтлэг хэрэглээнд нийцүүлсэн өөрчлөлт юм. Одоо “Стратеги” нь нэг болон түүнээс дээш “Арга хэмжээ” болон түүнд хамаарах “үйл ажиллагаа, үр дүн, зорилт, мөн үнэт зүйл болон зорилго”-оос бүрдэнэ.

**Үйл ажиллагаа** – Арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор төслийн ажилтнууд болон/эсвэл түнш байгууллагуудын гүйцэтгэж буй харилцан уялдаа бүхий даалгаврын цогц.

**Дасан зохицох менежмент** – Шийдвэр гаргах явц дахь тодорхойгүй байдлыг багасгахын тулд зориудын, системтэй суралцах үйл явцыг мэргэжлийн практикт шингээхийг хэлнэ. Өөрөөр хэлбэл, энэ нь төлөвлөлт, менежмент болон үнэлгээ мониторингийн уялдуулан нэгтгэж, хэрэгжүүлэгчдэд гол таамгуудыг системтэй, үр ашигтайгаар шалгах, гарсан үр дүнг үнэлэх, удирдлагын шийдвэрээ шаардлагатай үед өөрчлөх, улмаар шинэ мэдлэг, сургамж бий болгох боломж олгодог арга барил юм. Байгаль хамгааллын стандарт нь дасан зохицох менежментийн эдгээр зарчмыг байгаль хамгааллын практикт тодорхой, шууд байдлаар нэвтрүүлдэг.

**Таамаглал** - Үнэн гэж үзэж буй зүйлсийг тодорхой, ил тод байдлаар илэрхийлэхэд ашигладаг ерөнхий нэр томъёо юм. Үүнд тухайн системд тодорхой хүчин зүйл оршин байгаа эсэх, эсвэл нөхцөл байдлын үнэлгээ болон өөрчлөлтийн онолд хоёр ба түүнээс олон хүчин зүйлийн хооронд шалтгаан–үр дагаврын холбоо бий гэж үзсэн ойлголтууд багтана.

**Аудит** – Төлөвлөлтийг эсвэл хөтөлбөрийг гадны, урьдчилан тогтоосон шалгуурын дагуу үнэлж дүгнэх үйл явц юм. Эдгээр шалгуурт жишээлбэл нийтээр хүлээн зөвшөөрсөн нягтлан бодох бүртгэлийн зарчим, тогтвортой ашиглалтын зарчмууд, эсвэл энэхүү гарын авлагад тусгасан стандартууд багтаж болно. Үнэлгээтэй харьцуулан ойлгоно.

**Зан үйлийн өөрчлөлт** – Хүмүүсийн хийж буй үйлдэл, дадлыг өөрчлөх үйл явц бөгөөд одоо байгаа зан үйлийг дэмжих, багасгах эсвэл шинээр зан үйл төлөвшүүлэхийг хэлнэ.



**Биофизик хүчин зүйл** – Биотик эсвэл абиотик нөхцөл байдлын илэрхийлэмж бөгөөд шууд аюул дарамт хэрхэн “үнэт зүйл”-д нөлөөлж байгааг тодруулах тогтолцоо. Жишээ нь: тохиромжгүй мод бэлтгэлийн үйл ажиллагаа (аюул, дарамт) нь гол руу тусах сүүдэрлэлтийг (биофизик хүчин зүйл) багасгаж, голын усны хэм нэмэгдснээр (биофизик хүчин зүйл) яргай загасны үржлийн эрчим буурч (биофизик хүчин зүйл/стресс) яргай загасны тоо толгойд нөлөөлөх (Үнэт зүйл). “Дарамт”-тэй харьцуулна, учир нь энэ нь биофизик хүчин зүйлийн нэг төрөл.

**Биологийн олон янз байдал болон экологийн үнэт зүйл** – Тухайн төслийн сонгосон биологийн төрөл зүйл, амьдрах орчин, эсвэл экосистем. Газарт суурилсан төслүүдийн сонгосон биологийн үнэт зүйлс нь тухайн газрын биологийн төрөл зүйлийг цогцоор нь төлөөлөх ёстой. Энэ нь “хамгаалах үнэт зүйл”-ийн нэг төрөл.

**Байгаль хамгааллын төлөвлөгөө** – Төсөл эсвэл хөтөлбөрийн нэгдсэн төлөвлөгөө. Бүрэн хэмжээний байгаль хамгааллын төлөвлөгөө нь стратегийн төлөвлөгөө, мониторингийн төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс бүрдэнэ.

**Туршлага солилцох бүлэг эсвэл мэргэжлийн бүлэг** – Нэгэн ижил асуудал, сорилт, эсвэл тодорхой сэдвийн талаар ижил сонирхолтой, түүнээс суралцаж, мэдлэг чадвараа гүнзгийрүүлдэг хүмүүсийн бүлэг.

**Байгаль хамгааллын практик** – Тодорхой нөхцөл байдалд хүрэхийг зорьж буй үр дүнгийн талаар баг нэгдсэн ойлголтод хүрч, эдгээр үр дүнд хүрэхийн тулд нэг буюу хэд хэдэн стратегиар дамжуулан бодит үйл ажиллагаа хэрэгжүүлэх үйл явцыг хэлнэ. Байгаль хамгааллын стандарт нь хамтын ажиллагаа, нотолгоонд суурилсан байгаль хамгаалал, дасан зохицох менежментийн зарчмуудыг тодорхой, системтэйгээр тусгасан нийтлэг хүрээ болон “сайн туршлагаудын” цогцыг санал бөгөөд өргөн утгаараа бол байгаль хамгааллын практик нь дэлхийн байгаль хамгааллын хамтын салбарынхны хуримтлагдсан мэдлэг, туршлагын цогцыг хамарсан салбар юм.

**Байгаль хамгааллын үнэт зүйл** – Энэ нэр томъёо нь зөвхөн биологийн олон янз байдлын үнэт зүйлийг бус, байгаль хамгааллын ажлуудад хамаарах бусад төрлийн үнэт зүйлсийг мөн хамарна.

**Нөлөөлөгч хүчин зүйл** – Нөхцөл байдлын дүн шинжилгээнд тодорхойлогдох, шууд аюул, дарамт үүсэхэд нөлөөлдөг шууд бус аюул, дарамт, боломж, эсвэл бусад хүчин зүйлсийг хэлнэ. Өөрөөр хэлбэл, нэг буюу хэд хэдэн шууд аюул, дарамтад хүргэж буй суурь шалтгаан юм.

**Аюул, дарамт** – Нэн тэргүүнд шийдвэрлэх нь чухал гэж үнэлэгдсэн шууд аюул, дарамт.

**Шууд аюул, дарамт** – Нэг буюу хэд хэдэн хамгаалах үнэт зүйлийг шууд доройтуулдаг хүний үйл ажиллагаа (жишээ нь, хууль бус мод бэлтгэл, тогтвортой бус загас агнуур). Мөн хүний үйл ажиллагаанаас шалтгаалан өөрчлөгдсөн байгалийн үзэгдэл байж болно (жишээ нь, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас шуурганы давтамж нэмэгдэх). Ихэнхдээ нэг буюу хэд хэдэн оролцогч талтай холбогддог. Шууд бус аюул, дарамт-тай харьцуулна. Зарим оролцогч талуудын хувьд “шууд аюул, дарамт” гэдэг нэршил илүү тохиромжтой байж болзошгүйг *pressure* хэсэгт тайлбарладаг.

**Олон янз байдал** – Байгууллага, төсөл, хөтөлбөр доторх ялгаатай итгэл үнэмшил, туршлага, үзэл бодол, онцлогийн олон төрөл. Дэлгэрэнгүй тайлбарыг дараагийн хэсгээс үзнэ үү.

**Хөтлөгч хүчин зүйл** – Нөхцөл байдлын дүн шинжилгээнд ашиглагддаг зарим хүчин зүйлийн ерөнхий нэршил. Ихэнхдээ шууд хөтлөгч хүчин зүйл нь шууд аюул, дарамттай, харин шууд бус хөтлөгч хүчин зүйл нь нөлөөлөгч хүчин зүйлтэй дүйцнэ.

**Экосистемийн үйлчилгээ** – Бүрэн бүтэн, хэвийн үйл ажиллагаатай экосистем, амьдрах орчин, зүйлүүдээс хүмүүсийн хүртэж буй ашиг тус, үйлчилгээ.

**Дэмжих хүчин зүйл** – Стратегийн үр нөлөөг нэмэгдүүлж, хэрэгжих боломжийг бүрдүүлдэг хүчин зүйл. Ихэвчлэн нөхцөл байдлын загварт нөлөөлөгч хүчин зүйл, эсвэл өөрчлөлтийн онолд дэмжих үр дүн хэлбэрээр дүрслэгддэг. Төлөвлөлтийн багийн шууд хяналтаас гадуур байх нь элбэг (жишээ нь, хууль эрх зүйн бодлого, тогтвортой бүтээгдэхүүний хэрэглэгчийн эрэлт).

**Шударга, тэгш эрхийн мэдрэмжтэй байгаль хамгаалал** – Байгаль хамгааллын ажлыг хэрэгжүүлэхдээ олон янз байдал, тэгш эрх, оролцоо, шударга ёс (DEIJ)-ын зарчмуудыг зориудаар, цогцоор нь тусган хэрэгжүүлдэг хандлага.

**Эрх тэгш байдал** – Хүн бүрт шударга хандлага, тэгш хүртээмж, адил боломжийг хангахын зэрэгцээ түүхэн явцад тодорхой бүлгүүдийг сул байдалд оруулж ирсэн саад бэрхшээлийг илрүүлж, арилгахыг зорихыг хэлнэ. Дэлгэрэнгүй тайлбарыг дараагийн хэсгээс үзнэ үү.

**Үнэлгээ** – Төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилго, зорилтууд болон/эсвэл гадаад гүйцэтгэлийн шалгууртай харьцуулан үнэлэх үйл явц. Өргөн утгаараа, төслийн орчин нөхцөл, стратегийн талаар тодорхой асуултад хариулахын тулд өгөгдөлд дүн шинжилгээ хийхийг хэлнэ (үнэлгээ мониторинг-той харьцуулна). Аудит-тай харьцуулна.

**Нотолгоо** – Асуултад хариулах, таамгуудыг шалгах, шийдвэр гаргахад ашиглагддаг холбогдох өгөгдөл, мэдээлэл, мэдлэг, туршлага.

**Нотолгоонд суурилсан байгаль хамгааллын практик** – Төлөвлөх, хэрэгжүүлэх, суралцах бүх үе шатанд шийдвэр гаргалтыг чиглүүлэхийн тулд нотолгоог ил тод, системтэйгээр бий болгох, ашиглах арга барил.

**Хүчин зүйл** – Нөхцөл байдлын дүн шинжилгээнд ашиглагддаг ерөнхий нэр томъёо бөгөөд үүнд хамгаалах үнэт зүйл, биофизик хүчин зүйлс, шууд аюул, дарамт, нөлөөлөгч хүчин зүйлс багтана.

**Хамгаалах үнэт зүйл** – Төсөл эцсийн дүндээ өөрчлөх, сайжруулахыг зорьж буй зүйл. Ихэнхдээ нийт системийн гол шинжүүдийг төлөөлөхөөр сонгосон элемент байдаг. Хамгаалах үнэт зүйлийн төрлүүдэд биологийн олон янз байдал (жишээ нь, зүйл, амьдрах орчин, экосистем), уур амьсгал, соёл, хүний сайн сайхны төлөөх зорилт орно. Зорилго (goal)-той харьцуулна; зорилго нь үнэт зүйлийн хүсэж буй ирээдүйн төлөвийг тодорхойлдог.

Тайлбар: 5.0 хувилбарт өмнө нь хэрэглэж байсан “target” нэр томъёоны оронд “focal value” гэдэг нэршлийг ашиглаж байна. Ингэснээр тусгай хамгаалалттай газрын хамгаалах элемент-ийг *value* гэж, харин SMART зорилго, зорилтын хүсэж буй ирээдүйн хэмжигдэхүйц түвшин-ийг target гэж ялган хэрэглэдэг олон улсын жишиг, хэлэлцүүлэгтэй нийцүүлж байгаа юм (жишээ нь, 30×30 зорилт).



**Чөлөөт, урьдчилсан, мэдээлэлд суурилсан зөвшөөрөл (FPIC)** – Ямар нэгэн үйл ажиллагаа нь хүн, бүлэг хүмүүст эерэг эсвэл сөрөг нөлөө үзүүлэхээс өмнө тухайн хүн болон хүмүүст бүрэн мэдээлэл авсан үндсэн дээр, дарамт шахалтгүйгээр уг үйл ажиллагааг үргэлжлүүлэхийг зөвшөөрөх ёстой гэсэн зарчим. Дэлгэрэнгүй тайлбарыг дараагийн хэсгээс үзнэ үү.

**Зорилго** – Зорилго нь *хамгаалах үнэт зүйлтэй* (байгаль хамгаалал болон/эсвэл хүний сайн сайхан байдал) шууд уялдсан байх бөгөөд эдгээр үнэт зүйлсийн урт хугацаанд хүрэхийг хүссэн төлөв байдал буюу *эцсийн үр дүнг илэрхийлсэн* тодорхойлолт юм. Зорилго нь тодорхой, хэмжигдэхүйц, хэрэгжих боломжтой, үр дүнд чиглэсэн, хугацаатай байх гэсэн “SMART” шалгуурыг хангах ёстой (Дэлгэрэнгүйг Хавсралт 2. *Алсын хараа* болон *зорилттой* харьцуулна.

**Хүний сайн сайхны төлөөх зорилт** – Сайжруулах, дэмжихийг зорьж буй хүний сайн сайхан байдлын тодорхой чиглэлүүдийг хэлнэ. Байгаль хамгааллын ажлын хүрээнд эдгээр зорилтууд нь ихэвчлэн биологийн олон янз байдлын төлөв байдал болон/эсвэл төслийн стратегиас үүдэлтэй үр дүнтэй уялдсан байдаг. хүний сайн сайхны төлөөх зорилтууд нь *биологийн олон янз байдлын үнэт зүйлс* болон/эсвэл төслийн стратегиас хамаарах хүний сайн сайхан байдлын хэрэгцээний өргөн хүрээг хамтад нь төлөөлөх ёстой.

**Нөлөөлөл (эцсийн үр дүн)** – *Хамгаалах үнэт зүйлийг* хүргэхээр зорьж буй ирээдүйн төлөв. Зорилго нь энэхүү нөлөөллийг албан ёсоор илэрхийлсэн мэдэгдэл юм.

**Оролцоог хангах** – Хүн бүр өөрийгөө тавтай, үнэлэгдсэн, хүндлэгдсэн гэж мэдэрч, өөрийн чадавхаараа бүрэн хувь нэмэр оруулах боломжтой орчинг бүрдүүлэх практик. Дэлгэрэнгүй тайлбарыг дараагийн хэсгээс үзнэ үү.

**Шалгуур үзүүлэлт** – Тодорхой *мэдээллийн хэрэгцээтэй* холбоотой хэмжигдэх нэгж. Жишээ нь: *үнэт зүйлийн* төлөв байдал, *шууд аюул дарамтад* гарсан өөрчлөлт, *зорилго* эсвэл *зорилтын хэрэгжилт* (биелэлт), нэг буюу хэд хэдэн хувьсагчийн хамаарал. Сайн шалгуур үзүүлэлт нь хэмжигдэхүйц, нарийвчлалтай, тогтвортой, мэдрэг байх шаардлагатай.

**Шууд бус аюул дарамт** – Нөхцөл байдлын шинжилгээнд илрүүлсэн, нэг буюу хэд хэдэн шууд аюул дарамтыг бий болгож буй *нөлөөлөгч хүчин зүйл*. Ихэвчлэн хамгааллын үйл ажиллагаа авах гарааны цэг болдог. *Шууд аюул дарамттай* харьцуулна.

**Мэдээллийн хэрэгцээ** – Төлөвлөгөөний талаархи хүмүүсийн мэдэж байх шаардлагатай зүйлс, ихэвчлэн асуултын хэлбэрээр илэрхийлэгддэг.

**Оролцогч тал** – Байгаль хамгааллын үйл ажиллагаанд шууд болон шууд бус байдлаар нөлөөлөх боломжтой, үүнээс ашиг хүртэх эсвэл хохирол амсах магадлалтай хувь хүн, бүлэг, байгууллага. Оролцогч талууд бол *зорилгод* хүрэхийн тулд харгалзан үзэх ёстой бүх талууд бөгөөд тэдний оролцоо, дэмжлэг нь амжилтын үндэс юм. *Эрх эзэмшигчтэй* харьцуулна.

**Тайлбар:** “Stakeholder” гэх нэр томъёо нь колонийн өнгө аястай гэж үздэг тул бид илүү төвийг сахисан “оролцогч тал” гэх нэр томъёог хэрэглэж байна.”

**Дунд шатны үр дүн** – *Зорилгод* хүрэх логик дарааллын явцад, *өөрчлөлтийн онолын* дунд хэсэгт байрлах үр дүн буюу хүчин зүйл. Энд “дунд шатны” гэдэг нь өөрчлөлтийн онолын логик дараалал дахь байршлыг илэрхийлнэ.

**Цогц арга хэмжээ** – Нарийн утгаараа *арга хэмжээтэй* дүйцэх ойлголт. Өргөн утгаараа, нэг зорилгод чиглэсэн олон үйл ажиллагааны цогц буюу *стратегийг* илэрхийлэхэд хэрэглэгддэг нэр томъёо.

**Шударга ёс** – Хүмүүс хоорондын болон байгууллагуудын оролцооны хүрээнд боломж, нөөцийг хэрхэн хуваарилах талаар шударга, ёс зүйтэй шийдвэр гаргах үйл явц. Дэлгэрэнгүй тодорхойлолтыг дараагийн хэсгээс харна уу.

**Экологийн чухал хүчин зүйл** – Зүйлийн, амьдрах орчны эсвэл экосистемийн төлөв, шинжийг илэрхийлэх нэг тал бөгөөд энэ шинж чанар хадгалагдаж байвал тухайн хамгаалах үнэт зүйл эрүүл байгааг илтгэнэ. Харин уг шинж чанар алдагдах эсвэл өөрчлөгдвөл тухайн үнэт зүйл цаг хугацааны явцад бүрэн устах, эсвэл доройтоход хүргэнэ. Үүнтэй адил гол шинж чанаруудыг бусад төрлийн хамгаалах үнэт зүйлсэд мөн тодорхойлох боломжтой.

**Гол асуудлууд** – Нөхцөл байдлын шинжилгээнд тодорхойлогдсон, тухайн нөхцөл байдалд бодитоор, үр дүнтэй нөлөөлөх боломжтой гэж үзэгдэж буй хүчин зүйл.

**Логик хүрээ (үр дүнгийн хүрээ)** – Логик хүрээний шинжилгээний үр дүнд боловсруулагддаг матриц хэлбэрийн хэрэгсэл бөгөөд төслийн арга хэмжээ, зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтүүдийг хүснэгтэн хэлбэрээр харуулж, төслийн логик уялдааг илэрхийлдэг.

**Аргачлал** – Шалгуур үзүүлэлтийг хэмжих зорилгоор өгөгдөл цуглуулахад ашиглагддаг тодорхой арга техник. Сайн аргачлал нь нарийвчлалтай, найдвартай, зардлын хувьд үр ашигтай, хэрэгжих боломжтой, мөн зохистой байх шалгуурыг хангана.

**Завсарын зорилтот түвшин** – Тодорхой хугацаанд хүрэхээр төлөвлөсөн шалгуур үзүүлэлтийн завсрын төлөв байдал буюу зорилтот түвшин. Зорилго эсвэл зорилтод хүрэх явцын ахиц дэвшлийг илэрхийлнэ. Ихэнх тохиолдолд энэ нь зорилго, зорилтод тодорхойлсон түвшнээс бага түвшинд байх бөгөөд харьцангуй богино хугацаанд хүрэхээр төлөвлөгддөг. Зорилтот түвшинтэй харьцуулж үзнэ үү.

**Мониторинг** – Төслийн нөхцөл байдал болон стратегийн талаар тодорхой асуултуудад хариулах зорилгоор өгөгдлийг тогтмол давтамжтайгаар цуглуулж, үнэлэх үйл явц. Зарим тохиолдолд энэхүү өгөгдлийн үнэлгээг мониторинг ба үнэлгээ (M&E), эсвэл мониторинг, үнэлгээ, суралцахуйн (MEL) “үнэлгээ” бүрэлдэхүүн хэсэг гэж нэрлэдэг.

**Мониторингийн үйл ажиллагаа** – Мониторингийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд гүйцэтгэх шаардлагатай тодорхой даалгавруудын цогц. Үйл ажиллагаатай харьцуулж үзнэ үү.

**Мониторингийн төлөвлөгөө** – Төслийн мөчлөгийн туршид мэдээллийн хэрэгцээг хангах зорилгоор шалгуур үзүүлэлтүүд болон тэдгээрийг хэмжих аргачлалуудыг тодорхойлсон байгаль хамгааллын төлөвлөгөөний нэг хэсэг.

**Зорилт** – Төслийн хүрээнд хүрэхийг зорьж буй дунд шатны үр дүнг тодорхойлсон томъёолол бөгөөд аюул, дарамтыг бууруулах зэрэг үр дүнг хамарна. Сайн зорилт нь тодорхой, хэмжигдэхүйц, хүрэх боломжтой, үр дүнд чиглэсэн, мөн хугацаатай (SMART) байх шалгуурыг хангана. Хэрэв төсөл ойлголтын болон загварчлалын хувьд сайн боловсруулагдсан бол зорилтууд биелснээр төслийн зорилгод хүрч, улмаар түүний алсын харааг хэрэгжүүлэхэд хүргэнэ. Алсын хараа болон зорилготой харьцуулж үзнэ үү.

**Үйл ажиллагааны төлөвлөгөө** – Төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүжилт болон чадавхийн хэрэгцээ, эрсдэл, нийгмийн хамгааллын арга хэмжээ, мөн урт хугацааны тогтвортой байдлыг хэрхэн хангахыг тодорхойлсон байгаль хамгааллын төлөвлөгөөний нэг хэсэг.

**Боломж** – Нөхцөл байдлын шинжилгээнд тодорхойлогдсон, нэг буюу хэд хэдэн хамгаалах үнэт зүйлд шууд болон/эсвэл шууд бусаар эерэг нөлөө үзүүлэх боломжтой нөлөөлөгч хүчин зүйл. Ихэвчлэн байгаль хамгааллын үйл ажиллагааг эхлүүлэх гол цэг болдог (жишээлбэл, тогтвортой аргаар бэлтгэсэн модон бүтээгдэхүүний эрэлт). Зарим талаараа аюул дарамтын эсрэг ойлголт гэж үзэж болно.

**Үр нөлөө** – Өөрчлөлтийн онол дахь тодорхой нэг хүчин зүйлийн ирээдүйн төлөв байдал. Зарим мэргэжилтнүүд дунд хугацааны үр нөлөө (богино хугацааны зорилттой холбоотой завсрын үр дүн) болон эцсийн үр нөлөө (төслийн зорилгод тодорхойлогдсон нөлөөлөл, *impact*)-г ялган авч үздэг.

**Үр дүн** – Үйл ажиллагаа эсвэл даалгаврын шууд үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, эсвэл хүрэх үр дүн бөгөөд хэрэгжүүлэгч байгууллагын шууд хяналтад байдаг.

**Түнш** – Төсөл эсвэл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож, дэмжлэг үзүүлж буй хувь хүн, бүлэг, эсвэл байгууллага.

**Амсхийх, эргэцүүлэн тунгаах** – Дасан зохицох менежментийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд төслийн баг хэрэгжүүлсэн арга хэмжээ, гарсан үр дүнг дүгнэж шинжилсний үндсэн дээр шаардлагатай тохиолдолд стратеги, үйл ажиллагаагаа нийцүүлэн сайжруулах үйл явц.

**Мэргэжилтнүүд** – Байгаль хамгааллын төсөл, хөтөлбөрийг төлөвлөх, удирдах, мониторинг хийх үйл ажиллагаанд оролцож буй хүмүүс.

**Дарамт** – Төслийн оролцогч талууд өөрсдийн арга хэмжээг “аюул дарамт” гэж нэрлэхэд сөргөөр хандаж болзошгүй нөхцөлд ашиглахад тохиромжтой нэр томъёо.

**Хөтөлбөр (санаачлага)** – Тодорхой нэг зорилгод хүрэхээр боловсруулсан уялдаа холбоотой хэд хэдэн төслүүд эсвэл стратегийн цогц. Хөтөлбөрийг илүү өргөн цар хүрээтэй төсөл гэж ойлгож болохоос гадна хамаарах төслүүдийг удирдах, санхүүжүүлэх, эсвэл тэдгээрээс суралцах үйл ажиллагааны нэгж гэж үзэж болно. Нэр томъёоны хэрэглээг энгийн байлгах зорилгоор энэ аргачлалд “төсөл” гэсэн нэр томъёог төсөл болон хөтөлбөрт ийг адил тэгш илэрхийлэхэд ашигласан буюу аль алинд нь адилхан үйлчилнэ. Төсөл-тэйхарьцуулан үзнэ үү.

**Төсөл** – Тодорхой зорилго, зорилгод хүрэхийн тулд менежер, судлаач, олон нийтийн төлөөлөл болон бусад оролцогч талуудаас бүрдсэн мэргэжилтнүүдийн багийн хэрэгжүүлж буй стратегиудийн цогц. Хөтөлбөртэй харьцуулан үзнэ үү.

**Төслийн баг** – Төслийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах үүрэгтэй мэргэжилтнүүдээс бүрдсэн баг. Энэ багт менежер, судлаач, үйл ажиллагааны ажилтнууд болон бусад гол хэрэгжүүлэгчид, оролцогч талуудын төлөөлөл багтаж болно.

**Нийгмийн төлөв** (сэтгэлзүйн болон нийгмийн) – Хүмүүс яагаад тодорхой дадал, зан үйл хийдгийг тодорхойлдог итгэл үнэмшил, хандлага, мэдрэмж болон бусад танин мэдэхүйн төлвүүдийн тухай.

**Үр дүн (outcome)** – Өөрчлөлтийн онолд тодорхойлогдсон хүчин зүйлийн ирээдүйд хүрэхийг зорьсон төлөв. Ихэвчлэн “дунд хугацааны үр дүн”-гийн товчилсон хэлбэрээр илэрхийлэгддэг, мөн хамгаалах үнэт зүйлийн хүссэн нөхцөл байдлыг ч илэрхийлж болно.

**Үр дүнгийн хэлхээ (theory of change diagram, strategy pathway)** – Тодорхой нэг стратегийн өөрчлөлтийн онолыг дүрслэн харуулсан диаграм. Энэ нь төслийн үйл ажиллагаа → хүлээгдэж буй дунд хугацааны үр дүн → эцсийн зорилго буюу хамгаалах үнэт зүйлийг шалтгаан-үр дагаврын дарааллаар холбож үзүүлдэг. Мөн гол таамаглалуудыг илэрхийлэхэд ашиглагддаг.

**Эрх эзэмшигч** – Тухайн нутаг дэвсгэр дэх газар, ус болон/эсвэл байгалийн нөөцийг хууль ёсоор болон уламжлалт заншлын дагуу өмчлөх, ашиглах эрхтэй

хувь хүн эсвэл бүлэг. Нөлөөлөлд өртөх бүс нутагт хэрэгжиж буй төсөлтэй холбогдсон бүх эрхийн эзэмшигчид нь сонирхогч талд тооцогдох боловч бүх сонирхогч тал заавал эрхийн эзэмшигч байдаггүй.

**Эрсдэл** – Ямар нэг үйл явдал тохиолдон төслийн зорилго, зорилгод хүрэх явц болон оролцогч талуудын ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх магадлал. Эрсдэлийг ихэвчлэн тухайн үйл явдал болох магадлал болон түүний үр дагаврын ноцтой байдлын хослолоор илэрхийлдэг.

**Үндсэн шалтгаан** – Нөхцөл байдлын шинжилгээнд ашиглагддаг хүчин зүйл. Үндсэн шалтгаан нь ихэвчлэн нөлөөлж буй хүчин зүйлтэй адил утгатай бөгөөд асуудал үүсэхэд шууд болон дам нөлөө үзүүлдэг гол эх сурвалжийг илэрхийлдэг.

**Хамрах хүрээ** – Төслийн газарзүйн эсвэл тухайлсан сэдвийн цар хүрээ. Хамрах хүрээ нь төсөл ямар асуудал, нөхцөлд нөлөөлөхийг тодорхойлдог боловч заавал тухайн газар нутагт үйл ажиллагаа явагдана гэсэн үг биш.

**Нөхцөл байдлын дүн шинжилгээ** – Төслийн баг болон хамтрагч талуудад төслийн талаар нийтлэг ойлголт бий болгоход чиглэсэн үйл явц. Үүнд биологийн орчин, нийгэм, эдийн засаг, улс төр, байгууллагын тогтолцоо болон хамгаалах үнэт зүйлд нөлөөлдөг холбогдох оролцогч талуудын уялдаа холбоог багтаан авч үздэг.

**Нөхцөл байдлын загвар (ойлголтын загвар)** – Нөхцөл байдлын шинжилгээг дүрслэн харуулсан диаграм. Энэ загвар нь нөхцөл байдлын шинжилгээнд тодорхойлогдсон гол хүчин зүйлүүд хоорондын харилцаа, уялдаа болон тэдгээр нь хамгаалах үнэт зүйлд хэрхэн нөлөөлж байгааг харуулдаг. Сайн загвар нь хамгаалах үнэт зүйлийг тэдгээрт учирч буй аюул, дарамт, боломж болон гол оролцох цэгүүдтэй уялдуулан холбож харуулдаг.

**Нийгмийн хамгааллын арга хэмжээ** – Хувь хүн, олон нийтийг сөрөг нөлөөллөөс хамгаалахад чиглэсэн бодлого, арга хэмжээ. Ялангуяа байгаль хамгаалал, хөгжлийн төсөл, бодлого, нийгмийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгждэг. Эдгээр нь эмзэг болон гадуурхагдсан бүлгийн эрх ашиг, сайн сайхан байдал, ашиг сонирхлыг хамгаалах зорилготой.

**Стратегийн төлөвлөгөө** – Байгаль хамгааллын төлөвлөгөөний нэг хэсэг бөгөөд төслийн хамрах хүрээ, нөхцөл байдал, стратеги, мөн арга хэмжээг хэрхэн зорилго, зорилгод хүрэхийг тайлбарладаг.

**Стратеги** – Нэг буюу хэд хэдэн *арга хэмжээ*, тэдгээртэй холбоотой *үйл ажиллагаа*, *үр дүн*, *зорилт* болон *хамгаалах үнэт зүйл*, *зорилгыг* багтаасан цогц арга замыг хэлнэ. Ихэвчлэн *өөрчлөлтийн онолд* дүрслэгддэг.

**Тайлбар:** 5.0 хувилбарт “стратеги” гэсэн өмнөх нэр томъёог “арга хэмжээ” гэж өөрчилсөн. Одоо “арга хэмжээ” нь одоо илүү өргөн хүрээтэй стратегийн нэг бүрэлдэхүүн хэсэг гэж ойлгогдоно.

**Дарамт** – *Хамгаалах үнэт зүйлийн* доройтсон шинж чанар бөгөөд хүний үйл ажиллагааны шууд болон шууд бус нөлөөллөөс үүсдэг. Жишээ нь: амьтны тоо толгой багасах, төрөлтийн түвшин буурах (зүйлийн хувьд), эсвэл голын урсгал багасах, тунамал ихсэх (экосистемийн хувьд). Ерөнхийдөө *экологийн гол хүчин зүйл* доройтохтой адил бөгөөд *биофизикийн хүчин зүйлийн* нэг төрөл юм.

**Зорилтот түвшин** – Төслийн багийн хүрэхээр төлөвлөсөн *үзүүлэлт*, хэмжүүрийн ирээдүйн хүссэн утга эсвэл түвшин. Энэ нь ихэвчлэн SMART *зорилго*, *зорилтын* тоон болон чанарын хэмжигдэхүүн байдаг.

**Тайлбар:** 5.0 хувилбарт “зорилтот түвшин” гэсэн нэр томъёог өмнө нь ашиглаж байсан “системийн хүчин зүйл” гэсэн утгаас өөрчилсөн. Энэ өөрчлөлт нь Биологийн олон янз байдлын конвенц болон олон улсын бусад байгууллагын хэрэглээтэй нийцүүлэх зорилготой. Жишээ нь: “30 x 30 зорилт” буюу 2030 он гэхэд дэлхийн нийт хуурай газрын 30%-ийг хамгаалах *зорилт*.

**Зорилтот бүлэг** – Төслийн багийн мэдээлэл өгөх, нөлөөлөхийг зорьж буй тодорхой хүмүүсийн бүлэг. Энэ бүлэгт *шууд аюул*, *дарамт* учруулж буй эсвэл нөлөөлж буй хүмүүс (жишээ нь: хууль бус загасчид,

фермер, бодлого боловсруулагчид) багтахоос гадна төслийг дэмжигчид (жишээ нь: түншүүд, хандивлагчид, олон нийт) ч орж болно.

**Даалгавар** – Нэг *үйл ажиллагаа*, *хяналтын ажил* эсвэл *ажлын төлөвлөгөөний* бусад бүрэлдэхүүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тодорхой ажил.

**Өөрчлөлтийн онол** – Төслийн багийн үйл ажиллагаа нь хэрхэн *дунд хугацааны үр дүн* болон *эцсийн нөлөөлөлд* хүрнэ гэж үзэж буй шалтгаан-үр дагаврын холбоотой *таамаглалын* цогц. Өөрчлөлтийн онолыг текст, зураг (жишээ нь: *үр дүнгийн гинжин холбоо*), эсвэл бусад хэлбэрээр илэрхийлж болно.


**Аюул, дарамт** – *шууд болон шууд бус аюул*, *дарамтыг* харна уу. Мөн *дарамт* (Stress) гэсэн тодорхойлолтыг үзнэ үү.

**Үнэт зүйл** – “*Хамгаалах үнэт зүйл*”-ийн тодорхойлолтыг үзнэ үү.

**Алсын хараа** – Төслийн *хамрах хүрээтэй* холбоотойгоор хүсэж буй ирээдүйн төлөв, эцсийн зорилгыг тодорхойлсон дүрслэл. Сайн алсын хараа нь ерөнхий, урам зориг өгөхүйц, товч тодорхой байх ёстой.

**Гүйцэтгэлийн төлөвлөгөө** – *Байгаль хамгааллын төлөвлөгөөний* нэг хэсэг бөгөөд *стратеги*, *мониторинг*, *үйл ажиллагааны төлөвлөгөөг* хэрэгжүүлэх *төлөвлөгөө*. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үйл ажиллагаа, даалгавар, хариуцсан хүн, хугацаа зэргийг жагсаадаг. Мөн төсөвтэй холбон харуулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай зардал, нөөцийг тодорхойлдог.

## Өөрчлөлтийн онолын диаграм түүний тайлбар



## Хүртээмжтэй байгаль хамгааллын нэр томъёоны дэлгэрэнгүй

**Олон янз байдал** - Нийгмийн орчинд байгууллага, төсөл, хөтөлбөрт оролцож буй хүмүүсийн ялгаатай байдал, туршлага, үзэл бодол. Үүнд арьс өнгө, угсаа гарал, бэлгийн чиг баримжаа, хүйс, хөгжлийн бэрхшээл, уугуул гарал, нас, соёл, шашин, нийгэм-эдийн засгийн байдал, гадаад төрх, хэл, аялга, боловсрол, газарзүй, иргэншил, амьдралын туршлага, ажлын чиг үүрэг, зан үйлийн төрөл, сэтгэлгээний хэв маяг зэрэг багтана. Мөн байгаль хамгааллын ажилд оролцож буй бүлэг, байгууллагын олон янз байдлыг илэрхийлэхэд хэрэглэгддэг (жишээ нь: сайн дурынхан, ахмад настнууд, олон нийтийн төлөөлөгчид).

**Тэгш байдал** - Бүх хүнд шударга хандах, тэгш боломж, хүртээмжийг хангахын зэрэгцээ түүхэн уламжлалаар зарим бүлгийг хохироож ирсэн саад бэрхшээлийг илрүүлж, арилгахыг зорьдог ойлголт. Тэгш хүртээмжтэй байдал нь хүмүүсийн хэрэгцээ өөр өөр байдаг тул ижил үр дүнд хүрэхийн тулд өөр өөр арга зам шаардлагатайг хүлээн зөвшөөрдөг. Энэ нь хүн бүр ижил гараанаас эхэлдэггүйг ойлгож, шударга байдлыг хангахын тулд тохируулга хийх шаардлагатайг онцолдог. Практикт тэгш байдлыг бий болгохын урьдчилсан нөхцөл.

**Урьдчилсан, мэдээлэлтэй зөвшөөрөл** - Нэг үйл ажиллагаа нь хувь хүн эсвэл олон нийтэд эерэг болон сөрөг нөлөө үзүүлэхээс өмнө тухайн хүн эсвэл олон нийт уг үйл ажиллагааг зөвшөөрөх ёстой гэсэн зарчим. Гэхдээ зөвшөөрөл нь тухайн үйл ажиллагааны талаар бүрэн мэдээлэлтэй байх ёстой, эс бөгөөс зөвшөөрөл утгагүй болно ("мэдээлэлтэй"). Зөвшөөрлийг үйл ажиллагаа эхлэхээс өмнө өгөх ёстой ("урьдчилсан"). Мөн зөвшөөрөл нь ямар нэгэн дарамт шахалтгүй, чөлөөтэй өгөгдөх ёстой ("чөлөөт").

**Оролцоо** - Бүх хүн өөрийгөө хүлээн зөвшөөрөгдсөн, үнэлэгдсэн, хүндлэгдсэн, бүрэн хувь нэмрээ оруулах боломжтой гэж мэдрэх орчныг бүрдүүлэх үйл явц. Оролцоог дэмжсэн байгаль хамгаалал нь олон янзын бүлгийн (ялангуяа орон нутгийн болон уугуул иргэдийн) эрх, хэрэгцээ, алсын хараа, дуу хоолой, манлайллыг хүлээн зөвшөөрч, дэмждэг. Энэ нь олон янзын хүмүүсийг байгууллага, олон нийтийн бүх үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулахыг хамардаг. Олон янз байдал нь төлөөлөлтэй холбоотой

бол оролцоо нь тэднийг үнэлж, хувь нэмрийг нь бодитоор хүлээн зөвшөөрөх соёлыг бий болгох тухай юм.

**Сонирхогч тал** (Оролцогч тал) - Төслийн үйл ажиллагаанд шууд болон шууд бус байдлаар нөлөөлөх, эсвэл төслийн үр дүнд ашиг хүртэх, хохирол амсах магадлалтай хувь хүн, бүлэг, байгууллага. Сонирхогч талууд нь төслийн зорилгод хүрэхэд зайлшгүй тооцох шаардлагатай бөгөөд тэдний оролцоо, дэмжлэг нь амжилтад чухал нөлөөтэй. "Сонирхогч" гэдэг нь тухайн тал төслийн ажилд нөлөөлөх, эсвэл нөлөөлөлд өртөх боломжтойг илэрхийлдэг бөгөөд заавал идэвхтэй оролцож байгаа эсвэл мэдэж байгаа гэсэн үг биш. Сонирхол нь санхүүгийн, ёс суртахууны, хууль эрх зүйн, хувийн, олон нийтийн байж болох бөгөөд шууд болон шууд бус хэлбэртэй байж болно.

**Шударга ёс** - Боломж, нөөцийг шударга, ёс зүйтэйгээр хуваарилах шийдвэр гаргах үйл явц. Шударга ёс нь зөвхөн тэгш байдлыг хангахаас илүү, тогтолцооны тэгш бус байдал, ялгаварлан гадуурхах үзэгдлийг арилгахыг зорьдог. Үүнд ялгааг бий болгож буй бүтэц, бодлого, дадлыг өөрчлөх, урт хугацааны нийгмийн өөрчлөлтийг дэмжих орно. Байгаль хамгаалалд шударга ёсны хандлага нь сонирхогч талуудыг тэгш, оролцоотойгоор хүлээн авч, тэднийг аюулгүй, итгэлтэйгээр оролцуулах нөхцөлийг бүрдүүлэхийг хэлнэ. Мөн төлөвлөлт, хэрэгжилтэд олон янзын төлөөллийг нэмэгдүүлэхийг шаарддаг.

**Нийгмийн хамгааллын арга хэмжээ** - Байгаль хамгаалал болон хөгжлийн төсөл, бодлого, нийгмийн хөтөлбөрийн хүрээнд хувь хүн, олон нийтийг сөрөг нөлөөллөөс хамгаалах бодлого, арга хэмжээ. Эдгээр нь эмзэг болон гадуурхагдсан бүлгийн эрх, сайн сайхан байдал, ашиг сонирхлыг хүндэтгэж, хамгаалахад чиглэдэг.

# ХАВСРАЛТ 2. ҮНДСЭН НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ, ШАЛГУУР

## Үндсэн нэр томъёоны тайлбар

**Алсын хараа** - Төслийн хүрээнд хүрэхийг зорьж буйрээдүйн төлөв буюу эцсийн зорилгыг илэрхийлсэн ерөнхий тодорхойлолт

- **Харьцангуй ерөнхий** - Төслийн бүх үйл ажиллагааг хамрахуйц өргөн агуулгатай байх.
- **Алсын хараатай** - Хамгаалах үнэт зүйлийн ирээдүйн төлөв байдлын өөрчлөлт нь итгэл, найдвар төрүүлэхүйц байх.
- **Товч** - Бүх оролцогчид санаж, ойлгоход хялбар, энгийн бөгөөд цэгцтэй байх.

**Зорилго** - Төслийн зорьж буй үр дүнг тодорхойлсон албан ёсны томъёолол буюу хамгаалах үнэт зүйлийн ирээдүйн хүссэн төлөв байдлыг илэрхийлнэ.

**Зорилт** - Төслийн хүрээнд хүрэхийг зорьж буй дунд хугацааны үр дүнг тодорхойлсон албан ёсны томъёолол. Жишээ нь: аюул, дарамтыг бууруулах зэрэг үр дүнг хамарна. Сайн зорилго, зорилт нь дараах SMART шалгуурыг хангах ёстой:

- **Тодорхой:** Бүх оролцогчид юуг илэрхийлж байгааг нэгэн адил ойлгохоор тодорхой томъёологдсон байх
- **Хэмжигдэхүйц:** Ямар нэгэн стандарт хэмжээсээр тодорхойлох боломжтой байх (тоо, хувь, хэсэг, эсвэл "тийм/үгүй" төлөв байдал).
- **Хүрч болохуйц:** Төслийн нөхцөл байдалд нийцсэн, бодитой хэрэгжихүйц бөгөөд улс төр, нийгэм, санхүүгийн орчныг харгалзан үзсэн байх (ялангуяа зорилтын хувьд; зорилго нь илүү алсын хараатай байж болно)
- **Үр дүнд чиглэсэн:** Хамгаалах үнэт зүйлийн төлөв байдлын өөрчлөлт аюул, дарамтыг бууруулах, эсвэл бусад гол үр дүнг илэрхийлсэн байх.
- **Хугацаатай:** Тодорхой хугацааны дотор хүрч болохуйц байх. Ерөнхийдөө зорилт нь 1–10 жилд, зорилго нь 10–20 жилд биелэгдэхээр төлөвлөгдөнө.

**Арга хэмжээ** - Нэг зорилго, зорилтод хүрэхийн тулд тодорхой нэг асуудлуудад чиглэсэн, боломжуудыг

оновчтой ашиглаж, хязгаарлалтыг багасгах зорилготой харилцан уялдаатай цогц үйл ажиллагаа.

- **Уялдаа холбоотой** - Нөхцөл байдлын дүн шинжилгээ (эсвэл загвар)-ний нэг буюу хэд хэдэн хүчин зүйлд шууд нөлөөлөх.
- **Төвлөрсөн** - Хэрэгжүүлэх шаардлагатай тодорхой үйлдлүүдийг зааж өгсөн.
- **Хэрэгжих боломжтой** - Төслийн нөөц боломж, хязгаарлалтыг харгалзан үзэхэд бодитоор хэрэгжүүлэх боломжтой.
- **Зохистой** - Тухайн газар нутгийн соёл, нийгэм, биологийн хэм хэмжээнд нийцсэн, хүлээн зөвшөөрөгдөхүйц байх, (нийгмийн болон байгаль орчны хамгааллын асуудлуудыг харгалзсан).

**Шалгуур үзүүлэлт:** Тодорхой мэдээллийн хэрэгцээтэй холбоотой хэмжигдэхүүн. Жишээ нь: хамгаалах үнэт зүйлийн төлөв байдал, аюул, дарамтын өөрчлөлт, зорилго/зорилтод хүрэх ахиц дэвшил, эсвэл нэг буюу хэд хэдэн хувьсагч хоорондын хамаарал.

- **Хэмжигдэхүйц:** Тоон болон чанарын хэмжүүрээр бүртгэж, шинжлэх боломжтой.
- **Нарийн тодорхой:** Бүх оролцогчид ижил утгаар ойлгохоор тодорхойлсон.
- **Тогтвортой:** Цаг хугацааны явцад өөрчлөгдөхгүй, үргэлж ижил зүйл хэмждэг.
- **Мэдрэмтгий:** Өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэхүйц.

**Аргачлал:** Шалгуур үзүүлэлтийг хэмжихийн тулд мэдээлэл цуглуулах тодорхой арга техник.

- **Нарийвчлалтай:** Өгөгдөл цуглуулах аргачлал нь алдаа гарах магадлал маш бага, эсвэл огт байхгүй байх.
- **Найдвартай:** Давтан хэрэглэхэд тогтмол ижил үр дүн гаргадаг.
- **Өртөг багатай:** Зардал нь түүгээр гарч буй өгөгдлийн ач холбогдол болон боломжит нөөцтэй харьцуулахад зохистой байх
- **Хүрч болохуйц:** Төслийн багийн гишүүд хэрэгжүүлэх боломжтой.
- **Зохистой:** Тухайн газар нутгийн соёл, нийгэм, биологийн хэм хэмжээнд нийцсэн.

# ХАВСРАЛТ 3. ЕРӨНХИЙ ЗАРЧИМ, АНХААРАХ АСУУДЛУУД

Байгаль хамгааллын стандартын алхмуудад мөрдөх ерөнхий зарчим, анхаарах асуудлууд бий. Тэдгээрийг энд нэгтгэн тайлбарлав.

## Ерөний зарчим

- **Түншүүдтэй хамтран ажиллах** – Байгаль хамгааллын нэг байгууллага тухайн төлөвлөлтийн хүрээнд хийх шаардлагатай бүхий л ажлыг гүйцэтгэхэд хангалттай туршлага, дотоод нөөц бололцоотой байх магадлал бага. Үүнээс гадна, төлөвлөгөө хэрэгжиж дууссаны дараа ч түүний хүрээнд эхлүүлсэн ажил үргэлжлэн хэрэгжих нь чухал. Иймээс тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй хамтрагч талуудыг тодорхойлон, тэдэнтэй албан болон албан бус хамтын ажиллагаа, харилцаа тогтоох, мөн тэдний төлөөллийг төлөвлөлтийн багт оролцуулах замаар хамтран ажиллах хэрэгтэй. Байгаль хамгааллын стандарт нь талуудын хооронд мэдээллийг үр дүнтэй солилцох, хамтын ажиллагааг дэмжих нийтлэг, ил тод зарчмуудыг тодорхой тусгасан байдаг.



PHOTO: SARA ESTLANDER

- **Оролцогч талуудыг аль болох эрт бөгөөд бүрэн оролцуулах** – Оролцогч талуудыг тодорхойлон, алхам тутамд татан оролцуулах нь нэн чухал. Оролцогч тал гэдэгт аливаа үйл ажиллагаанд ашиг сонирхол нь шууд болон шууд бусаар хамаарах, эсвэл нөлөөлөх боломжтой, мөн нөхцөл байдал өөрчлөгдөх эсвэл хэвээр үлдэхээс шалтгаалан ашиг хүртэх эсвэл хохирол амсах магадлалтай хувь хүн, бүлэг, эсвэл байгууллагуудыг хамруулна. Үйл ажиллагааны явцад оролцогч талуудын үүрэг, оролцоо өөрчлөгдөж болох бөгөөд төлөвлөх, хэрэгжүүлэх, шийдвэр гаргах алхам бүрт холбогдох талуудтай тогтмол харилцаж, идэвхтэй оролцуулах замаар оролцоог бодитоор хангах нь зүйтэй ([Дэлгэрэнгүйг 1D-алхамаас харна уу](#)).
- **Байгаль хамгааллыг шударга, тэгш, хүртээмжтэй байдлаар хэрэгжүүлэх** – Манай гарагийн ирээдүйг аюулгүй, баталгаатай байлгахын тулд хүн бүр дуу хоолойгоо хүргэх, бодитоор оролцох боломжтой байх ёстой. Судалгаагаар олон талт байдал нь инновацыг нөхцөлдүүлдэг нь тогтоогдсон бөгөөд СМР нь байгаль хамгааллын мэргэжилтнүүдийг үр дүнтэй дэмжихийн тулд шударга, тэгш, хүртээмжтэй байгаль хамгааллыг дэмжих ёстойг онцолдог. Байгаль хамгааллын стандартад төлөвлөлт, хэрэгжилт зэрэг бүх алхамд талуудын оролцоог бүрэн хангах стратегийн түвшний зарчмуудыг тусгасан байдаг. Цогц байдлаар хэрэгжсэн байгаль хамгаалал нь илүү баталгаатай, урт хугацаанд тогтвортой үр дүнг бий болгодог. Энэ зарчим нь бүхнийг бүрэн хамруулах зорилготой бус бөгөөд нийгэм, эдийн засгийн нөхцөлд ямар арга үр дүнтэй, аль нь үр дүнгүйг дасан зохицох менежментийн хандлагаар тодорхойлох нь чухал юм.

- **Нотлох баримт бүрдүүлж зохих ёсоор ашиглах** – Нөхцөл байдал, үйл ажиллагаатай холбоотой гол асуултад хариулахын тулд орон нутгийн болон дэлхийн түвшинд байгаа боломжит нотолгоо, баримт мэдээллийг ашиглах хэрэгтэй. Эдгээр нь тодорхой нэг зүйлийн үржлийн бүс нутгийн талаарх нутгийн иргэдийн мэдлэгээс эхлээд санал болгож буй байгаль хамгааллын арга хэмжээний үр нөлөөг үнэлсэн дэлхийн түвшний системчилсэн судалгааг хамарч болно. Үйл ажиллагааны явцад илүү их мэдлэг, туршлага хуримтлуулахын хэрээр өөрийн олж авсан нотолгоо, сургамж, туршлагаа хуваалцаж, бусад нь таны туршлагаас суралцан, үр ашиг хүртэх боломжийг бүрдүүлэх хэрэгтэй (дэлгэрэнгүйг [CMP-ээс гаргасан “Defining and using evidence in conservation practice”-аас үзнэ үү](#)).
- **Тодорхойгүй нөхцөл байдалд дасан зохицох менежментийн зарчмыг ашиглах** – Нөхцөл байдлын дүн шинжилгээ, төлөвлөж буй арга хэмжээг аль болох зохих нотолгоонд тулгуурлан боловсруулах нь зүйтэй. Ихэнх тохиолдолд хангалттай мэдээлэл байхгүй ч яаралтай арга хэмжээ авах шаардлага тулгардаг. Ийм үед таамаглалаа тодорхой дэвшүүлээд, тэдгээрийг шалгахад шаардлагатай мэдээллийг системтэйгээр (гэхдээ үр дүнтэй) цуглуулж, үнэлж, улмаар дасан зохицож, суралцах нь чухал.
- **Шийдвэрээ баримтжуулах** – Нотолгоонд суурилсан байгаль хамгаалал болон дасан зохицох менежментийн гол зарчим нь алхам бүрт гаргасан шийдвэрийн үндэслэл, нотолгоог зохих ёсоор бүртгэн баримтжуулах явдал юм. Энэ нь юу үр дүнтэй, юу үр дүнгүй байсанд дүн шинжилгээ хийхэд туслахаас гадна бусад хүмүүст таны сонголтыг ойлгох, хянах, санал, дүгнэлт өгөх боломжийг олгодог. Шийдвэрээ баримтжуулж, таамаглалаа баталгаажуулах нотолгоо гаргаж өгөх нь ажлын ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлдэг. Гэсэн хэдий ч баримтжуулалтад хэт их цаг зарцуулж, багийн гишүүдийн ачааллыг нэмэх нь зохимжгүй. Зарчмын хувьд, төлөвлөлтийн баг өөрсдийн ажлаа зүй зохистой үнэлж дүгнэн, бусадтай хуваалцахад тус болох хамгийн энгийн, бодит баримт бүрдүүлэхэд анхаарлаа төвлөрүүлэх нь зүйтэй.
- **Суралцах орчныг төлөвшүүлэх** – Нотолгоонд суурилсан байгаль хамгаалал, дасан зохицох менежментийн бас нэг зарчим бол үр дүнгээсээ суралцаж, ажлаа сайжруулж байх явдал юм. Үүний тулд суралцах хандлагыг төлөвшүүлэх, алдаа, оноогоо хүлээн зөвшөөрч, амжилтаа тодорхойлон, аль нь яагаад үр дүнгүй байсныг ойлгохыг

зорих нь нэн чухал. Суралцахуйн үнэ цэнийг эрхэмлэдэг байгууллагын соёл нь үр дүнтэй суралцах орчныг бүрдүүлэхэд чухал нөлөөтэй. Ийм соёлыг төлөвшүүлэхийн тулд бүх түвшний түнш байгууллагуудын хамтын ажиллагаа, тууштай хүчин чармайлт шаардлагатай.

## Анхаарах асуудлууд

Байгаль хамгааллын стандартыг хэрэгжүүлэхдээ дараах зүйлсийг анхаарна уу.

- **Байгаль хамгааллын стандарт нь цаг хугацааны явцад өөрчлөгдөнө** – Энэ стандарт нь үр дүнтэй байгаль хамгааллыг хэрхэн хэрэгжүүлэх талаарх эцсийн, өөрчлөгдөшгүй заавар биш юм. Харин янз бүрийн нөхцөл байдалд хамгааллыг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар хуримтлуулсан мэдлэг, туршлага, ойлголтыг тусгах зорилготой. Иймээс CMP нь байгаль хамгааллын мэргэжилтнүүдийн оролцоо, саналд тулгуурлан Байгаль хамгааллын стандартыг бодит нөхцөлд хэрэгжүүлэн турших явцад юу үр дүнтэй, юу үр дүнгүй талаарх мэдлэг нэмэгдэхийн хэрээр тэдгээрт суурилан тогтмол сайжруулж, шинэчилдэг. Шинэчлэлд оролцохыг хүсвэл [CMPinfo@conservationmeasures.org](mailto:CMPinfo@conservationmeasures.org) хаягаар бидэнтэй холбогдоно уу.
- **Байгаль хамгааллын стандарт нь “хамгийн тохиромжтой” загварыг илэрхийлдэг** – Энэ стандарт нь байгаль хамгааллын төлөвлөлт, менежмент, хяналт-мониторингийн сайн туршлагыг багтаасан цогц ойлголт өгөхийг зорьдог. Гэхдээ янз бүрийн шалтгаанаас үүдэн стандартын бүх алхмыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй байх тохиолдол гарч болохыг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй. Хамгийн гол нь тэдгээрийг системтэй, логик дараалалтайгаар баримтлах явдал юм. Тухайлбал, юуг хамгаалахыг зорьж байгаагаа тодорхойлохоос (**1B алхам**) өмнө шалгуур үзүүлэлтүүдээ (**2B алхам**) тодорхойлох ёсгүй. Үүний нэгэн адил, стандартын тодорхой нэг алхмыг хэрэгжүүлэх боломжгүй бол энэ нь таны бусад ажилд хэрхэн нөлөөлөхийг тодорхой тайлбарлах шаардлагатай.
- **Зарим тэргүүлэх чиглэлийг урьдчилан тодорхойлсон** – Хаана ажиллах, эсвэл хэр өргөн хүрээний асуудлыг авч үзэх вэ гэсэн шийдвэр нь ихэвчлэн байгаль хамгааллын төлөвлөлтийн өмнө, дээд түвшинд гарсан байдаг. Ийнхүү та болон танай байгууллага ерөнхий байдлаар тэргүүлэх чиглэлээ тодорхойлсон байх нь Байгаль хамгааллын стандартыг хэрэглэх урьдчилсан нөхцөл хэмээн үзнэ. Байгаль хамгааллын стандартыг хэрэгжүүлэх явцад хуримтлуулсан мэдлэг, туршлага, сургамж нь цаашдын тэргүүлэх чиглэлийг тогтооход суурь болдог.

- **Цөөн тооны төслүүд Байгаль хамгааллын стандартыг эхнээс нь хэрэгжүүлдэг** – Хэрэв та шинэ төсөл эхлүүлэх гэж байгаа бол Байгаль хамгааллын стандарт танд эхнээс нь цогц төлөвлөлт хийхэд тусална. Гэвч энэхүү стандартаас үр ашиг хүртэх боломжтой олон төслүүд аль хэдийн хэрэгжилтийн шатандаа орсон байдаг. Стандартыг одоогийн нөхцөл байдалдаа тохирсон алхамаас эхлэн хэрэгжүүлж болох бөгөөд шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөнийхөө сул буюу сайжруулах шаардлагатай талыг тодорхойлох зорилгоор хэрэглэж болно.
- **Байгаль хамгааллын стандартыг өөрийн нөхцөлд нийцүүлэн тохируулах боломжтой** - Байгаль хамгааллын стандартыг төлөвлөлтийн баг бүр өөрийн нөхцөл байдалд тохируулан уян хатан байдлаар хэрэглэж, хэрэгцээндээ нийцүүлэн өөрчлөх боломжтой байхаар боловсруулсан. Стандартын алхмууд нь байгаль хамгааллын бүх төсөлд хамаарах боловч, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог, хөрөнгө, нөөцөөс шалтгаалан баг бүр өөрийн нөхцөлд нийцүүлэн тодорхой түвшинд хэрэгжүүлэх нь зүйтэй. Мөн зарим багийн хувьд тодорхой алхмууд нь тухайн нөхцөлд нийцэхгүй байж болох бөгөөд ийм тохиолдолд тэдгээр алхмуудыг өөрийн нөхцөлд тааруулан өөрчлөх шаардлага гарч болно.
- **Стандарт нь орон зайн, байгууллагын болон/эсвэл цаг хугацааны аливаа түвшний төлөвлөлтөд хамаарна** – Төлөвлөлт нь жижиг хэмжээтэй газрын менежментээс эхлэн эко бүс нутаг, ландшафт, экологийн коридор зэрэг өргөн хүрээтэй газар нутгийг хамарч болно. Мөн томоохон үр дүнд хүрэхийн тулд жижиг хэмжээтэй газрын менежментэд зэрэгцүүлэн хэрэгжүүлэх тохиолдол ч бий. Төлөвлөгөө хэрэгжих хугацаа нь хэдхэн долоо хоногоос эхлээд олон арван жил үргэлжлэх хүртэл янз бүр байж болно. Түүнчлэн, бодлогын түвшинд аюул, дарамтыг бууруулах, эсвэл тодорхой нэг зүйлийг хамгаалахад чиглэсэн санаачилга зэрэг сэдэвчилсэн шинжтэй байж болно. Эдгээр бүх нөхцөлд Байгаль хамгааллын стандарт нь ижил хэмжээнд ашиглагдах боломжтой. Мөн стандартыг санхүүжилтийн хөтөлбөр боловсруулах, хөтөлбөрийн зорилго болон буцалтгүй тусламж хоорондын уялдаа холбоо тодорхой болгоход ашиглаж болно. Гэхдээ байгууллагын түвшний, өргөн хүрээтэй бөгөөд тодорхой бус зорилгод чиглэсэн стратегийн төлөвлөлтөд ашиглах үед тодорхой хэмжээнд өөрчлөх шаардлага гарч болох юм.
- **Байгаль хамгааллын стандарт нь байгаль хамгааллыг гол зорилгоо болгон анхаардаг ч бусад нөхцөлд зохицуулан хэрэглэх боломжтой** - Энэхүү стандартыг биологийн олон янз байдал, байгалийн нөөцийг хамгаалах зорилго бүхий байгууллага, агентлагууд боловсруулсан бөгөөд тэдгээрт зориулагдсан. Мөн олон байгууллага хүний сайн сайхан байдалд анхаарч ажилладаг бөгөөд зарим нь хүний сайн байхан байдлыг байгаль хамгаалалтай эн зэрэгцүүлдэг бол зарим нь түүнээс ч чухал гэж үздэг. Байгаль хамгааллын стандарт нь багийн үндсэн зорилгын хувьд төвийг сахисан байр суурьтай байдаг ч тухайн баг төлөвлөлтийн эхний алхамд тодорхой болгодог. Гэсэн хэдий ч Байгаль хамгааллын стандартын хэд хэдэн алхам, хэрэгслүүд нь мөчлөгийн туршид өөр өөр зорилгыг тэргүүлэх чиглэл болгохтой холбоотой боломж болон түүний үр дагаврын талаар ил тод, тодорхой хэлэлцүүлэг өрнүүлэхэд дэмжлэг үзүүлж чадна.
- **Стандартыг байгалийн шинжлэл, нийгмийн ухаан болон зан үйл судлалын шинжлэх ухааны арга, аргачлал, зөвлөмжүүдийг ашиглан хэрэгжүүлэх боломжтой** – Энэхүү стандарт нь төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-мониторинг хийх талаар байгаль хамгааллын мэргэжилтнүүдийн хуримтлуулсан мэдлэг, туршлагын хамгийн сайн жишгийг нэгтгэн гаргах зорилготой бөгөөд суралцах соёлыг дэмжихийг зорьдог. Түүнчлэн стандартыг хэрэгжүүлэхэд үр дүнтэй нь нотлогдсон арга, хэрэгслүүдийг ашиглахыг санал болгодог ч, тухайн нөхцөл байдалд илүү тохиромжтой бусад арга, хэрэгслийг нэмж ашиглах боломжтой.
- **Стандарт нь нэр томьёог тодорхойлж, тогтмол хэрэглэхийг зорьдог** – Зорилго, зорилт, стратеги, үйл ажиллагаа, зорилтот үр дүн, үе шат, үр дүн зэрэг нэр томьёоны утга, ялгааны талаар маргаан мэргэжилтнүүдийн дунд тасралтгүй өрнөж байдаг. Байгууллага, төсөл, хувь хүний хувьд ч нэр томьёоны хэрэглээ харилцан адилгүй байдаг. Үүнд зөв хариулт гэж байхгүй. Байгаль хамгааллын стандартыг мэргэжилтнүүд нэр томьёоны талаар тодорхой бөгөөд нэгдсэн ойлголттой байх нь маш чухал гэж үздэг. Үүнийг харгалзан энэхүү стандартад ашигласан нэр томьёог анхааралтай сонгож, анх оруулсан хэсэгт тод үсгээр тэмдэглэгээ хийн, нэг утгаар хэрэглэсэн бөгөөд нэр томьёоны тайлбар хэсэгт нэгтгэн оруулсан. Нэр томьёоны тайлбарыг хийхдээ төлөвлөлт, мониторинг, үнэлгээний чиглэлээр ажиллаж буй мэргэжилтнүүдийн хэрэглээ, туршлагад үндэслэв. Байгаль хамгааллын стандарт хөгжихийн хэрээр гол зарчим, алхмуудын талаарх ойлголт, хүлээн зөвшөөрөх байдлыг нэмэгдүүлэхийн тулд зарим нэр томьёог шинэчлэх шаардлага гарч болохыг үгүйсгэхгүй (одоогийн хувилбарт орсон шинэчлэлийг [Хүснэгт 1](#)-ээс харна уу).

# ХАВСРАЛТ 4. БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН СТАНДАРТЫН АЛХАМ, ТЭДГЭЭРИЙН ХҮРЭЭНД ГАРАХ ҮР ДҮНГИЙН ТОЙМ

Дугаар нь стандартын үндсэн болон дэд алхмыг, (◇) тэмдэглэгээ нь гарах үр дүнг илэрхийлнэ. Стандартын алхам, тэдгээрийн хүрээнд гарах үр дүн нь тухайн нөхцөл байдал, онцлогт тохирохгүй байх магадлалтай бөгөөд хэрэгцээндээ нийцүүлэн өөрчилж болно.

## 1. Тодорхойлох

### 1А. Зорилго тодорхойлох & баг бүрдүүлэх

- ◇ Ажлын зорилго, шийдвэр гаргагчид, шийдвэр гаргах үйл явц болон шийдвэрийг тодорхойлох
- ◇ Оролцогч талуудыг тодорхойлон оролцоог хангахад шаарлагатай дэмжлэг үзүүлэх
- ◇ Баг бүрдүүлэх, багийн ахлагч, үндсэн болон зөвлөх гишүүдийг сонгох
- ◇ Багийн гишүүдийн одоогийн мэдлэг, ур чадвар болон чадавхижуулах хэрэгцээг тодорхойлох
- ◇ Үүрэг, хариуцлагыг тодорхойлж хуваарилах

### 1В. Хамрах хүрээ, алсын хараа, хамгаалах үнэт зүйлийг тодорхойлох

- ◇ Хамрах хүрээг тайлбарлаж газрын зурагт харуулах
- ◇ Алсын харааг тодорхойлох
- ◇ Хамгаалах үнэт зүйлийг сонгож үндэслэлийг тайлбарлах, хамгаалах үнэт зүйлийн байршлыг харуулах
- ◇ Хүний сайн сайхны төлөөх зорилт, тэдгээрт хамаарах экосистемийн үйлчилгээг тодорхойлох
- ◇ Хамгаалах үнэт зүйл бүрийн оршин тогтнох чадамж буюу төлөв байдлыг тодорхойлох

### 1С. Аюул, дарамтыг тодорхойлох

- ◇ Аюул, дарамтыг тодорхойлох, аюул, дарамт ба хамгаалах үнэт зүйлс нь газарзүйн байршлын хувьд хэрхэн огтлолцож байгааг газрын зурагт харуулах
- ◇ Уур амьсгалын биофизик (байгаль орчны) нөлөөлөл болон бусад аюул, дарамтуудын харилцан үйлчлэлийг тодорхойлох
- ◇ Аюул, дарамтыг үнэлж, эрэмбэлэх

### 1D. Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх

- ◇ Шууд бус аюул, дарамт болон боломжуудыг тодорхойлж дүн шинжилгээ хийх
- ◇ Оролцогч талууд, тэдний ашиг сонирхлыг үнэлэх
- ◇ Аюул, дарамтад нөлөөлж буй хүчин зүйлс, шалтгаан, үр дагаврын хамаарлыг илэрхийлсэн нөхцөл байдлын шинжилгээний диаграм эсвэл тайлбар хийх

## 2. Төлөвлөх

### 2А. Стратегийн төлөвлөгөө боловсруулах: Зорилго, Арга хэмжээ, Таамаглал, & Зорилт

- ◇ Хамгаалах үнэт зүйл тус бүрт зорилго, хүний сайн сайхны төлөөх зорилтуудыг тодорхойлох
- ◇ Нөлөөллийн гол цэгүүд, арга хэмжээг тодорхойлох
- ◇ Арга хэмжээг тэргүүлэх байдлаар нь эрэмбэлэх
- ◇ Арга хэмжээ болон түүнтэй холбоотой ажлууд хүлээгдэж буй үр дүнд хүрнэ гэсэн таамаглалд суурилсан өөрчлөлтийн онол
- ◇ Дунд шатны үр дүнд чиглэсэн зорилтоо тодорхойлох
- ◇ Стратегийн төлөвлөгөөг эцэслэх

### 2В. Үнэлгээ, мониторингийн төлөвлөгөө боловсруулах

- ◇ Зорилтот бүлэг, тэдгээрийн мэдээллийн хэрэгцээ, мэдээлэл харилцааны арга замыг тодорхойлох
- ◇ Шалгуур үзүүлэлт, тэдгээрийг хэмжих аргачлалыг тодорхойлох
- ◇ Үнэлгээ, мониторингийн төлөвлөгөөг эцэслэх

## 2С. Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

- ◇ Хүн, санхүү болон бусад нөөцийн үнэлгээ хийх
- ◇ Эрсдлийн үнэлгээ, эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах
- ◇ Нийгмийн хамгааллын арга хэмжээ
- ◇ Төслийн үргэлжлэх хугацааг тооцоолж шилжилтийн, үр дүнгийн тогтвортой байдлын стратегийг тодорхойлох

## 3. Хэрэгжүүлэх

### 3А. Багийн бүтэц, үйл явцыг хянах

- ◇ Багийн гишүүдийн болон бусад хамтын ажиллагааны гэрээ, дүрэм, журмыг шинэчлэх
- ◇ Талуудын оролцоог хэрхэн хангаж ажиллах талаарх мэдээлэл харилцааны стратегийг шинэчлэн боловсруулах

### 3В. Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, хугацааг төлөвлөх

- ◇ Стратеги, мониторингийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан ажил, даалгавар, хариуцагчийг нарийвчлан тодорхойлсон гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах
- ◇ Хугацааг нарийвчилан төлөвлөх

### 3С. Төсөв тооцох, боловсронгуй болгох

- ◇ Төсөв тооцох
- ◇ Боломжит санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох
- ◇ Санхүүжилт олох төсөл боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх

### 3Д. Төлөвлөгөө хэрэгжүүлэх

- ◇ Стратеги, мониторингийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх (гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах); төсөв, хугацааг анхаарч ажиллах
- ◇ Мэдээллийг хадгалах, хялбар хандах боломжтой систем бий болгох
- ◇ Мониторингийн дата, өгөгдлийг тухайн системд бүртгэн хадгалах
- ◇ Хэрэгжилтийн явцын тайланг байгууллага, санхүүжүүлэгчид болон бусад сонирхогч талуудад хүргэх

## 4. Үр дүнг үнэлэх & уялдуулах

### 4А. Өгөгдөл бэлтгэх

- ◇ Шаардлагатай мэдээ, өгөгдлийг тогтмол бүртгэж, хадгалж, боловсруулах, аюулгүй байдлыг ханган хадгалах

- ◇ Шийдвэр гаргахад ашиглах зорилгоор холбогдох мэдээ, өгөгдлийг график дүрслэлээр илэрхийлэх

### 4В. Үр дүнг шинжилж дүгнэлт гаргах

- ◇ Таамаглал, үр дүнд дүн шинжилгээ хийх
- ◇ Үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээлэл, өгөгдөлд дүн шинжилгээ хийх
- ◇ Хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэрийн бүртгэл

### 4С. Төлөвлөгөө, төсвийг тодотгох

- ◇ Стратегийн төлөвлөгөө (хамгаалах үнэт зүйл, амьдрах чадвар, аюул, дарамтын үнэлгээ, нөхцөл байдлын шинжилгээ, үр дүнгийн хэлхээг агуулсан), мониторингийн төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө, төсөв зэргийг багтаасан шинэчлэгдсэн баримт бичгүүд
- ◇ Нотолгоо, хэлэлцүүлэг, гарсан сургамж, болзошгүй эрсдэл болон тодорхой бус байдал, гаргасан шийдвэрийг баримтжуулсан бүртгэл

## 5. Хуваалцах

### 5А. Баримтжуулах

- ◇ Гол үр дүнг, хуримтлуулсан мэдлэгээ баримтжуулах

### 5В. Мэдлэгээ хуваалцах

- ◇ Оролцогч талууд, тэдний мэдээллийн хэрэгцээ, мэдээлэл хүлээн авах тохиромжтой арга хэлбэрийг тодруулах
- ◇ Багийн гишүүд, түнш болон сонирхогч талуудтай тогтмол холбоо, харилцаатай байж мэдээлэл хуваалцах
- ◇ Нотлох баримт бүрдүүлэх
- ◇ Сурталчилгааны материал боловсруулан гаргах, түгээх

### 5С. Суралцах орчинг бүрдүүлэх

- ◇ Албан болон албан бус хэлбэрээр тогтмол саналаа солилцох
- ◇ Байгаль хамгааллын туршлагаа үнэлэх, аудит хийх
- ◇ Удирдлага, ажилтнуудын зүгээс суралцах ба шинэлэг санааг дэмжих аюулгүй орчныг бүрдүүлэхэд гаргаж буй хүчин чармайлт
- ◇ Амжилт, сургамжаа дэлхийн бусад мэргэжилтгүүдтэй хуваалцах

## Төлөвлөлтийн мөчлөгийг зангидах нь



Нээлттэй стандарт (СМР-ээс боловсруулсан) нь байгаль хамгаалах ажлын үр нөлөөг илүү нэмэгдүүлэхийн тулд нийтлэг ойлголт, нэгдсэн үг хэллэг, арга зүйгээр хангахад тусална.

СМР гишүүд (2024-2025):

